

БЯМБАЖАВЫН ЦЭНДОО

ЕРЭЭД ОНЫ



ТУНГАЛАГ ТАМИР

ЭЛЭГЛЭЛ ТУУЖ

Б.ЦЭНДДОО

ЕРЭЭД ОНЫ ТУНГАЛАГ ТАМИР

ЭЛЭГЛЭЛ - ПАРОДИЯ - РАКОРҮ

Би тэнгэрийн хаяанд...



Алдарт хүмүүсийн зураг номынхоо эхний нүүрт, алдаршаагүй зохиогчийнх арын нүүрэнд хэвлэгдсээр ирсэн түүхтэй. Эл номыг бүтээгч миний бие арын хуудсанд гэрэл зургаа нийтлэхээс татгалзах шалтгаан гарсан юм. Учир нь хэд хэдэн уншигч миний урьд гарсан номын талаар ирүүлсэн "үнэт санал" "ашигтай зөвлөгөө"-ндөө:

-Ном чинь дэндүү царайлаг, чи өөрөө хэтэрхий царай муутай юм гэж дурьджээ.

Иймээс энэ удаа миний бие өөрийн шог зургийг нийтлэхээр шийдэж зураач нөхдөөсөө:

- Намайг муухайгаар шоглож зурж өгөөч гэж хүсэв. Гэтэл тэд:

-Чи угаасаа царай муутай учир байгаагаас чинь илүү муухай болгох бололцоо байхгүй. Дээр нь шог төрсөн царайг шог болгох аргагүй гэж хэлэв. Тэгэхлээр нь би:

-Тэгвэл намайг гоё болгоод уран сайхнаар зураад өгөөч гэж гуйлаа.

Тэд

-Урлагт уран сайхны хэтрүүлэл байж болдог боловч бодит байдлыг гуйвуулах нь "түүх гуйвуулахын нэг адил" хориотой хэмээн эрс татгалзлаа.

Ингээд би эцсийн эцэст өөрийн хөргийг зурахаас өөр аргагүй болов.

Энд нийтлүүлсэн зураг "Би тэнгэрийн хаяанд..." гэдэг нэртэй. Тэнгэрийн хаяан дахь өчүүхэн цэг бол би.

Түүнийг электрон микроскопоор 2 сая дахин томруулбал нэгэн сайхан залуу харагдах нь миний бие болой. Сүүлд дуулахнаа бүх юм цэгээс эхтэй ажгуу. Энэ ном ч миний уран бүтээлийн нэгэн цэг юм. Цэг томорсоор бөмбөрцөг, уран зураг болдог гэнэ. Тийм болтугай.

Өмнөтгөл

Ч.Лодойдамбын "Тунгалаг Тамир" романы баатруудтай бид дахин уулзах гэж байна. "Тунгалаг Тамирын" Итгэлт, Эрдэнэ, Төмөр гээд уншигч олны сэтгэлд хоногшсон баатрууд маань 90-ээд онд Монголд өрнөсөн ардчилал, зах зээлтэй хэрхэн учирч байгаа тухай өгүүлэх энэ элэглэл туужийг Б.Цэнддоо туурвихдаа, уг романы үйл явдал, түүнээс сэдэвлэсэн олон явган шог уншигчдын дунд байдгийг үндэс болгосон хэдий ч номынхоо үйл явдлыг зөвхөн өөрийн бодож олсон адал явдлуудаар өрнүүлжээ. Эх зохиолын олон баатрууд өөр хүнээр солигдсон ба зарим нэг шинэ баатрууд энэхүү элэглэл туужид бас орж ирсэн юм. Бүхний танил нэгэн романаас эхтэй энэхүү хошин бүтээл нь 90-ээд онд өрнөсөн монголын ардчилалын нэгэн хошин түүх болсон гэж бодож байна.

Лодойдамбын Галбадрах. 1996-01-08

Григориан тооллын нэгэн мянга есөн зуун ерээд оны август хэмээх зуны сүүл сарын эхний декад, Архангай аймгийн Их тамир сумын өмнөх засмалаар гуч орчим насны хар хүн нэлээд ачаатай бядхан чиргүүл зүүсэн хуучивтар "Газ-67" жолоодон явж байв. Элэгдэж хуучирсан торгон савхин цамцаа янз бүрийн өнгөөр олон дахин будуулсан тул анх ямар өнгөтэй байсан нь үл мэдэгдэнэ.

Энэ хүнийг Эрдэнэ гэнэ. Говь-Алтай аймгийн Тайшир сумын хүн. Ойрноос нэрээ "Нью боржигин овогт мистер Эрдэнэ" хэмээн бичих болжээ. Эрдэнэ өмч хувьчлалаас болж аймгийнхаа засаг даргатай заргалдаад "коррупцитай өштэй хүн мөнгөгүй, ковбойтой өшгэй хүн амьгүй" гэдгийн үлгэр болж дийлдээд арга барагдан Улаанбаатар орж бизнес хөөх, далимд нь өмч хувьчлалын комиссын Гэрэлчулуунтай уулзах гэж явж байгаа нь энэ.

Эрдэнэ эцэг, эхээс хоёул. Дүү Төмөр нь аль багадаа сайн эрсийг даган "загалмайлсан эцэг" болно гээд сургуулиа орхин замын машинд дайгдаад хот руу арилжээ. Төмөр нэг хэсэг вокзал хавиар "нүүрсчин" хийж байснаа улмаар Улаан-Үд, Эрээн хоёрын хооронд гахай чирж овоо цулайгаад, сүүлдээ автомашины хулгайгаар дагнан занимаалах болж, Варшав, Москва, Улаанбаатар, Бээжин, Сингапурыг холбодог үндэстэн дамнасан том мафийн тэргүүн болж олонд "алмаз" Төмөр хэмээн алдаршаад бриллианттай гараар салаавч өгдөг нэгэн болжээ. Төмөр ноднин зун орос, хятад хоёр гангстерийн хамт ахындаа ирж зуугаад юань, хэдэн доллар, таван шил "Рояль" спирт орхиод явжээ. Түүнээс хойш үхсэн амьдын сураг гарсангүй.

Машиных нь зүүн урд дугуй өнөөдөр гурав дахиа хагарсан тул эхнэр хүүхдээ чирж яваа Эрдэнэ хээр хоноглох боллоо. Тайхар чулуунаас машинаа гинжлээд тавтай сайхан унтав. Эрдэнэ үүрээр босч хөтөвтэй шингэнээ барьсаар гарч иртэл машин алга. Гинжнүүдийг төмрийн хайчаар тас хяргажээ. Эрдэнэ уулсын толгой ширтэн гааль дээр шатсан ганзгачин шиг бүрзгэр царайлаад "Ээ ертөнцийн эзэн, Езүс Гэгээн, Мария дар эх минь, би нэг ч цугларалт таслаагүй юмсан, яаж байгаа нь энэ вэ?" гэжээ. Энэ чимээнээр эхнэр хүүхэд нь сэрж бөөн уйлаан майлаан боллоо. Долгор ихэд уйлж:

- Ингээд хүний нутагт гахай явган нохой нүцгэн үлдлээ. Энэ архангайнхан чинь хүний бүрхээр хүртэл шатаадаг их хэцүү улс гэнэлээ. Яанаа хэмээн улам цурхирлаа. Эрдэнэ түүнийг тайтгаруулж:

- За хө уйлаад яах вэ хө. "Амьд хүн аргатай, америк жинс чанартай" гэж үгтэй юмаа хөө. Явгарсан болохоос биш гааль дээр шатсан биш гээд Долгорын дутуу буржийлгасан үсийг илбээд цайгаа чанахаар примүүсээ асаалаа.

Тэр гурвыг ийнхүү будилж байхад эзгүй хээр газар бүх гэрлээ асааж сирена дохиогоо хангинуулсан шар алаг машин сүр бараатайхан ирлээ. Машинд тусгай хорих ангийн хуяг ахлагч Бадарч суужээ.

Бадарч уул нь боловсрол нимгэн, долоо ч төгсөөгүй хүн. Арван долоотойдоо НАХЯ-ны мэдээлэгч болж хамт ажилладаг нөхдөө хайр найргүй ольсоор цаадулдаа их үнэлэгджээ. Дэвшүүлэх гэтэл даанч боловсролгүй тул шоронгийн хуяг болгож. Хэрэгтэнд хатуу харгис ханддагаараа цууд гарсны дээр самбо бөхийн зэрэгтэй хүн юм. Бадарч сүүлийн үед хээль хахууль авах болж үлэмж хөлжөөд хүнийг "Чи муу цалингаараа амьдрагч" хэмээн хараах нь

олширчээ. Бадарч хэдэн хоногийн өмнө алмаз Төмөрийг машин нь онхолдоод ухаангүй хэвтэж байхад барьж нэрд гараад мөрөн дээрээ нэг таван хошуу хариугүй нэмдэгийн даваан дээр алдчих нь тэр. Одоо тэр Төмөрийг барьж авч алдагдсан нэрээ сэргээхийн дээр хэн ч бариагүй Төмөрийг хоёр дахин барьсан гэдэг алдар хүртэхийг горилж яваа хүн. Бадарчийн ард сууж яваа хүнийг Дамдин гэх. Ноднингоос цагдаагийн албанд ирсэн хүн. Дамдинд Төмөрийг барих ямар ч хүсэл байхгүй. Харин ч сайн эрийн гарт өртөж "жертв" болох вий гэхээс айж яваа нэгэн. Тэрбээр "Ингэж амь насаа алдах шахан ямар ч ашиггүй явж байснаас наймаачин авгай нарын шагийн архи, ширхэгийн тамхийг архи, тамхины хуулиар далайлган булааж аваад, авгайнхаа дэлгүүрт тавьж байх нь хамаагүй дээр юм" гэдгийг ойлгоод "Ээ Бадарч гуай цаадах чинь олдохгүй ээ" гээд хэлээд үзжээ.

Бадарч тэдний гадаа ирж зогсоод сум үл нэвтрэх цамцаа өмсөөд сая машиныхаа хаалгыг нээж тасгийн пулементынхаа замгийг тачигнуулан:

- Хөөе тэр палатканд байгаа бүх хүн гараа шилэндээ аваад гараад ир, давай! гэж хашгирлаа. Эрдэнэ гарч ирлээ.

- Танай үүгээр сэжигтэй хүн яваагүй биз! хэмээн толгой дээгүүр нь хий буудангаа асуулаа. Эрдэнэ тэнэсэн сумнаас дальдчин байж:

- Явсан байхаа, урьд шөнө миний хөл залгадаг унааг минь хулгай авчихаж.

Юу гэнээ. Машинаа манаж чадахгүй Интерполоос эрэн сурвалжилж байгаа хүнд хөл залгуулна гэнээ! Алив үнэмлэх толооноо аваад ир! гэж зандарлаа.

- Хаанаас даа бид, зүгээр л Улаанбаатараар дайраад Ромын папад мөргөх гэж яваа улс гэж Эрдэнэ хэллээ.

- Тэгээд урьд шөнө хэдийд явах шиг болов, мэдэв үү? гэж Бадарч асуув.

- Ишш, хэдийд явсныг нь мэдсэн бол барьчихсаан танд тушааж байхгүй юу!

Бадарч пар пар инээж:

-Барина гэнээ. Чам шиг пацаан барьдаг эр биш. Бас балтаалдаг эр байхнээ гэснээ царай нь хувирч -Чам шиг жулик барьдаг эр биш. Чи нам шаалгачихалгүй үлдсэндээ баярла! Тэр чинь Говь-Алтайн алмаз Төмөр байсан юм гэв.

Хэдэн сар сураг нь сонсдоогүй дүүгийнхээ тухай хэл мэдээ сонсоод Эрдэнийн царай хувиран баярын совин татав. Үүнийг ажсан Бадарч:

- Муу жулик чи Төмөрийн нэрийг сонсоод хувьсхийх чинь юу билээ! Арай хам хэрэгтэн нь биш биз? хэмээн ноцтой асуулаа.

- Иш ахлагч минь тийм айхтар эртэй учраад амьд үлдсэндээ л баярлаж явна гэлээ.

Бадарч ч явж Эрдэнэ "Муу дүү минь Роллс ройс, Кадиллак, Линкольн л гэдэгсэн, ядуу

хүний жаран долоо дээр бууж байхыг бодоход ядарч л яваа юм байна даа” гэж бодсоор үлдлээ.

Энэ зуур Цэцэрлэг хотын төв хэсэгт байх "Итгэлт энд Ко" гэсэн бичигтэй байранд хэдэн хүн хоол идэнгээ пиво ууж суулаа. Төмөрийг эрж явсан хоёроос гадна "Итгэлт" ББХК-ын захирал Итгэлт байна.

- Үгүй ээ тэгээд япон гав, герман дөнгөтэй байж урьдчилсан хорих байрнаас оргочихдог мөн лут эрээ гэж Итгэлтийн хэлэхэд,

- Үүнээс өмнө Интерполийн шугамаар эрээд олоогүй, барьж чадаагүй л юм даа гэж Бадарч тахар хэлэхдээ "Гэвч би л түүнийг барьсан юм даа" гэх омгорхол нүүрэндээ тодруулна. Тэгээд:

- Та нар зодуулж байхыг нь харсан ч болоосой. Хоёр гарыг нь ард нь гавлаж паарнаас уячихаад нүүр рүү нь орос бакиалаар өшиглөөд байхад шүд нь хятнахаас бус ёо гэдэггүй шийртэй нохойдоо гэлээ. Итгэлт:

- За, за тэр яахав. Бадарч та нар пийжүү ууцгаа. Алив Должоон, тэр Ням гуайд өвгөнт хийж өг гэлээ.

Гэтэл гаднаас савхин цамц өмссөн хүн орж ирсэн нь үзмэрч Дашцэрэн ажээ. Бадарч түүнд их л тал өгч:

- Өө аштай юу. Үзмэрч Дашцэрэн гуай ороод ирдэг чинь! Энэ муу алмаз Төмөрийг барьж чадах нь уу, үгүй юу та архивгаа нэг үзээд өгөөч? Уул нь яамны жаран жилийн наана барьчихвал их хэрэг юмсанж гэлээ.

Дашцэрэн баадантай архиваа задлан "12 мөнгөний" гэгдэх дэвтэр гарган халхын цуутай мафийн толгойлогчийн хувь заяаны тухай хаана юу гэж өгүүлснийг шүүрдэж гарлаа. Энэ зуур Итгэлт:

- Манай Дашцэрэн гуай чинь ёстой шарсан хортой өндөг анддаггүй шар зурхайч даа. Ямар сайндаа л энэ намрын дараагаар өвөл болно гэж үзмэрдээд яг тэрүүгээр нь болж ихэд алдаршаад ерөнхийлөгч Очирбатын дэрний үзмэрч хүртэл болж байхав дээ хэмээн үг нэмэрлэв.

Дашцэрэн гуай:

- Сүүлийн үед нас хөгшрөөд архиваа хольж хутгаад байх болсон байна лээ.....аа энэ байна... Алмаз Төмөрийг Бадарч хуяг барина... тэгээд алдана... гэж бичиж...

- Тэгээд цааш нь

- Тэгээд үү... хар даа... үлдсэн хэсэг нь урагдаад алга болчихож...

- Уул нь мөн сайхан гарч байнаа... цаашаа алга байдаг нь тусгүй яа...

Эрдэнэ замын машинд дайгдан Архангай аймгийн төв орж ирлээ. Тэгээд Итгэлт компанийн байранд орж учир явдлаа хэлэн унаа гуйлаа. Сарын дараа хоёр ч машин өгнө гэж хэлээд үзэв. Итгэлт түүнийг хаанахын хүн бэ гэхэд, угийн шударга Эрдэнэ нутгаа нууж чадсангүй үнэнээ хэлэв. Гэтэл Итгэлтийн царай хувьсхийж:

- За залуу минь Баатар генерал, Пүрэв генерал, Пүрэвдорж генерал, Жадамбаа генерал гээд Говь-Алтайн хөх харцуул хэцүү. Наад зах нь энэ ерөнхий сайд Жасрайгаа хар! Тамирын голын мөсийг долоох шахаж байж олсон хэдэн ногооныг минь албан татварын багц хуулиар булааж аваад төсвийнхээ цоорхойг нөхөж сууна. Дээр нь бензиний үнэ тэнгэрт гарлаа. Би чамайг танихгүй, чи намайг мэдэхгүй. Хоёулаа хал балгүйхэн салах уу даа гээд бослоо. Гэтэл тэр үеэр тэдний ажилчин Галсан нэг факс барьсаар орж ирснээ:

- Итгэлт ахаа, Америкаас нэг факс иржээ гэв.

Итгэлт факсыг толгойг нь өөд уруу харуулж хэд

харснаа

- За байз энийг чинь хэнээр орчуулуулдаг билээ гэв. Эрдэнэ:

-Би орчуулаад өгвөл болохсон болов уу? гэв. Итгэлт тоомжиргүй ёжтой инээмсэглээд:

- Үгүй одоо та юу даа?! гэхэд:

- Тиймээ. Би дөчин тав хоногийн дамжаанд суусан юм л даа хэмээн тайван хариуллаа. Эрдэнэ факсыг авч

-Дийр сэр Итгэлт... хэмээн амандаа гүнгэнэснээ - Танайхаас нийлүүлэх ноолуурын үнийн хагасыг гэрээнд тохирсон ёсоор шилжүүллээ. Үлдсэнийг ноолуураа хүлээж авмагц танай дансанд оруулна гэсэн байна гэж хэлэв...

Латин үсгээр англи хэл дээр бичсэн факсыг нэг ч удаа түгдрэлгүй синхрон орчуулж байгаа Эрдэнийг хараад Итгэлт ихэд гайхав. Англи ноосон гонжоом, саламандр бажийнк, пэр кардин цамцтай нарийхан хуруутай гол төлөв хараа муутай турьхан орчуулагчид л түгдрэлгүй ярьдаг хэлээр сүүлийн хэдэн жил нэхийний бизнесээс өөр юу ч хийгээгүйг нь илтгэн давс шивхний үнэр ханхлах баривгар гартай Эрдэнэ ярьж байгаа нь гайхал төрүүллээ.

Итгэлт багадаа англи хэл сурах гэж нэлээд оролдсон боловч "Биг маззи", "ай ам хангри" хоёроос цааш хэтэрсэнгүй Гэтэл ийм хэлтэй хүн өөрөө хүрээд ирнэ гэдэг түүнд ямар ч үзмэрч урьдчилан хэлэх аргагүй баяр байлаа.

- "Говь-Алтайнхан сайтай муутай, голын бургас урттай богинотой" гэдэг. Лодойдамба гуайгаас авахуулаад аятайхан улс танайд байдаг л юм. Чи ерөөсөө манай компанид брокер бол гэж элэгсгээр хэлэв.

Итгэлт уулаасаа баян тарган ч юмуу, албан тушаалтай явсангүй. Нэгдэлд элссэнээс хойш зааз хонь хэдэн жил маллажээ. Гэвч тэрээр альхимийн аргаар гүн ухааны чулуу гаргахаас бусад аргаар хөлжин баяжжээ. Арван ссөн насандаа Их тамир сумын намын үүрийн даргын охинтой гэрлэж сумын төвд суурьшин зээлдэн туслах кассын сахиул болсон нь түүний цаашид дэвжихийн эхлэл болжээ.

Эцэг нь нас барахдаа түүнд гурван үе дамжуулан хэрэглэсэн ир мөр нь ялгагдахгүй зэс балиус үлдээж "хадгалж яваарай" хэмээн гэрээсэлжээ. Гэвч Итгэлт түүнийг хадгалаагүйгээр үл барам "Хүрэлийн үеийн ховор олдвор" хэмээн Соёлын яамны сайд Энхбаярыг мэдэхгүйгээр нь далимдуулан тархийг нь эргэтэл хуураад Дүрслэх урлагын музейд 1000 доллараар зарсан ба одоо болтол түүнийгээ өөрийн хийсэн хамгийн зөв зүйлийн нэг гэж итгэсээр явдаг юм.

Итгэлт анх Ардчилсан холбоо гарсан гэж дуулаад гайхсангүй. Тэдний анх дэвшүүлсэн санал шаардлагууд цөм л зөв зүйтэй мэт санагджээ. Зөвхөн дарга нарын хүүхдүүд дарга болдог, малыг булааж авч нийгэмчилсэн зэрэг нь Итгэлтийн дотроо буруушааж л явдаг юмны нэг байлаа. Гэвч тэр үүнийгээ хэнд ч хэлсэнгүй. Гэтэл нэг орой хадам эцэг нь дуудаж:

-За Итгэлт минь чи одоо нэг өөрийгөө харуулах цаг боллоо. Чи хэдийгээр миний хүргэн ч гэсэн миний удирдаж байгаа намын үүрийн гишүүн хүн. Тэр ардчилсан холбоо гэдэг чинь цөмөөрөө хулгайч, гэмт хэрэгтнүүд байсан байна. Сая Намын Төв Хорооноос тэдний намтрыг ирүүллээ. Чи унш! Элбэгдорж хүнд зээлсэн мөнгөө өгөөгүй. Малыш Энхтүвшин залилангийн хэрэгтэй ... гээд л ялын тогтоол шиг юм уншлаа. Хүнийг ингээд ирэхээрээ яадгийг нагац ламыгаа бариулсан, сүүлд Лоохуузыг үзэн ядах хуралд сууж явсан хүний хувьд Итгэлт гадарлаж дотор нь эвгүйцлээ. Гэсэн ч Ардчилсан холбоог дэмжиж явснаа хэнд ч хэлээгүй болохоор айх юм алга.

Хадам яриагаа цааш үргэлжлүүлж:

- Чи маргааш арван хонь, арван морь туугаад аймаг орж МАХН-даа хандивла. Ингэвэл намд маань ч хэрэгтэй, чамд ч тустай. Ирэх намраас чамайг аймгийн Намын бага хурлын гишүүн болгох санаагаа би хоёрдугаар даргад цухуйлгахад нэг их дургүйцэхгүй л байна билээ. Удахгүй идшээ авах гээд ирэхээр нь бас нэг сануулна. Үүнд маргаашийнхийг нэмбэл... гэлээ.

Итгэлтэд дургүйцэх юм алга байлаа. Хэдийгээр нам засгаас нэг малчин 50 толгойгоос илүү малтай байж болохгүй гэж заасан ч намын дарга хадам, намын гишүүн хүргэн хоёрын далд сүрэг хоёр зуу дөхжээ. Ер нь ч хэзээ хэзээгүй маарт болох гэж байгаа тул Должин, Солонгод, бас Дулмаад бэлэглэх хятад алчуур ч болов олж ирэхийн тулд аймаг орох ажил Итгэлтэд байлаа. Тэр ч бүү хэл энэ тухайгаа БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, МАХН-ын Тов Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнхөд цахилгаан явуулах, аймагт суугаа "Үнэн" сонины сурвалжлагчийнд арван литр сүүтэй очиж энэ тухайгаа төвийн хэвлэл, радио телевизээр зарлуулах юм шүү гэж бодогдсон боловч "хэрвээ тэд ялбал..." гэсэн өөр нэг бодол тээглээд болсонгүй. Тэд өнөө биш ч маргааш ялна. Өмхрөн унаж буй хуучин ёс ба өнөөдөр дэлхий дахинд болж байгаа бүхнийг мэдэхийн хувьд Итгэлт "хэзээд тэд ялна" гэсэн бат бодолтой байсан юм.

Ингээд энэ удаа чимээ шуугиангүй аваачаад л өгчихье гэж шийдлээ. Ядаж араажавны зай дууссан тул юу болж байгааг ганц хадмынхаа л амнаас дуулдаг байлаа.

Итгэлт, Хонгор, Ням гурав хэдэн адуу хонио туусаар Цэцэрлэг хот руу орж явтал Намын хорооны дэргэдэх талбай дээр баахан улс цугласан харагдав. Хонь үхрээ нэгэнт Намын Хороонд хүргэх тул бөөгнөрсөн олон руу дөхөж очлоо.

Олны дундаас тас няс гэх чимээ хадаж нэг хүн учиргүй ёлно. Дөхөн харвал цасан дээр нэг хүний хонгыг гарган хэвтүүлээд орос цэргийн гуран бүсээр ороолгож байв.

Гэнэт Ням гуай дуу алдаж:

- Еэ Ленин багш минь. Энэ манай нэгдүгээр дарга Бизьяа шив дээ...

- Арай намхан, залуухан хүн байна шүү дээ.

- Үгүй ээ Итгэлт минь, тэр зодуулж байгаа нь!

- Нээрээ энэ чинь...?

Гэтэл хажуунаас нь цэнхэр тууз ханцуйдаа хадсан залуу ярианд оролцож:

- Яг тийм. Шийтгүүлж байгаа нь Бизьяа дарга... Ороолгож байгаа нь Элбэгдорж гуай. МоАХ-аас ирсэн юм.

- Тэднийг барьчихсан юм биш үү?

- Юу баригдах.. Цаана чинь Улс Төрийн Товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцроод, хуучин засаг халагдсан. Манайх ардчилсан улс болсон. Өчигдөр шөнийн 23 цаг 59 минутаас эхлэн социализмын замыг орхиж өчигдрөөс өнөөдөрт шилжих шөнийн "нойль" цагаас капитализм руу эргэсэн гэхчилэн ярив.

Элбэгдорж дарга их ууртайгаар:

- Чиний тэр цуглаан хийлгэх таван зуун хүний суудалтай заал бэлэн байлгана гэсэн чинь хаана байна. Заалаа цоожлоод түлхүүрийг нь авсан хүнийг ХКН руу зугтаалгана гэнээ!? Тэгээд бас малтан ардын эд хогшлыг шатаадаг гээд байгаа шүү. Байх уу чи... ! хэмээн ороолгоход цаадах нь:

- Байя, байя... заал ч олж өгье, би дахиад бүрхээр байтугай самогоны аппарат олдсон ч шатаахгүй. Ерөөсөө өөрөө ч бүрхээртэй болж маргаашнаас тогоо нэрье хэмээн орилж, уг үйл явдал өндөрлөх тийшээ хандлаа.

Итгэлт арай ч түрүүн ирээгүйдээ өөртөө баярлалаа. Тэгээд хүү Хонгortoо соокны шил өгч гүйлгээд ахуйн үйлчилгээ рүү ороод ус аваад ир гэлээ. Хонгорыг ус авчирмагц Итгэлт өврөөсөө мөнгөн аяга хадаг бас нэгэн боодолтой зүйл гаргасан нь хуурай сүү байв. Сүүг усанд найруулж хэд хутгаад мөнгөн аяганд хийж хадаг бариад хөлсөө арчин зогсож байгаа

Элбэгдорж руу очлоо.

- За би угаас харц ард гаралтай. Хотод МоАХ байгуулагдлаа гэж дуулаад их баярлаж байлаа. Сэтгэл зүрх минь хөөрөн догдолж байсан боловч инээхээс бусад өвчинд нэрвэгдсэн болохоор салбар зөвлөл байгуулж гишүүн элсүүлж чадсангүйг өршөө. Ингээд өвгөн ах нь залуус та нарынхаа эхэлсэн их үйлсэд хандив болгож хувиасаа агт морь арав, халзан цагаан хонь арвыг тууж ирчээ. Тогтоон авна уу! гэлээ.

Элбэгдорж хадаг сүүг аван талархал илэрхийлээд "Итгэлт гуайн сэтгэл бол манай мянга мянган эгэл ардын сэтгэлийг төлөөлөх үндэстэй" болох тухай, ийм олон

иргэд энд тэндгүй байгаа тухай гучаад минут ярьлаа. Элбэгдорж тэр орой болсон цуглаан дээр Итгэлтийг иш аван ярьсан бөгөөд цаашид олон аймаг, суманд хийсэн уулзалт дээр түүний тухай өгүүлсээр "ардчилсан холбоог дэмждэг Итгэлт" гэдэг нэр олны танил боллоо.

Олны өмнө намын гишүүн, коммунист хүн атлаа аймагтаа анх МоАХ-г дэмжиж малаар хандив өргөсөн Итгэлтийг нэгэн хэсэгтээ эрх мэдлээ хадгалж байгаа дарга нар араандаа зуух нь дамжиггүй боловч өнөөдөр ардчилагчийн дүрд тоглохыг хүсэж байгаа тэдгээр түшмэд цөмөөрөө "МоАХ-ны Итгэлтийг гадуурхаж гэнэ" гэсэн яриа хөөрөөнд өртөхийг хүсэхгүй гэдгийг Итгэлт ойлгож байв.

Итгэлт малаа тоо ёсоор нь өгөөд харихдаа анх удаа холын замаас буцахдаа хадмындаа буулгүй өнгөрч билээ. Ням өвгөн ч гэсэн өөрөөс нь дутуугүй баяр хөөртэй явсан учрыг тааж мэдсэн Итгэлт жоготой инээвхийллээ.

Угаас өтлөх насандаа жаахан балгачих дуртай болсон Ням өвгөн Бизъяа даргад хэд хэдэн бүрхээрээ хураалгаснаар барахгүй захиргааны журмаар баривчлуулж хүртэл явжээ. Одоо тэр хэнээс ч айхгүйгээр хэдэн тогоогоор нэрсэн ч болох нээ...

"Итгэлт ББХК" хонио хяргах гэнэ гэсэн яриа Тамирын хөндийгээр тарж, чадвал хэд гурван цаас олох, ядвал цадталаа хооллох бодолтой олон хүн хайчтай нь хайчаа, бритвтэй нь бритвээ аван товлосон өдөрт нь цугларлаа. Мөн Итгэлтийн ноосыг газар дээрээс нь сул авчих санаатай хэдэн ганзагачин, хоёр гурван хужаа ирсэн боловч, ноосоо өөрөө угааж худалдана гээд халгаасангүй.

Итгэлт хонь хяргаж байгаа хүмүүсийн дундуур дахин дахин явж:

- Би татварт өгөөд үлдсэнээ олон ах дүүстэйгээ хувааж сурсан хүн. Одоо ч хээл хахуульд ихэнх нь явчихаад үлдэх юм бага болж дээ. Тэгэхдээ яах вэ, та нөхдийн минь, нутаг орны минь хишиг одоохондоо байна. Идэцгээ, ууцгаа, ажлаа эртхэн шиг дуусгаад орой диско хийнэ шүү хэмээн зарлаж явлаа.

Галсан Итгэлтийн өмнө хойно гүйж

- Итгэлт ахаа, Босс дайдаа гэхчлэн зүйл зүйлээр налиглан дуудаж, -Засаг дарга Гүррагчаагийн пүүснийхэн хонио хяргах гэж цуглаад хуушуураа булаалдан зодолдож бөөн юм болоод Гарамжил хурандаа хэдэн цагдаатайгаа очиж тараасан байна шүү дээ гэв.

Итгэлт цаанаа нэг маадгар инээж:

- Харамч золиг, хамаг ноосыг нь ажилчид нь Эрээн рүү зөөгөөд барж байгаа юм. Цаадах чинь дампуурна даа... дампуурна гээд "дуудлага худалдаанд орохоор чинь чамайг би..." хэмээн шивгэнэснээ хүн дуулчихсан юм биш байгаа даа гэсэн аястай ийш тийшээ харлаа.

Мичин жилийн могой сарын луу өдөр Ван овогт хэмээх хятад наймаа анх Эрээнээр дамжин Архангайд ирж хоёр шуудай өвгөнт архи наймаалах гэжээ. Тэр ирсэн дороо л Итгэлтийг өөртөө хэрэг болох хүн гэдгийг таньжээ. Тэр дахиад архи зөөсөнгүй. Харин монгол нутгийн хөрсөн дээр хог мэт хэвтэх үнэт төмөрлөг, бас малын арьс ширийг Итгэлтгэй хамсан зөөсөөр хөлжиж "Тамир-Түнпан" пүүсийн хятадын талын захирал болоод авчээ. Хэдийгээр монгол газар түүнд "Изобилигийн эвэр" гэдэг эрдэнэсээр бөөлжигч эвэр болон хувирч түүний сан хөмрөг өдрөөр биш цаг цагаар өсч байсан ч нэг л зүйл зовоосоор байлаа. Анх Ван овогтыг хошууны намын үүрийн жирийн идэвхтэн байхад нь хошууны Амрыг хамгаалахын (Догоодыг хамгаалахын) дарга дуудан:

-Одоо чи зүгээр нэг мэдээлэл бичиж байдаг цаг өнгөрлөө. Уул нь чи овсгоотой залуу. Монголд энэ хоёр шуудай өвгөнт архийг аваад яв! Гаалийн дарга, байцаагч хоёрт нэг нэг тор өвгөнт архи өгөхөд чамайг ногоон гэрлээр гаргана. Хил давах бол амархан. Одоо хамгийн гол асуудалдаа орьё. Бидэнд байгаа мэдээгээр бол Монголын төв орчим хэсэгт архинд маш дуртай хүмүүс байдаг нэг аймаг байна. Яагаад гэвэл үе үе тэндхийн сонин хэвлэлд хулгайгаар архи үйлдвэрлэгчдийн багаж хэрэгслэлийг устгасан тухай мэдээлдэг. Чи тэр нутагт очоод энэ хорт архинд дасгах ажил зохио. Тэнд өвгөнтийг тараах салбарууд байгуул. Бас мөнгө хөрөнгөнд дуртай нэр нөлөөтэй хүмүүсийг худалдаж авах ажил зохио хэмээжээ.

Ингээд анхны явалтын дараа Ван овогт удирдлагадаа Итгэлтийн талаар ярьж өгөхөд хөрөнгө мөнгө хайрлалгүй элсүүлж ав гэсэн үүрэг өгчээ.

Гэтэл бүх юм Ван овогтын санаснаар явсангүй. Итгэлт баяжиж хөлжих төрөлхийн арга ухаантайн дээр өдөр ирэх тутам бие дааж харин ч Ван овогтын хөрөнгийг хянах болж иржээ. Монголын талын захирлын хувьд "Өвгөнт" архи оруулж ирэхийг тас хорьсноор барахгүй, анх авчирсан хоёр шуудайгийн нэг нь тэр чигээрээ Итгэлтийн зооринд хэдэн жил болж ноднин заримыг нь арьс идээлэхэд ашиглажээ.

Харин засаг захиргаагүй хатуу юм хэрэглэдгээрээ түүнээс нь Ням өвгөн хэд гурвыг цааш харуулсан юм. Эхлээд Итгэлт уурлаж, "би танаас коньяк байсан ч харамлаад байсан удаагүй байхаа!" гэхэд:

- Энэ чамд ч хямд, миний сэтгэлд ч амар гэснээс хойш юм хэлэхээ больжээ. Ван овогт Итгэлтийг өөртөө татахын тулд Цэцэрлэг хотын гайгүй гэсэн хэдэн хүүхнийг авчран зад дайлсан боловч Итгэлт төдий л уусангүй, тэгэж ингэж байснаа утас залгаж "Галсан гадагшаа явсан эсэхийг" лавласнаа яваад өгчээ. Харин Ван овогтын залуу эхнэр Үй Бай Хуа руу нэг л учиртай хараад байгааг хятад данжаад мэдэж гол нь харласан боловч Амрыг хамгаалахын даалгаврыг биелүүлэхгүй бол энд нэг л өдөр өөр коммунист эзэн сууж өөрөө Ганьсу муж руу одно гэдгээ мэдэх гул дүүрсэн хэрэг монголчуудын хэлдгээр "углаад авахаас ямар ухаж аваад явчих юм биш" хэмээн санаа алджээ. Гэвч түүнээс долоон дор юм болно гэдгийг тэр яахин мэдэх билээ.

Харин Итгэлтэд өөр бодол бий. Үнэгүй хэвтэж байсан төмөр ноос, үсийг алт болгоход нь Ван овогт ба түүнтэй хамтарсан пүүс хэрэгтэй байлаа. Харин одоо өөр. Ноднин ноолуураа Америкт худалдахад Итгэлтэд Ван овогт жигтэйхэн уурлаж "Хай танай яасан танийсаан хүн байтлаа яах нь энэ баа" хэмээжээ. Тэгэхэд нь Итгэлт "За за, чи бид хоёр тэр таван зуун тонн ноолуураар заяаны дутахгүй. Би зөвхөн ганцхан энэ жил л тийш нь өгч байна. Чи худлаа гэвэл үүнийг хар хэмээн ганцхан жилийн хугацаатай гэрээгээ харуулжээ. Үнэхээр Итгэлт хойтон жил ноолуураа Америк гаргахгүй нь үнэн боловч бас урагш нь гаргахгүй байж. Тэр Америкт гаргасан ноолуурынх нь өртөг дотор ноолуурын үйлдвэр явж байлаа. Ван овогт Итгэлтэд бас л эргэлзэж байсан боловч яаж ч чадсангүй.

Тэр өөрийгөө хэдийгээр дотор хүн, хань үндэстний нарийн ухаантай, монголчууд тэнэг мулгуу, малтай адилхан гэж боддог боловч Итгэлт нэг удаа малчдын хог дээр хаях гэж байсан хуучин хөвөнтэй туурга шар эсгий зэргийг үнэгүй аваад шальгүй додомдоод эскимосчуудад өндөр үнээр зарж байхыг үзээд түүнтэй яавч зиндаархаж болохгүй гэдгийг мэдэж авчээ.

Харин Итгэлт Ван овогтыг шууд дампууруулах бодлого явуулсангүй. Нэг удаа Ван овогт:

-Хай түнш чи бид хоёр дундаа нигээ пүүсүүтэй баа. Харин чи тусуудаа бас нигээ пүүсүүгэй. Миний юм бол чиний юм ба. Чиний юм бол миний юм ба. "Итгэлт Ко" ба "Тамир-Түнпан" -гаа нийлүүлбаа. Аймгийн засаг далгаа манай хүн болсоон шүү... Цөмөөрөө баяживаа" гэхэд Итгэлт:

- Таны хэлдэг зөвөө, гэвч аливаа юманд өөрийн цаг бий. Тусдаа байх нь ашигтай үе ч байна. Ухаандаа хойтон урагшаа явуулах ноолуурыг хоёр пүүс цуглуулсан нь дээр үү, нэг пүүс цуглуулсан нь дээр үү? гээд жоготой инээвэл Ван овогт:

- Аяа танай зөв ба, таны санаа яасан мэлгэн... хэмээн хэлсэн боловч "Зальт муу чоно чи юу сэдэж байгаа бол доо" хэмээн харджээ.

Орой нар шингэхээс өмнөхөн Итгэлтийн үүдэнд хятад жийп зогсож түүнээс Ван овогт, түүний гэргий, ойрноос тэднийд зарагдах болсон Чингисийн-Ялалт хэмээх өвөр монгол залуу буулаа. Итгэлт:

- Ни хао! хэмээн мэндэлж тэднийг гэрт оруулав.

Ван овогтын зарц авч явсан торноосоо хэдэн өдрийн өмнө "гэдэсний өвчин үүсгэгч савханцартай" хэмээн зурагтаар харуулж байсан шоколад гаргаж хүүхдүүдэд тараалаа.

Эрдэнэ хятад хүнийг харахаар очвол өнөөх өвөр монгол залуу:

- Жа та амархан шайн байна уу? Дааг далантай бяруу булчинтай, өн тарган өвөлжиж, зузаан таргатай зусаж байна уу... ! хэмээн мэндлэв. Ерөөлөөс хэсэглэж аваа болов уу гэмээр тэр урт мэндчилгээний зарим хэсгийг нь Эрдэнэ сайн ойлгосонгүй.

- Далгаан чийчаа угаанаа та тусарнаа гэхэд нь бас л ойлгож ядан байтал Ням өвгөн ирж:

- Вангийн барлаг алиа найрагч Чингисийн-Ялалт сайн уу? Чи ойрдоо яагаад үзэгдэхгүй байна? гэв.

- Ай хамаагүй явбал эжээн жодно шүү гэлээ.

Эрдэнэ Ням тэр гурав хятад данжаадын машиныг угаагаад майханд ирж пиво уулаа. Ням түүнд сайрхаж "Бид хятад пийжүү уухаа байсан. Хар л даа энэ Германы "Карлсберг" тэр нь Данийн "Холстен"

- Ай энэ ч бас яг сайн бишээ манай дотор газар "Хуй" гэж ёстой шайн пүүжүү байна.

Эрдэнэ түүнийг явуулахаар шийдэж "Түүнийгээ оросуудад худалд! Эр, эмгүй дурлан авна. Тийм нэр их таалагддаг юм гэв. Чингисийн -Ялалт:

- Яг тиймээ. Манай Хуй пүүжүүг орос эрэгтэй ба эмэгтэй их дуртай хэрэглэдэг болсоон гэхэд нь Эрдэнэ тэсэлгүй инээв.

Дараа нь тэрбээр үүдээр эргэн шагайж ойр хавь хүн байгаа эсэхийг харснаа Эрдэнэд:

-Та юун хүн? гэхэдНям:

- Энэ шинэ хүн. Манай хүн, их сайн хүн. Эрдэнэ гэдэг.

Чингисийн-Ялалт дуугаа намсган:

- Эрдэнээ ши Тань Аньминий талбай дээр юу болсонг дуулсан уу? гэж ноцтой өнгөөр асуулаа.

- Аа. Коммунист намаа шүүмжилсэн хэдэн залуус жагсаад тэднийгээ хярамцаг болтол нь танкаар дайрсан гэсэн байхаа.

- Бид дахиад бошно. Тэгэхдээ хоёр монгол орноо нэгтгэж агуу улс байгуулна. Та оролчоно биж дээ. Тэгээд Чингэш хаанаа дахин тодруулж шилээнд нь жална. Би танд энэ тухай шүлэг уншъя.

Аяа их өвөг дээдэс минь

Ахиад та нал малгааш төрнө

Агуу монгол дахин мандаж

Алтан дэлхийг уландаа гичгэнэ, уландаа гичгэнэ

уландаа гичгэнэ... хэмээн уншиж байтал Итгэлтийн тэндээс "Хай сэнкүү" гэх дуу хадаж. Мань Чингисийн-Ялалт хадаасанд хатгуулсан мэт огло үсрэн босоод "Жа жа би одоохон" гээд гүйлээ. Данжаад хятадаар хэдэн үг хэлсэн нь "Чи эхнэрийн бандажийг угааж авчирсан уу, арай угаагаагүй юм биш биз" гэсэн утгатай байжээ.

-Зайлуул, Данжаадаа ганц хашгирахад чацгаа савируулан гүйж байж Их монголыг байгуулах... Алтан дэлхийг уландаа гишгэх юм бодож явах... хүний дотор ч мөн уужуухан юм даа гэж Эрдэнэ боджээ.

Сүүлийн үед машины үнэ эрс буусанд гайхсан алмааз Төмөр Шар хадны техникийн зах дээр өөрөө очихоор шийджээ. Тэгээд ойр зуур гүйдэг улсаа буцааж өөрөө үнэ хүргэх гээд үзэв. Тэр захаар Хулхи Жагай хэмээх бас нэгэн халхад алдартай сайн эр явж байлаа. Жагай дэл сул хулхидмаар юм хайж үүгээр байнга явдаг нэгэн байжээ. Түүний хараанд Алмаз Төмөр өртлөө. Гав ганцаараа хэдэн согоо шиг лимузин сойчихсон зогсож байгаа хүн их дээрмийн хөл газар олз хайж яваа хүний харааг булаалгүй ч яах вэ дээ. Тэгээд Хулхи Жагай цагдаагийнхтай төстэй хар хүрэмнийхээ захыг босгож берет малгайгаа духдуулсхийн очиж:

- За залуу наад гурван тэрэгнийхээ түлхүүрийг өгөөдөх, би патентын цагдаа байна гэнгүүтээ ханцуйдаа байсан гаазаа дарав. Сүүлд бодоход дарсан л санагддаг билээ. Жагай гэнэт ухаан орвол том заалны дээврээс түүнийг хоньчлон хүлээд дүүжилжээ.

Цаад хүн:

-Одоо чамд ахынхаа лимузинг булаах арга зааж өгнөө гээд, яавлагны хайрцагтай юм доор нь авчран асгахад нүдний булангаар харвал дандаа зуутын рублиуд байв.

- Та намайг яах гэж байна.

- Таныг дулаацуулж далимд нь наян оноос өмнө хэвлэгдсэн миллиард рублиа шатааж хог новшноосоо салья.

- Таны алдар хэн бэ?

- Говь-Алтайн Алмаз Төмөр гэж дуулсан уу?

- Дуулсан.

- Тэр чинь би байна.

- Халхад байтугай, бүс нутгуудад нэрд гарсан "загалмайлсан эцгийг" таньсангүй, намайг өршөө. Та бид хоёр адилхан л гол гарган хулхидаж дундаас нь юм унагахаар яваа улс шүү дээ, намайг өрөвдөөч гэж гуйлаа.

Энэ үгийг дуулсан Алмаз Төмөр "би гол гаргаж, хулхидаж яваагүй шүү дээ" гэх бодол бодогдсон боловч үгүй гэх зүрх хүрсэнгүй.

- Төмөр ах минь та миний босс бол. Би таны жижиг тэрэгний чинь данхраад, том тэрэгний чинь маниул болоё гэж Жагай гуйлаа. Төмөр:

- За дүү хүү, тэгээд ахынхаа машиныг булаах өөр арга олов уу хэмээн пар пар инээснээ түүний хүлгийг тайлж:

- Надад тийм данхраат, маниулны хэрэг байхгүй. Тэртэй, тэргүй би астаачиртай тэрэг унадаг хүн гэлээ. Төмөр гараашаасаа гарахад Жагай аавдаа загнуулсан хүүхэд шиг арынх нь суудал дээр сууж явлаа. Хэсэг явсны дараа Төмөр түүнийг хажуудаа суулгаснаа хөгжмөө залгаж:

- Ай лав юу...хэмээн цээл сайхан хоолойгоор дуулсаар Эрээнийг чиглэн одлоо.

Төмөр түүнийг дагуулан Сингапур орлоо. Угаас хот тойрсон хэдэн аймгийн унхиагүй амьтдыг гол гаргаж явснаас бус ийм хол явж үзээгүй хулхи Жагайгийн сэтгэл хачин хөөрч хэзээ зах руу нь очиж хүний юм булаах бол гэж хүлээж байлаа.

Гэтэл Төмөр тийм юм яриагүйгээр барахгүй харин ч "Олон улсын валютын сан ухна" гэж аймаар ч юм шиг гайхмаар ч юм шиг юм хэлжээ. Манай төмөр авдраас өөр хогшилгүй банкнууд дээр л буутай цагдаа байнга байдаг юм чинь тэнд лав суман цэрэг байгаа даа гэж санаад:

- Төмөр ах аа? Буу зэвсэг, хүн хүч чинь бүрэн юм байгаа биз дээ гэвэл:

-Хүрнээ гээд үүрч яваа "Лэп топ" компьютерээ заажээ.

Шөнө хүн амьтан унтсан хойно Төмөр таван одтой буудлын компьютерийн сүлжээнд өөрийн компьютерээ залгаад ажиллуулж гарлаа. Жагайд учрыг нь олох юм байсангүй. Буу тулгахгүй, гараас булаахгүй, айлгаж сүрдүүлэхгүй яаж дээрэм хийх тухай урьд өмнө нь зүүдэлсэн ч үгүй явжээ. Төмөр байн байн дискээ солин янз бүрийн программ гарган шөнөжин үзлээ. Үүр цайхын алдад Төмөр дуу алдаж "ээ тарлан хайрхан минь уул нь ингэдэгсэн дээ" гэхэд сая анзааран харвал дэлгэц дээр "YES" гэсэн үсэг анивчиж байлаа.

Төмөр дараа нь команд өгснөө компьютераа унтрааж: -Явнаа, хувцсаа өмс

- Хаашаа, ОУВС руу юу?

- Үгүй ээ, Филиппин ниснэ. Хурдал гэжээ.

- Үгүй нөгөө мөнгө дээрэмдэх яасан бэ?

- Мөнгө бидэн рүү ирж яваа хурдан явья?

Төмөр тэр хоёр Манила хотын онгоцны буудлаас гадагш гарсангүй.

Төмөр нэг цонхон дээр очиж хүнтэй нэлээд яриад цаадах нь компьютертээ хэдэн юм хийгээд тэгээд л болчихов бололтой.

- За одоо Хон-Конг руу эргээд ниснээ гэхэд Хулхи Жагайд айх сэтгэл төрлөө. "Арай намайг энд тэнд аваачиж худалдах гэж яваа юм биш байгаа. Би ер нь Төмөрийг баярлуулах юм юу хийлээ" гэж бодогдон айдас хүйдсийн мананд автлаа. Үүнийг ажигласан Төмөр:

- Бүү ай. Чам шиг хулхи биш, би их гарын хүн. Тэгэхдээ оготны хамраас ч цус гаргасан удаагүй, дуугүй дагаад яв гэв. Төмөр мөн л Хон-Конгд дөнгөж буун хоёр хүнтэй уулзаад нислээ. Тэгээд хятадын Тяньжин боомтод очиж нисдэг тэрэг хөлөглөн явлаа.

Төмөр:

- Жагай чи доошоо хар даа

- Пээ ямар олон цуваа вэ?

- Захын хоёр урт цуваа одоо хөдөллөө, харав уу?

- Харлаа.

- За тэр чинь чи бид хоёрын "гахай"-даа гэснээ пар пар хөхрөв. Жагай нүдэндээ итгэсэнгүй. Зуугаад вагонтой хоёр цувааг биднийх болсон гэж...

Төмөр түүнд болсон явдлыг товч ярьж өгөв. Хэдэн сайн программч найз нартайгаа банкны данснаас мөнгийг нь гаргах программ хийжээ. Тэгээд л Сингапурт шөнөжин оролдож байж ОУВС-ын дансны талыг нь гаргаж Манила руу шилжүүлжээ. Талыг үлдээснээ "Монголд тусламж үзүүлж байгаа болохоор нь ОУВС-г хүндэтгэж үздэг" хэмээн тайлбарлалаа.

Манилад "угаасан мөнгөө" Хон-Конг руу эргүүлэн шилжүүлээд нэлээдийг нь орхиод Тэнжин боомтод байгаа Жийп машин ачсан хоёр цувааг худалдан авчээ.

Тэд нисдэг тэргээр цуваагаа даган аялсаар.

Нэг өдөр Жагай:

- Энэ олон машиндаа яаж зах зээл олно оо. Та Орос руу реэкспорт хийх үү гэвэл?

- Ядах юмгүй... Туранхай Жасрай сайдын улсын ядууст л тараачихна.

- Хэдээр өгөх ю?

-Өлссөндөө болоод Засгийн газрын ордны довжоог мэрэхдээ тулсан ядуусаас ямар балдуушийг нь авдаг юм бэ! гэв. Жагайгийн сэтгэлд аймаар хар буулаа. Хайран биеэ зовоож олсон юмаа хүнд зүгээр өгнө гэсэн чинь юу гэсэн үг вэ?

Нэг бол цуваанаас хулгай хийж өөр тийшээ зугатах хэрэгтэй байлаа. Гэвч энэ бол Жагайгийн хийх ажил биш. Харин хил давуут "Төмөрийг Жасрай сайд, Пүрэв генерал хоёрт барьж өгөөд их шан авч болох юм" гэсэн санаа гэнэт зурсхийлээ. Гэвч харамсалтай нь Пүрэв генерал Жагайг өөрийг нь бас эрж байгаагийн дээр

Жасрай, Төмөр, Пүрэв гурав нэг нутгийнх, Ерөнхий сайдыг Хятадын тагнуултай холбоотой гэдэг. Аягүй бол Төмөр түүний хань хамсаа ч юм билүү" гэсэн бодол төрж ацан шалаанд орлоо.

Улсын хилд дөхөж ирмэгц Төмөр нэг газар нисдэг тэргээ буулгаж хэдэн хужаад хүлээлгэн өглөө. Нөгөө хужаа нь жижиг тэргээр хилд нэлээн дөхүүлээд хаяжээ.

- За одоо улсын хилээр явган орно! Ингэсэн нь дээр байдаг юм. Машин юм уу онгоцоор хил давахаар хүний хараанд өртдөг юм гэлээ.

Элсэн цөлөөр бүтэн өдөржин хоол ундгүй явсан Жагай үхэн алджээ.

-Төмөр гуай уух юм, идэх...

- Чи өглөө амаараа гартал гудрах чинь билээ. Бид ямар Туулын эргээр бардааканд яваа биш, алхаад бай гэв.

Явж, явж зогсоод:

- За залуу... нөгөө булсан пийжүүгээ олоодох гэв.

Жагай түүнийг энд тэнд онгичин эрснээ царай нь

хувиран:

- Яанаа Төмөр гуай, хүн олоод уучихсан байна. Бид хатаж үхэх болохнээ ...ийн, ийн ...хэмээн эхэр татуулав.

Төмөр паржигнатал инээн:

- Алив тэр миний гахайг сөхөөдөх, тэгээд доод элсийг нь ух гэвэл үнэхээр тэр дороос олгой хаймарт хийж амыг нь төмөр утсаар дангинатал боосон пийжүү гарч ирлээ.

Тэр шөнө Хулхи Жагайгийн сэтгэлд нэгэн бодол төрсөн билээ. Пийжүү уугаад тайван дугхийж байсан Төмөрийг яг хамарт нь тулгаж байгаад нэг амьсгаагаар ёроолыг нь гартал гааздаж орхин, машин ачуулсан бичиг баримттай цүнхийг нь аван хилийн зүг гүйлээ. Төмөр нэг өндийж ирснээ "хэдэн муу хэлхээтэй төмөрнөөс болж хүн алах нь шив дээ" гэж гиншээд эргэн уналаа.

Хулхи Жагай ингэж гааздан хулхидах аргыг хэдэн жилийн өмнө Эрээний нэг лаг хужаад хоёрын хоёр дараапан польтон дээр нэг цэрэг шинээль нэмж өгч байж заалгасан билээ. Анх Говь комбинатын Дамдинжав дээр туршаад амжилттай болсон юм...

Эрдэнийг анх брокероор авсан жилийнхээ намар түүнийг дагуулсан Итгэлт цуглуулсан нэхийгээ тушаахаар хот орсон билээ. Урьд өмнө нь хүнтэй наймаа хийхдээ нүд амаа эргэлдүүлэн хуучин арифмометр торжигнуулан, сонингийн тасархай дээр элдэв тоо сараачин онигоонд орж явдаг байсан Итгэлт энэ жил үхэр хонины нэхийний наймаан дээр ажиллах праграмм суулгасан илэп топ" хэмээх бичил компьютер үүрсэн Эрдэнийг дагуулаад энэ тэрийг ширтэн харж явна. Зарим хүмүүс Итгэлтийг англитай болчихож гэж хүртэл цуурсан билээ.

Хотод ирснийхээ маргааш тэр хоёр "Туул- Жинпан" пүүсэнд очиж наймаа хийлээ. Эрдэнэ хашаанд үлдэж Туул-Жинпангийн менежер Шушмаа гэдэг залуутай арьс ширээ өгч авалцаж байлаа. Шушмаа монгол үгийг гаж буруу дуудна. Ард олны дунд өргөн хэрэглэгддэг зарим үг түүний амнаас гарахдаа нэгнийхээ чихэнд шивнэхэд ч зовмоор үг болж хувирна. Энэ бүхэн үнэн хэрэгтээ Шушмаагийн арчаагүй дуудлагын бүтээл бус, харин гэнэн цагаан сэтгэлтэй монголчуудыг гаж буруу дуудлагатай үгээр хөгжөөж анхаарлыг нь сарниулж байгаад жингийн тавган дээр чулуу тавих ч юмуу, тоолж байсан дэвсгэртээсээ сэм ханцуйлах зэргээр ашиг гаргаж явдаг ганц мэх нь байлаа.

Төрсөн нутагтаа зах зээлийн босгоор хөл тавьж, Говь-Алтайн хилийн боомтоор түмэнтээ нааш цааш явж бүр Хами аймаг хүртэл орсон Эрдэнийг ийм аргаар монжиж яавч болохгүй байлаа. Эрдэнэ түүний хэл зүйн алдаануудыг засахын зэрэгцээ "хам аа! Туухайг тэгж дардаггүй юм", "Мянгатын дэвсгэртийг ингэж сугалахаар баригдаад байдаг" гэхчлэнгээр царайг нь улалзуулан хорыг нь малтаж байгаад анхаарлыг нь сарниулан харин ч өөрөө арваад нэхий хий тоолуулан тушааж орхив.

Тэр үед пүүсийн хаалгаар УИХ-ын эрхэм гишүүн Довчин, саяхан шинэ байранд орохдоо авсан залуу эхнэр Гэрэлийгээ "нүдийг нь онийтол гоёод" дагуулан орж ирлээ. Хашаанд нэхий бөөндөж байсан Эрдэнэ, Шушмаа

хоёр тэдний анхаарлыг өчүүхэн ч татаж чадсангүй. Тэд шууд л пүүсний данжаадын офисийг чиглэв.

-Шушмаа минь чи буруу дуудаж байна. Чиний тэр танилцсан гээд байгаа алдарт уяач, их хурлын эрхэм гишүүний нэрийг "Хурыц" гэдэггүй, "Хурц" гэдэг. Айхтар үзүүртэй ирмэгтэй гэсэн үг шүү дээ. Тэгэхдээ нэр нь тийм боловч хүн нь сагсуу л болохоос зөөлөн эр гэдэг юм шүү.

-Оо оо тийм аа тийм. Нээлээ "Хуц" далгаа манай хүн зөөлөн хүн...

-Бас л биш. Нааадах чинь өөр юмны нэр. Алив тэр шээгтэй нэхийг аваад аль. Тэр хамгийн том. За наадахаа! Үнэрлээд орхи!

-Ой яа яа! Энэ мааюутай доофууны үнэрээ ?

-Хуцны шанель гэж ийм юм байх гэснээ Эрдэнэ ха ха хөхрөх нь Гэрэлийн чихэнд дуулдав.

"Яасан сайхан диктор хоолойтой хүн бэ! Базарын Цэдэндамбаа гуай юу даа" гэж Гэрэлд

бодогдоод эргэж харав. Тэр сайхан дууны эзэн бол араажавын сурвалжлагч, аргил сайхан хоолойт Цэдэндамба бус, Дуурийн чаатрын жүжигчин Баатарын дүрд яг тохирмоор гуалиг сайхан эр байлаа. Хүүхний нүд Эрдэнээс нэг хэсэг салж чадсангүй.

-Эхнээр ийшээ орьё гэж Довчинг хэлэхэд үл таних хүнийг ширтэж байгаадаа Гэрэл балмагдсан боловч "Та орж бай! Би нэхийний үнэ мэдчихээд ирье" гээд үлдлээ. Өөрийг нь сэтгэлдээ бодож явдаг эрчүүд олон байдгийг Гэрэл мэднэ. Гэвч тэд Довчингийн өндөр албан тушаал, Гэрэлийн "амбаардалт" хоёроос айгаад хавьтаж зүрхэлдэггүй тул нэгэн том хана хэрмийн цаана суугаа мэт сэтгэгдэл төрдөг болой. Гэтэл Эрдэнийг өнөөдөр олж хармагц тийм хана хэрэм байдаггүй мэт санагдаад эхлэв. Гэрэл эхлээд Эрдэнийг хараад л баймаар санагдаад ар талд нь баахан зогсов. Эрдэнэ ард нь гэнэт үл таних эмэгтэй зогсохыг мэдээд түүнийг сэжигтэй харснаа бүх хармайгаа шалгаж үзлээ. Гэрэл юу ярихаа мэдэхгүй баахан сандрав.

-Арьсаа хэдээр бөөндөж байна вэ?

-Авах хүнтэй бол ярина аа!

Гэрэл дуугүй эргээд явлаа. Ард нь:

-Гадаад яамны сайдын нэр Бомбоошүлэн биш шүү дээ! Зүгээр л Гомбосүрэн гэж хэл. Харин чиний наад хэлдэгтэй чинь холбоотой түүний тухай онигоо нилээд бий хэмээн Эрдэнийн тайлбарлан ярих аргил сайхан дуу хүнгэнэнэ.

Гэрэлийг дотогш ороход Итгэлт Довчин хоёроос гадна бас нэг сахалгүй хүн "хятад монгол ярианы дэвтэр" гарчиглан сууж байв.

-Би татварын ерөнхий газрын шалгалтын материалтай танилцаж байхдаа танай кампаний тухай уншсан юм байна гэж Довчин хорлонтой хэлэв. Тэгтэл Итгэлт:

-Би ч бас таныг их хурлын гишүүнд сонгогдохоор өрсөлдөж байхдаа тараасан "Монголын улсын нийслэл Улаанбаатараас доош нь ухсаар байгаад Америкийн нийслэл Нью Йоркоор гараад ирэх туннелийн төслийн" тухай ухуулах хуудасны сүүлийн таван бүлгийг нь гарчиглаж байсан. Бас Хятадыг өөртөө тайван замаар нэгтгэн Юань гэдэг их гүрэн байгуулах санаа ч бас сонин санагдсан шүү... гэж егөөтэйгээр хэлбэл Довчин гишүүний царай хувьсхийн суудлаа засав.

Гэтэл энэ үеэр пүүсний дэд данжаад ирлээ. Энэ данжаад мөнөөх сахалгүй хүнийг онцгойлон үзэж:

-Өө! Бандийт даргаа! Жа та нар танирцацгаа. Бандийт даргаа гуай их тусч көөн. Саяын тэр тогтоорд таны оруурж өгсөн заарт манай тун их хэрэг борсон шүү. Өө Оюубураг ажаа яагаад ирээгүй ээ! Бидэнд гомдсоон биш ээ...өө... Энэ жирээс эхрэн манай их данжаад дөчий саяа бишээ, наая саяаг жир бүр өгөхөөр борроо гэж Бээжингээс хэрүүрсэн..." гэж нэг амьсгаагаар дуржигнаснаа: -Өө би нэг юм мартах шахсаан... Өнөө бидний урсан нууцыг задарсан Жанжаацүлэн цаазаар авхуурсан!!!

-Үгүй ээ. Тэнсэнтэй гарсан

-Тэнээсээн!.... гэснээ..Ой ёо .. хэмээн нүдээ эргэлдүүлэн...: -Тэнээсээн. Тэнээд явсан. Өвчин туссаан! хо хо. Ямаал хоол өгсөөн? Зээт пүүсэнд оруулж өндөг идүүлсэн?

-Үгүй ээ, ялыг нь тэнссэн. Одоо гэртээ байгаа.

-Гэртээ. Ой яа яа.Тэр дахиад та бидний урсан нууцыг задарбар яана!

-Битгий ай! Тэрнээс айгаад байх хэрэггүй -Ай! Та ёсуугай баатар сэтгэртэй хүн баа?

Мөнөөх сахалгүй хүн тэгсгээд явах болов. Мань даргыг хужаа саатуулж:

-Ай ! би нэг юм мартаж шахжээ. Сая Хөх хот руу захиурж байж энэ сайхаан ярианы дэвтрийг авчируурсан. Түүний танд байдгаас олон өгүүрбэртэй. Та боргоож айрд! Банди дарга түүнийг нь аваад гарав.

Дэд данжаад эргэж орж ирээд -За Довчин даргаа. Энэ Итгэрт. Бид хоёр сүүрийн хэдэн жир наймий хийж байна. Хатуу гартай боровч буянтай бизнесмэн дээ.

-Дөрвөн жил би энэ хүнд идүүлж байгаа юм даа гэж Итгэлт ёжтой хэллээ.

-Хай бизнэсмэн хүнийг хуурвал бизнэс бүтэхээ бориноо шүү

-Харинч зааныг хаяж заан боддог гэж үгтэй юм даа гэхэд данжаад сайн ойлгосонгүй:

-Оо зааны ясаан савхаа ч бас манай дотор газар ч үнээтэй шүү гээд шар шүдээ ярзайлган инээв.

Г эрэл энэ зуур дэлгүүрээс торго авчруулан үзэв. Гэлээ гэсэн ч түүний сэтгэлд Эрдэнийн төрх л эргэлдсээр байв. Дэд данжаад "Хонконгод хийсэн юм", "Мэйго газрын нандин бараа" гэхчлэн үгээ олохгүй магтавч Гэрэлд таалагдах торго олдсонгүй.

-Шушмаа чи битгий дүрсгүйтээд бай! Хүүхэд боловч ийм программ дээр ажиллаж чадна гэж гаднаас Шушмааг дагуулан орж ирсэн Эрдэнэ хэлээд компьютерээ товшиж гарав. Түүний арван хуруукомпьютерий нхээ гар дээгүүр гүйж байгаа нь "Хунт нуур" бүжгэн жүжгийн зулзган хунгуудын бүжиг мэт.

-Ёстой л праграммист хүний хуруу байна даа гэж Довчин хэлэв.

-Миний Сээконд хээнд даа гэж Итгэлт онгиргон хэлэв.

-За ийм л байна даа гэж Эрдэнэ хэлээд компьютерийнхээ дэлгэц өөд заалаа

-Тиймээ тийм гэж Шушмаа уцаарлангүй хэллээ.

-За Эрдэнэ юу болов?

-Энэ Шушмаа вирустсэн праграмм оруулж байгаад дундаас нь 5002 төгрөг 58 мөнгө шомбодох гэж байхгүй юу?

-Шушмаа минь чи хүнээ олсонгүй дээ гээд Итгэлт тас тас хөхрөв.

Эрдэнийг хулгайн нүдээр харсаар байгаад Гэрэл гартаа байга торгонд олигтой анхаарч чадсангүй.

-Эхнээр санаанд чинь таарах юм байна уу? гэж Довчинг асуухад:

-Үүнийг авдаг юм билүү гэж хамгийн түрүүнд дайралдсан торгыг заав.

-Би бас авдар еэвэн авна шүү! Авчруулаарай гэж Итгэлт хэллээ. Гэрэл нөхрийнхээ чихэнд:

-Энэ хоёрыг хүлээн авалтад уриач гэж шивэгнэв.

-Та манай өчүүхэн бааранд маргааш морилон очиж гийгүүлнэ үү?

-Бас таны сээконд хээндэг гэж Гэрэл нэмлээ.

-Бид хоёр чинь маргааш ноолуур Мандахынд уригдсан байх аа?

-Биднийг бас урилаа гээ биз дээ гэж Гэрэл баяртаи нэмлээ.

-Тиймээ

-Бид тэгвэл маргааш тэднийд уулзахнээ гэснээ Довчин: -За данжаад чи манай руу хоёр авдар "талын хар"архи, зургаан лонх пийжүү, хоёр тор өвгөнт явуулдаг юм шүү гээд гарч явлаа.

Тэднийг гарснаас хойш Итгэлт нэг хэсэг дуугүй сууснаа:

-Эрхэм гишүүний хатагтайн мэлмий, Галсангийн гурван шүдтэй дэгээг Тамирын усанд чапаак хөөж байгаа юм шиг чамаас салахгүй байхыг харав уу? гэж асуув.

-Бүү мэд, огт ажигласангүй гэж Эрдэнэ ажиггүй хариулав.

-Тааз нь гэж янзтай ... гэж Итгэлт сэрэл нь хөдөлсөн байдалтай хавчиганан хэллээ.

Дараа нь гаднаас авдар еэвэн оруулж ирэхэд Итгэлт нэгийг авч хазснаа:

-Чулуу шиг хатуу золиг шивдээ гээд данжаад руу харлаа.

-Хатаагүй ээ. Тийм ёсоон хаа байна.

-Тэгвэл өөрөө хазаад үзээч?

Данжаад түүнийг хазаж үзээд:

-Энэ бол гурил хатсан хэрэг биш, манай дотор газрын "хань" үндэстний гурилын онцгой чанар гэхчлэн тайлбарлав. Итгэлт хариуд нь:

-Чи энэ чулуу шиг гурилаараа бороохой хийгээд өнөөдөр ялаа шиг олширч байгаа цагдаа нарт зарвал том бизнес болно доо хэмээн егөөдлөө.

Итгэлт хотод ирснийхээ маргааш Монгол улсын ерөнхийлөгчид бараалхаж санал хүсэлтээ ярина хэмээн Эрдэнийг дагуулан явжээ.

Тэд явсаар хүлээн авах байранд ирвэл үй олон санал хүсэлт гаргагчид цугларчээ. Тэгтэл нэг том тамга хармайлсан дарга ирснээ:

-Өнөөдөр ерөнхийлөгч төрийн чухал албатай тул биеэр уулзахгүй видеоогоор уулзана, шууд золгохгүй сунтгаар мэндчилнэ гэж зарласан нь ерөнхийлөгчийн захидал мэдээллийн албаны дарга Баасанжав гэгч гэнэ. Эрдэнэ учрыг олж ядан гайхаж:

-Одоо яадаг билээ? гэхэд Итгэлт:

-Ялгаагүй! Ер нь ерөнхийлөгчөөс биелүүлчихэж болмоор юм хүсдэг хүн тэртэй тэргүй байдаггүй юм. Мөнгө зээлдүүлээч гээд л хүмүүс ирж байгаа. Энэ олон гуйлгачны хэнд нь мөнгө зээлдүүлэх вэ дээ! Харин би бол татварын хуулинд өөрчлөлт оруулж өгөөч гэж гуйх гэсэн юм. Гэхдээ бүтэхгүй гэдгийг нь мэдэж байна. Гагцхүү намайг энэ талаар хөөцөлдсөн гэсэн баримт л үлдвэл хаваасаг! Надад паакт нь л хэрэгтэй.

Тэгтэл нэг хархүү том зурагт авчран тогонд залгаад асаатал, ерөнхийлөгчийн дүрс тодроод:

-Миний ард түмний эрхэм хүндэт өргөдөлчин, гомдолчин, саналчин та нар минь сайн байна уу? Та нарын маань санал арвин, гомдол гүн, өргөдөл зузаан байхын билэгт ерөөл дэвшүүлэн мэндчилье! гэж хэлэнгүүт гаднаас "Бостон" хэмээх алдарт ноосон даавуугаар хийсэн ханцуй бүхий гарыг сугавчилсан нэг залуу орж ирээд түүнийгээ сунган хүн бүртэй тавааришуулж эхлэв. "Энхсайхан дарга өөрөө байх шив дээ" хэмээн хүмүүс хоорондоо шивэр авир хийн мөнөөх хиймэл гар руу хуйларцгаалаа. Тэр гарны араас нарийхан кабель зүүгээстэй байх ба олны хэлэлцэх нь "тэр кабелийн нөгөө үзүүрээс ерөнхийлөгч атгаасгай байдаг" гэлцэнэ. Эрдэнэ Итгэлт хоёр тэрхүү хуванцар гарнаас атган мэндчилэв. Итгэлт саналаа бичгээр гаргана гээд том цүнх дүүрэн саналаа барьсаар гарч явтал нэгэн дугуйтай хүүхэд хүүе гэхийн зуургүй шүүрч булаан булан тойрон алга болов. Итгэлт:

-Хүүеэ! хэмээн нэг том орилсноо:- За, болж болж! Муу хулгайч урам нь хугарсандаа яах бол?! ... хэмээн тавлангуй хэллээ. Тэрээр эргэж очоод саналыхаа төслийг бичсэн дискийг гарган, хэвлэх-хувилах төлбөрт үйлчилгээний хүүхэнд хандан: - Нэг мөсөн зуу хувилчих гэлээ.

Тэднийг гарч явтал өмнө нь явсан хоёр хүний нэг нь:

-Саяын тэр сунтгийн гарнаас залгасан кабелийн нөгөө үзүүр нь ерөнхийлөгчийн ширээний хөлнөөс уяатай байдаг гэж үнэн болов уу? гэхэд нөгөө нь:

-Битгий сөрөг суртал нэвтрүүлэг хийгээд бай! Үнэхээр түүний үзүүрийг ерөнхийлөгчийн баруун гарын бугуйнаас мөнгөн гаваар гавласан байдаг юм гэнэ билээ.

-Та өөрөө үзээгүй шүү дээ гэж нөгөөх нь хэлж байна. Итгэлт энэ бүхнийг сонсоогүй дүр

Үзүүлэн:

-За ингээд бүх ард түмнээс сонгогдсон ерөнхийлөгчийн сунтган гарыг арван долоо дахь удаагаа барин мэндчилэв шив дээ гэж хөөрөв.

Тэр орой Итгэлт, Эрдэнэ хоёр "Ноолуур Мандах" гэдэг айлд зочлуулах юм болов. Мандах шинэхэн танилцсан Итгэлтэд баярхах гэхдээ "Эрээн боов" гэдэг гадаад гуанзангаас япон тогооч хөлслөн авчирсан байжээ.

-За Эрдэнэ минь Улаанбаатарын муусайн зээлийн баячууд өрнөөс өөр юмгүй мөртлөө муухай сагсуу шүү. Нэрээ бодож юм үзсэн хүн шиг байгаарай! гэж захилаа.

Орой тэр хоёр заасан хаягаар нь очвол, хаалгаа тайлж өгсөнгүй. Хэсэг балбасны хойно нохой дагуулсан залуу болгоомжтойхон ирээд хаалганы цаанаас ярилцаж эхлэв.

-Бид нийслэл хотын тэргүүн баян ноолуур Мандах авгайг сурж явна

-Та айл андуурч

-Өөрийнх нь зааж өгсөн хаяг энэ юмсан

-Эндээс нүүчихсэн шүү дээ

-Өө харла гэж. Хаа буугаа бол!

-Латин Америк руу дүрэвчихсэн. Эргэж ирэхгүй, бүр явсан.

-Хүү минь битгий нохойтоод бай. Би өчигдөр уулзсан хүнээ эрж явахад...

-Тэгээд яагаав. Өнөөдрийн Бээжингийн онгоцоор ниссэн!

-Яасан хачин хүн бэ! Цайллагад урьчихаад... хэмээн эргэх гэтэл өнөөх залуу үүнийг сонсоод араас нь дуудаж:

-Таныг хэн гэдэг вэ?

-Өчигдөрхөн нь л намайг энэ айлд уригдаж байхад Архангайн дойлуур Итгэлт гэдэг байсан юмсан.

-Байз байз бид таныг таньсангүй өршөө гээд өнөө залуу тэднийг дагуулан хашааны араар тойрч явах зуураа: -Энэ үнэхээр таны сурж байгаа айл мөн. Баян хүнд хорссон атаархсан хүн олон болохоор бид ийм аюулгүйн арга хэмжээ авч байдаг юм гэж тайлбарлаад, хашааныхаа нэгэн банзыг сугалан авч түлээний пингээр дамжин гэрт оров.

Баян Мандахад атаархсан, хорссон хүн байдаг нь үнэнтэй ч хэрэг дээрээ түүний тавьсан өр, зээл Монгол улсын жилийн төсвөөс аль хэдийнээ давсан тул хугацаа хэтэрсэн зээлээ хөөцөлдөх банкныхан, хулхидуулсан ноолуураа нэхсэн ганзагачидаас нуугдахын тулд ийм байдалд орсон юмсанжээ.

Мань хоёрыг ороход Мандахынд бараг бүх зочид цугларчээ. Мавдах ч Итгэлтийн өмнө үнэхээр баярхах гэсэн нь илэрхий. Гурван өрөө байраа битүү хивсэлж, таазандаа хүртэл хивс хадсан ба тэр нь зарим газраараа наалт нь ховхрон хүлхийсэн төдийгүй дутсан газар нь

ноолууран хөнжил залгажээ. “SONY” зурагтаа пойлоосоор бүрүүлэхдээ спийкерийг нь битүүлсэн тул дэлгэц дээр мэргэжлийн хүмүүсийн "немой кадр" гэж нэрлэдэг дуугүй дүрсүүд жирэлзэх ба Мандах эхнэр хоёр харин ч түүгээрээ гайхуулах байдалтай. Итгэлт бүгдтэй ихэмсгээр мэндлээд хойморт суулаа. Итгэлтийн доод талд шашин, улс төрийг хослон эрхлэгч лам Баасан, дараа нь Эрдэнэ суув. Довчингийн доод талд эхнэр Гэрэл нь, түүний дор ардчилсан хувьсгалын үеэр өлсгөлөнд орж алдаршсан, Ардчилсан холбооны Дарьсүхбаатар гэдэг хүн суулаа.

Итгэлт үйлчилж байгаа охидын мини юбкийг харангаа:

-Манай охидын сүүлийн үед өмсөж байгаа юүүпэг ч өнөө чи бид хоёрын орж балардаг Бангкокийн секс шоуны охидыг санагдуулам оггор болжээ, хи хи гэв. Эрдэнэ:

-Харин ээ? Арай ч урт юм уу хэмээн хээв нэг хэлэв. Гэрийн эзний царай хувьсхийн “Бүр Тайланд хүртэл орчихож, их эр юм” гэж бодов. Гэвч тэр тийм амар барьц алдсангүй

-Би дээхнээ нэг Герман яваад гайгүй эдэлсэн "Бенц" ноолуураар зодож авбаа... гэж ирээд л юм үзэж нүд тайлснаа ярьж гарах гэтэл:

-Чи хулхидуулаагүй л бол их юм. Германчууд хэцүү. Бид тун саяхан Франкфурт - Берлиний хооронд явж байгаад цуваанаасаа таван вагон алдчихсан шүү. Уул нь олон улсын шүүхэд хандвал олддог л гэж улс ярьдаг юм билээ. Тэгээд шальгүй юмны хойноос хоёцөлдөх зав бидэнд хаа байх вэ! хэмээн давуу байдлаа эргүүлэн авав.

-Би хөөцөлдөө гэхэд та л болоогүй шүү хэмээн Эрдэнэ эргийг нь улам чангалав.

Удсан ч үгүй хүмүүс халамцан улаан зээрд болж эхлэв. Эрдэнэ тэнд байсан мандолиныг сурмагаар цохин "Битлз"-ийн "Еэстэдэй" гэдэг дууг хөөмийлэв.

-Ёстой Лучиано Поварити шиг хоолойтой хүн юм аа гэж Баасан ламыг хэлэхэд Итгэлт тийм ямар юм байдгийг мэдэхгүй боловч:

-О Кей, яг тийм шүү. Та яг онож хэллээ гээд хөхрөв.

-Цэвэр теонор байна гэж Дарьсүхбаатар хэлэв. Энэ хүн ардчилсан холбоонд анхнаасаа зүтгэж ихэд нэр гарсан ба юм л бол "Биднийг анх өлсгөлөн зарлаад байхад..." гээд л эхэлдэг юм.

-Бид амь насаараа дэнчин тавьж тавьж өлсгөлөн зарлаад авчирсан ардчиллын хүчээр манай мал эзэндээ очоод, эзэн Чингисийн үеийн нүүдлийн иргэншил дахин сэргэж, Чингис хаанаа тодруулан ширээнд залаад, нөлөөгөө тэлэн Адриатик тэнгис хүрэн алдаггийн даваан дээр муусайн Ху нам сонгуульд ялаад хамаг юм баллачихлаа. Хэрвээ тэгээгүй бол өдийд бид НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлийн гишүүн болчихсон байхгүй юу! гэхэд Довчин шүүрэн аваад:

-Дэмий юм ярих тусгүй. Хэрвээ манай Ху нам ялаагүй бол ХКН нам бидэнд нүүр буруулж Эрээний боомтоо хаагаад ард олон турж үхэх байсан шүү. Ард олны заяа түшсэн л хэрэг

-Гайгүй байлгүй. Та нар сөнөн мөхөж байгаа соц системийн тасархай болж мөхөх гээ юү?

-Дэмийр. Ард түмэн биднийг сонгосон юм. Ард түмний дэргэд чи юу юм бэ? Тэгэж ярих юм бол одоогийн засгийн бодлогыг Их хурал хэлэлцээд зөв гэсэн юм шүү. Дарьсүхбаатар чи өчүүхэн өлсгөлөндөө эрдээд дэндэж байна. "Өлсгөлөнгөөр байгуулсан ардчиллыг өлсгөлөнгөөр хөгжүүлж болдоггүй" гэсэн үг бий юм шүү хэмээн Довчин хэдэн жилийн өмнө нэгэн дотор хүнээс сонссон үгээ хэлж орхив. Тэггэл минчийтлээ уурласан Дарьсүхбаатар ширээний бүтээлэг рүү ухасхийв. Энэ мөчид цаадуул нь таваг аягаа сурмагаар шүүрэн авлаа. Дарьсүхбаатар агсам тавихдаа ингэж ширээний бүтээлэг хуу татахдаа сурмаг нэгэн ба цаадуул нь хэд хэдэн удаа томоохон төлбөрт орсныхоо эцэст занг нь мэддэг болж аяга тавгаа өрсөн шүүрч авах эрдэмд нэвтэрчээ. Дарьсүхбаатар гартаа хөглөрөн буй дан бүтээлгийг урамгүй харж зогсов. Тэр бүтээлгэний дороос цоо шинэ өөр бүтээлэг гарч ирсэн харагдана. Тэрнийг хуу татахад мөн цаана нь бас хэд хэд бий нь илэрхий. Ингэтэл Гэрэл: -Ардчиллын төлөө амёб боож үхэв гэгчээр та нар яах нь вэ? Улс төржихөө болиоч! Эрдэнийн дууг дахиад нэг сонсмоор байна гэлээ. Энэ зуур хэрүүл зогсож Эрдэнэ "Аавын минь зулай" гэдэг дуу дууллаа. Тун удалгүй дахин нэг хоол ирлээ. Итгэлт түүнээс амссанаа: -Чи бид хоёрын Сидней хотын Хилтон буудалд идсэн хоол мөн шив, тиймээ Эрдэнэ ээ? гэв.

"Энэ Итгэлт саяхан баяжсан нэхийчин гэх чинь билээ. Хэдийдээ тийм хол газар явав гэж! Намайг давж байгаа бололтой. Янзыг үзье байз" гэж гэрийн эзэн амандаа бөвгнөөд гарлаа. Энэ зуур Эрдэнэд "үхэж" эхэлсэн Гэрэл дэргэд нь ирж суугаад "Таныг дахиулья" гэж шалсаар байгаад хэд хэд дуулуулав.Сүүлд нь:

-Би согтсон шиг байна. Толгой хэдхэн секундн завсарлагатайгаар өвдөлт өгөөд... бас хүчилтөрөгчийн хангамж дутагдаад байх шиг гээд бостол Довчин ухасхийж

-Би хамт гаръя гэв. Гэрэл түүнийг хориглож:

-Чи сууж бай! гэснээ Эрдэнэд хандаж -Та надад үйлчлээд өгөөч! гэлээ. Эрдэнэ дагалдан гадаа гарвал хүүхэн түүнийг налж:

-Яасан сайхан шөнө вэ? гээд нүүр өөд нь харав -Хн. Агаар дахь азотын эзлэх хувь зөвшөөрөгдөх хэмжээнээс давжээ.

-Тэр ч тэнгэрийн буруу биш. Дулааны цахилгаан станц, станц хариуцсан шадар сайд Пүрэвдорж хоёрын буруу байхаа гээд түүнийг улам налахад Эрдэнэ зайлсхийв.

-Та битгий зугтаад бай! Би хүний хувцас руу бөөлждөггүй юм аа! гээд улам налав.

-Та их согтжээ. Таны цусанд байгаа алкоголь зөвшөөрөгдөх хэмжээнээсээ хэтрэх гэж байна.

-Тийм байх аа миний цээж аймаар халуун оргиод... алив та гараа хийгээд үз дээ... аан яасан сайхан ... хүйтэн юм бэ? .. наад зүрхэн тушаа чинь бүр халуун... доошоогоо улам халуун болоод байгаа биз. Бүр доор аягүй хэцүү байна аа? гэтэл Эрдэнэ гараа суга татан авч:

-За орцгооё! Цаадуул чинь байхгүй хойгуур архиа булагнаад уучихаж магадгүй хэмээн огцом хөндий хэллээ.

Эрдэнэ гэнэт гал тогооны өрөөнд хоёр хүн нэгэн ноцтой зүйлийг хэлэлцэхийг поорчгоор сонсов

-Наад хоолой хошного, пичээнъ, усан үзэм бүгдийг нь холиод орхи. Тэгээд хаана идэж үзсэн гэж шаахыг нь харъя

-Жа жа тэр борноо борно

Энэ яриаг сонсоод юу болох гэж байгааг таамагласан Эрдэнэ бушуухан гэрт орлоо. Тэгтэл удсан ч үгүй хоол орж ирлээ. Ноолуур Мандах:

-За энэ хоолыг Японы эзэн хаан их таалдаг байсан юм гэнэ лээ. Би ямар Япон явж түүнийг идэж үзсэн биш. Энд тэндгүй явснаараа та л сайн мэдэх байх гээд Итгэлт рүү ёжтой харав.

"Одоо юу гэж бурах бол" гэхээс Эрдэнийн дотор харанхуйлав. Итгэлт хоолноос хэд тамшаалж үзснээ:

-Нээрээ энэ чинь Монголыг хамаарсан түшмэл Шимүзүгийн Токиод барьсан зоог дээр идэж байсан өнөө хоол мөн байна гээч, Эрдэнээ! гэхэд Ноолуур Мандах хоржоонтой инээж:

-Итгэлт ч мөн газар үзэж нүд тайлсан хүн юм аа, эхнээр! гэлээ

-Итгэлтээ! Чи согтоод андуурч байна. Чи бид хоёр огг амсаж үзээгүй хоол байна гэхэд сая давслалт хэтэрснийг анзаарсан Итгэлт дорхноо сэхээрч:

-Нээрээ тийм бололтой. Согтоод лэвайс жийнсийг хуурамчаас нь ялгахаа больж.

-Японы эзэн хааны л дуртай л хоол гэдэг юм даа гэж гэрийн эзэн давтан хэлэв.

-Зальтай япон тогооч ямарч хүнийг бөөр зүрх. ходоод хошногоор хуурч чадна. Дотор нь жимс, печений амт хүртэл холилджээ. Би л лав ийм хоолыг хаан өөрөө өгсөн ч идэж чадахгүй гээд тавгаа түлхэв. Энэ бүхнийг хараад Итгэлт учрыг бүрэн сэхээрч:

-Танай тогооч олон хоол хийдэг хүн болох гээд таныг чадаж орхисон шиг хэмээн тавлаад цааш нь идэхгүйн тэмдэг болгож сэрээ хутга хоёроо тавган дээрээ зэрэгцүүлж тавьлаа...

Ноолуур Мандах ичсэндээ минчийтэл улайгаад өмднийхээ цахилгааныг татлаа. Тэнд Итгэлт шиг баярласан, Гэрэл шиг настрийндсэн, Дарьсүхбаатар шиг уурласан, гэрийн эзэн шиг "бөгс улайсан" хүн байсангүй.

-Та нар муусайн Ху намынхан, олон аавын хүүхдүүд ходоодны раактай болж байж олж авсан ардчиллыг баллаж байна. Бид хамаг юмаа Оросоос асуудаг байсан Монгол орныг дэлхий ертөнцийн өмнө нээж, Америктай хүртэл харилцуулсан. Гэтэл та нар ОХУ -д визтэй

зорчдог болгоод, одоо Хятадыг визтэй болгохоор завдаж байна... хэмээн Дарьсүхбаатар гэнэт хашгирлаа.

-Гадаад харилцааны асуудлыг ард түмний сонгосон УИХ шийднэ гэтэл дүрсхийн уурласан Дарьсүхбаатар:

-Яана гэнээ ... гээд ширээний бүтээлэг рүү ухасхийв. Яг энэ үеэр гаднаас Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч хэмээх нэгэн жавхаалаг, өнгөт хархүү орж ирээгүй бол юу болох байсныг бүү мэд.

-Өнөөдөр ерөнхийлөгч 1678 хүнд одон тэмдэг шагнаж, тэрнийгээ гардуулаад, би тэнд байлцсаар дөнгөж сая тарав гээд ихэмсгээр мэндчилэн суув.

"Аа өнөөдөр төрийн чухал албатай гэсэн нь энэ юм байна" гэж Эрдэнэ өөр зуураа бодов. Тэр хүн цай идээнээс болгоох зуураа, одоо төрийн одонгийн агуулахад хоёр сая гаруй одон байгаа нь манай ард түмний хэдэн үед хүрэлцэх тухай, Ерөнхийлөгч дараагийн сонгуулиас наана бүх сонгогчдоо шагнаж амжина гэж бодож байгаа тухай, мөн удахгүй хэний эхнэр, хэний нөхөр гавьяат болон ардын цол хүртэх гэж байгаа тухай, мөн өнөөдөр нэг хүнд гавьяат цол өгөөд шагналаа гардуулах гэтэл тэмдэг нь дуусчихаад, тэнд олон байснаар нь улсын баатрын тэмдэг зүүж өгөөд сүүлд нь зарлигаа зассан, цаад хүн нь "сохорсон биш завшив" гэдгийн үлгэр болсон тухай зэрэг төрийн ордонд болсон сүүлийн үеийн сониныг ярилаа.

Шөнө орой болсон хойно Итгэлт, Эрдэнэ хоёр явах гэхэд Гэрэл нөхрийн чихэнд үг шивнэв.

-Та хоёрыг маргааш манай бааранд хүрэлцэн ирэхийг урьж байна хэмээн Довчин худал инээн хэллээ.

-Бид өглөө эрт нисэх гээд онгоцны билет авчихсан, дараа л больё гэж Итгэлт хэлэв

-Унавал яана аа! Та нар айдаггүй юм уу? гэж Гэрэл дуу алдсан боловч, саяхан онгоц мөргөж унасан Марз уулнаас наана Архангай аймаг байдгийг дуулаад тайтгарлаа. Арга нь барагдсан Гэрлийн нүдэнд нулимс бүрхэж "Пондс" тосыг нь угаасаар хоцорлоо. Гэрлийн сэтгэлд зуун лааны чийдэн шиг гэрэлтэн тодорсон Эрдэнэ Галилейн сүүлт од шиг харваад явчихсан гэж бодохоор дотор нь тог тасарсан мэт харанхуйлж байвч хэдэн сарын дараа Эрдэнэтэй бааранд сууна, тэгээд буудал цагаар хөлслөн унтана гэдгээ яахин урьдчилан мэдэх билээ

Эрдэнэ Тамир, Чулуут сумаар ноос цуглуулахаар явсны маргааш Должин Улаанбаатарт багшийн коллежид суралцахаар явсан Хонгор, Бат хоёрыг эргэхээр автобусаар явлаа. Должин хоёр гурав хоногоос нааш ирэхгүй байв. Харанхуй болов. Долгор захирлынд хоол хийж байв. Итгэлт Солонго тэр гурав хамт сууж гуляш идлээ.

-Эрдэнээгээ хүсэж байна уу? гэж Итгэлт хөгжилтэй асуув

-Яршиг, ямар гаж донтой биш. Яваад ганцхан ч хоноогүй байхад...

-Би өнөөдөр Эрдэнийг чинь орлож үзэх үү дээ.

-Ёо ёотой юм яриад гэж Долгор хэлээд үүд рүү явлаа. Өглөөнөөс хойш эрс хувирсан Итгэлтийн тачаангуй нүдийг Долгор аль өглөөнөөс хойш ойлгосон бөгөөд өдөр нэг ажилтнаа аптека руу гүйлгэн гондоом авахуулж байхыг харснаас хойш учрыг лавтай ойлгон сэтгэл хямарсан билээ.

-Долгоор охиныг унтуулаад яв гэж захирангуй хэллээ.

Долгор аргагүйдэн эргээд Солонгийн орны өмнө сууж:

-Эрт урьд цагт Микки маус төрсөн өдрөө тэмдэглэх гэж найз Минни маусаа гэртээ урьж гэнэ ээ... хэмээн үлгэрээ эхэлсэн боловч сэтгэл нь өөр зүйлд эзлэгдээд нэг юм аа байн байн давтан ярьж байв.

Ядарч яваа цагт тусалсан Итгэлтийг уурлуулах хүсэл Долгорт байсангүй. Итгэлтийг авьяаслаг бизнесмэн гэж Долгор хүндэлдэг ч, түүний чалхыг сайн биш гэж боддог байжээ.

Итгэлт Долгорын хөдөлгөөн бүхнийг ажин өнөө шөнө л "гүйцэтгэнэ" дээ гэж баттай шийдсэн байлаа. Гэвч энэ бүхнээ эхлэх гэж хэд гурван үг хаясан боловч амжилттай болсонгүй. Энэ хэргийг Эрдэнэд мэдэгдэхгүй хийх нь чухал байлаа. Хэдийгээр "Гахай туйлаад гадаадад гарахгүй, нохой гүрийгээд ном уншихгүй" гэж бодогдовч Эрдэнэ мэдэж хэл ам гаргавал, өнгөрсөн жил аймгийнхаа сахилга томоотой хар хүн шалгаруулах тэмцээнд түрүүлж байж авсан "Аймгийн журамт эр" цолонд тусгүй байлаа

Охин нь унтсан гэдгийг мэдсэн Итгэлт шууд Долгорын дэргэд очиж гарыг барьснаа бугуйг нь барьж улмаар булчинг нь барив. Долгор эсэргүүцэн Итгэлтийг элэгдсэн боловч цаадахь нь үүнийг урьчилан тооцоолоод өвөртөө зузаан ном хийсэн байжээ. Тэд удаан ноцолдов. Итгэлт сүүлд нь тавьж: -Би та нарт маш их юм зээлдүүлсэн. Нэг өглөө бүгдийг нь нэхээд шүүхэд өгчихөж чадна шүү гэв.

-Би хүсэхгүй байна шүү дээ

-Би дор нь хүсэл төрүүлээд өгье, алив

-Болохгүй ээ. Хүүхэд олчихвол яах юм бэ?

Итгэлтийн дотор зарсхийн “нээрээ сүүлд нь хүүхдийн тэтгэвэр гээд хамаг байдгийг

хоослох санаа энүүнд төрөөгүй гэх газаргүй” гэж бодогдов. Тэгснээ:

-Зүгээрээ надад аягүй сайн, швед гондоом бий.

-Цоорчихвол яана!

-Гайгүй ээ. Өмнө нь би олон удаа Дул... гээд Итгэлт амаа барив.

Долгор гараас нь мултран гүйж гарлаа. Долгор гэртээ ирээд чийдэнгээ унтраан хэвтлээ. Гэнэт чийдэн асахыг мэдрэн хар дарж цочин сэрэв. Гэтэл өмнө нь арсайтлаа инээсэн Итгэлт зогсож байлаа. Итгэлт Должорыг гялс тэврэн аваад "Халуун хөнжилд" орчуулж тавьсан "Кама судрын" нэгэн позицоор массаж хийж эхэллээ...

Итгэлт буцаж явахдаа гадаа Дулмаатай таарлаа.

-Иргэдийн болон улсын нууцыг хадгалах Монгол улсын хууль саяхан гарсан шүү гэж сануулаад өнгөрөв.

Долгор энэ тухай нөхрөөсөө тас нууя гэж шийдэв. Хэдэн хоногийн дараа хоёр машин ноостой Эрдэнэ ирсэн нь хөөрхий Должинг өрөвдөн харж чадахгүй байсан Долгорт шинэ зовлон нэмлээ.

Эрдэнийг орж ирэхэд Долгор доошоо харан уйлав. Эрдэнэ хөмсөг зангидан эхнэрээ ширтснээ:

-Яасан! СПИД-ийн шинжилгээ зүгээр үү?

-Зүгээр ээ! Би чиний юуг ажиллагаагүй болчихож гэж зүүдлээд...

-За за! юундаа нь санаа зовдог юм бэ? Эмч нар намайг дал хүртлээ чалх чинь муудахгүй гэж байсныг чи санаж л байгаа биз дээ гэлээ.

Итгэлт сүүлдээ баярхаж байн байн хүлээн авалт хийж зоог барих болжээ. Нэгэн удаагийн найр хөл хөгжөөн ихтэй байлаа. Цоо шинэ хөх лээвчигтэй Дулмаа үе үе хиймэл шүдээ яралзуулан инээмсэглэж "Би сайхан хүүхэн шүү" гэж гайхуулах мэт архи дарс зөөж үйлчилнэ. Орсон хүн бүр Итгэлтийн нүнжигтэйг гайхах боловч энд тавьсан архи дарс боов чихрийг цөм гааль дээр хураагдаад шатаагдах гэж байхад нь устгах үүрэгтэйгээр зүгээр авсан төдийгүй "устгасны хөлс" хэмээн нэлээд төгрөг дундаас нь унагаасан гэдгийг хэн ч сэжиг авсангүй.

Орой болоход Итгэлтийн гэр хүнээр дүүрэв. Эрдэнэ "Эрэгтэй бор харцага", "Түмний эхнэр" зэрэг рок- поп дууг дуулж олны талархалыг хүчээлээ. Энэ үед гаднаас Бадарч ахлагч, эвлэлийн үүрийн дарга хийж байгаад саяхан лам болсон Цамбыг дагуулан орж ирлээ. Тэрбээр урьд нь Дулмааг МХЗ Эвлэлийн гишүүний манлайллыг нь шалгана хэмээн дуудаж ирүүлээд олон ч удаа өрөөндөө хонуулж байсан билээ. Цамба лам болоод тун удаагүй боловч Дулмааг санаад хамбаасаа арай гэж чөлөө аван энд иржээ.

Лааз пийжүү уугаад хацар нь улайж нүд сэргэсэн Дулмаа улам ч хөөрхөн болсон

харагдана. Дулмаагийн нөхөр Галсан авгайгаа хардах нь бүү хэл аягатай архи нь амаа олохгүй болоод "манай Итгэлт ах шиг есийн тос даасан баян хүн манай улсад байтугай Төв Азийн бүс нутагт байхгүй" гэж бувтнавч хэн ч түүнийг үл сонсоно. Тэгснээ гулжийн унахад Эрдэнэ тэврэн гарав.

Цамба Дулмааг "гараад ир" хэмээн хэд дахин пейжирдсэн боловч цаадахь хариу өгсөнгүй. Гэвч сүүлд нь өөрөө "гарья" хэмээн Цамба руу пейжирдээд үүд зүглэхэд нь Цамба дагалаа. Цамба сурсан зангаараа түүнийг жижүүрийн ширээн дээр хэвтүүлэх гэтэл шорон өсгийтэй туфлиэрээ эмзэг газар лүү тийрэх нь тэр. Цамба дуу алдан гиншиж:

-Дулмаа Чи яаж байна!... Энэ наддаа хэрэг... Члмайг биш ч өөрийг... Дулмаа минь гээд тэмтэртэл хүүхэн аль хэдийнээ алга болжээ.

Галсанг унтуулаад буцаж явсан Эрдэнийн хажуугаар Дулмаа гүйж өнгөрсөн ба Цамбын дуудахыг ч тэр сонсчээ. Эрдэнэ түүний энэ энгэр задгай байдалд маш их жигшив. Гэрт орсон хойноо Дулмаа Эрдэнэд том стакан дүүрэн архи барьж "Дууны дугараа" хэмээв. Эрдэнэ ууртайгаар ширэв татаж:

-Би уухгүй гэв.

-Дуулах хүнд битгий шах! гэж Итгэлт хэлээд тал зассан нүдээр түүнийг харав. Тэгснээ "За хө нутгийнхаа дууг дуулаарай" гэж шивэгнэв. Эрдэнэ микрофоныг шүүрэн авч:

-"Ерөнхий сайдын нугтаа..." хэмээн долгилуулан дуулж эхлэв. Нүдэнд нь Алтай хотын хэдэн жайжиг байшин, өмч хувьчлалаар аймгийн даргын давуу эрхээр хувьчилсан зочид буудал, бензээн холоонк, Хүнхэр зусланд болсон бүжиг, бардаак, Тарлан хайрханы орой дээрх релейны станц, Тайширын нурах шахсан нижгэр гүүр харагдах шиг болоод Дулмаад уурласан уур түр замхарлаа. Дараа нь олны алга ташилт дунд дахиад л өөрийнхөө үзэн ядалтын ертөнцөд бууж ирлээ.

Дулмаа эхэн үедээ Эрдэнийг огт тоодоггүй байсан боловч саяхнаас Говь-Алтайн алмаз Төмөртэй танилцсан ба түүнийг төрсөн дүү нь гэдгийг мэдсэнээс хойш үлэмж хүндлэн айж явдаг болсон билээ.

Маргааш нь Эрдэнэ Дулмаатай субботник дээр тааралдаад:

-Дулмаа минь чи яасан энгэр султэй хүүхэн бэ? Ямар орооны гичий биш дээ! Ийм хөөрхөн царайтай, тэгээд залуухан байж, гадаадын бэл хөрөнгөтэй жуулчдыг дэгээдэж хэдэн ногоон олохын оронд халаасандаа таван цаасгүй шалдан баньд нарт энэ сайхан биеэ үнэгүй хэрэглүүлж байдаг яасан дүүрчихсэн толгой вэ! Эр нөхөр, гэр бүлтэй хүнд чинь хэдэн ногоон олоод өмсөх зүүх, өрх гэрээ өөд татах хүсэл, шаардлага гэж нэг юм байдаг юм шүү хэмээн Эрдэнийг хэлэхэд хүнээр гуйлгуулж л явснаас загнуулж үзээгүй Дулмаа дүрсхийн уурлаж, нүд нь өлөгчин барынх шиг гялалзаад тоос сорогчоо чулуудлаа. Тэгээд:

-Өөрийнхээ эхнэрийг эхлээд захир! Чамд хамаагүй. Би өөрийгээ дамлана уу, 50%-ийн сэйл зарлана уу, зүгээр хандивлана уу танд падгүй хэмээн хашгирлаа. Эрдэнэ уурлаж:

-Хүнийг гүтгэвэл хуулиар шийтгэгддэг юм шүү гэв Дулмаа нүд нь эргэлдэн

-Үгүй ер өө! өөрийнхээ эхнэрийг Итгэлтээс нэг ч цент авалгүйгээр цэнгүүлээд байхад нүд шилтэй, чих чихэвчтэй явдаг байж хүний явдалд оролцоно гэнээ гэв. Эрдэнэ начин хийнэ гэж хамаг хахуулиа өгчихөөд тавын даваанд хальтираад уначихсан бөх шиг болов.

Нөхрийнхээ хаана юу хийж явааг хянах гэж аймгийн цагдаагийн даргыг гуйж баймаажин Эрдэнийн хүрэмний заханд оёулсан чагнах хэрэгслэлийнхээ тусламжаар энэ бүхнийг мэдсэн Долгор хярсан туулай шиг бүлтэгнэж суулаа.

Эрдэнэ гэртээ гүйн орж ирээд:

-Нээрээ сохор зоос ч аваагүй юу? гэж хашгиран асуув.

-Нээрээ гээд Долгор нүүрнийхээ "Пондсыг" нулимсаараа угааж эхлэв.

Эрдэнийн нүдэнд хорсол жигшил оволзон "Муу үнэгүй янхан" гээд алгадахад Долгор дөчин тавын плиткээ дамнан уналаа. Эрдэнэ эгшин зуур эргэн гараад мотоцикль асаан давхилаа. Тэгээд явж байхдаа дээр үед танилцсан, Ван данжаадын барлаг Чингисийн-Ялалт хэмээх өвөрлөгч залуу:

-Иш Эрдэнэ минь, чи намайг эхнэр ав л гэх юм. Тэрнийг чинь босс л хэрэглэнэ шүү дээ. Нэгэнт өөр хүн хэрэглэх юмыг би тэжээж алдагдалд ороод яах ч юм билээ хэмээн шулганаж байсан ба Итгэлт эрт орой хэзээ боловч Долгорыг чинь л үнэгүй ашиглах гэж чамд ийм их хөлс өгч байгаа юм гэх инээд тохуу хийсэн нь санаанд оров.

Эрдэнэ төр оройгоо хот орж хүүтэйгээ дөнгөж уулзаад:

-Аав нь Итгэлтийг хэмх нүдчихээд ирсэн. Эрэнгийнхэн сэжиг авахаас өмнө хил давах хэрэгтэй байна. Би эрхэм гишүүн Довчингийх рүү нэг утастачихаад "Ново" орно. Очмогцос факс явуулна гээд яаравчлан оджээ.

Эрдэнэ нийслэл хотод ирээд Долгорт араараа тавиулсан, Итгэлтэд монжуулсандаа гомдон дэлхийн биосферийг йонсфертэй хамтад нь зүхэж явлаа. Өнгөрсөн амьдралд нь тааралдсан бүх юм түүнийг хулхидсан, гол гаргасан бодогдон, коммунизм байгуулаад сайхан амьдрана гэж итгэсэн нь талаар болсон, дараа нь өмч хувьчлалаар юу ч ногдоогүй, анхны хайр нь бүтээгүй учраас шууд хоёр дахь хайртайгаа золгохоос өөр аргагүйд тулсан, өөрөө Долгорын анхных нь биш байсан зэрэг нь нүдний өмнүүр аймшгийн киноны кадрууд шиг жирэлзэн үзэн ядах сэтгэл нь цөмийн хурдасгуурт орсон мэт орчилдон дүрэлзэж байв аа. Ийнхүү алхаж явтал:

-Миистэр Эрдэнэ! хэмээн хашгирах бүсгүй хүний дуу тодхон сонсдов. Эрдэнэ гайхан харвал саяхан гадаад улсаас шагнуулсан "алтан луу" одонгоо зүүж, сүүлийн үед их л моодонд орсон цэнхэр өнгийн үйтэн хуаран шарваараар гангалсан УИХ-ын гишүүн Довчин, хүүхдэн эхнэр Гэрлийнхээ хамт машиныхаа дэргэд зогсон харж байлаа.

-Эрдэнэ гуай хэзээ ирэв? хэмээн Гэрэл бөөн хээл хахууль авдагийн даваан дээр тулсан төрийн зүгтэлтэн шиг баяр хөөрөө нууж ядан асуув.

-Саяхан ирлээ гэж сулхан хариулсан Эрдэнийн царайд их хэргийг нь бүтээж өгсөн хүний гар дээр тавих юмгүй хүний царайд илэрдэгтэй төстэй гунихрал тодорлоо.

-Манай муу амбаараар орохгүй яагаав?

-Зав муу. "Тайм из мани" болоод байна аа.

Гэрэл тэр нэгэн орой Эрдэнэтэй танилцаж дараа нь бардаак хийснээс хойш түүний үзэсгэлэнт царай, гайхамшигг чалх сэтгэлийг нь эзэмдэж түүний тухай бодож, ярьж суухдаа зан ааш нь Тереза эх шиг болдог тул Довчин хүртэл Гэрэлийг ууртай байхад нь Эрдэний сайхан эрхтний тухай ярьж эхнэрээ тайтгаруулдаг байжээ.

Довчин хүүхдэн эхнэрээсээ ухаан алдан айдаг ба өнгөрсөн жил "манай Багабанди дарга, эхнэр нь хужаагийн наймаачидтай танилцаад л байхад юу ч хэлэхгүй суугаад л ... мөн ч хөгийн эр юм аа" гэхэд "Эрдэнэ ирэхгүй бол яана аа" хэмээн гунихарч суугаад огт анзаараагүй Гэрэл сайхан бодлыг нь тасалсанд уурлан "Юу гэнээ чи!" хэмээн асуухад "Би л бол баяр хүргэнэ" гээд инээмсэглэж суусныг нь ордны цай зөөгч хүүхэн сонссон ба тэр нь яван явсаар дарга нараа шоолж даапаалах явдлыг өөрийнхээ "хобби" гэж үздэг, хэн нэг даргыг л егөөдөж, шоолж суувал энэ яваа насаа талаар өнгөрөөгүйд тооцдог Цэнддоо гэгчид дуулдаж "Монголын улс төрийн 333 онигоо " номд орчихсон юмсанж.

Гэрэл Эрдэнээс баярын нүдээ салгалгүй:

-Довчоон визиткээ өгөөч гэж шивэгнэв

-Та миний "мини" гэрт морилно уу?

Онгоцноос унасан хүн үүлнээс атгах гээд үздэгийн нэг адил оофис ч үгүй, оочих стакан ч үгүй болсон Эрдэнэ тэднийг дагалаа.

Эзэн авгайн зан хайлсан плюмбум гэдэг бодис шиг наалинхай болсонд гайхсан үйлчлэгч нар учрыг олоод "Гайхмаараа", "Хөх толбо" зэрэг сонины хов живийн буланд нууц нэрээр бичиж хэд гурван цаас цохичих санаатай гайхан шивэгнэлдэж битүүхэн тандана. Удалгүй хоол унд, архи дарс бэлэн боллоо. Гэрэл юуг нэн яаралтай хүсэж байгаагаа ярих гэж оролдовч Эрдэнэ зориудаар өөр ярианд шилжүүлж түүнийг улам азаартуулж байлаа. Эрдэнэ Архангай руу буцаж явахгүй гэдгээ хэлбэл "та манайд байгаач" гэж гуйлаа.

Олон хоног бааранд сууж бардаак хийсэн Эрдэнэ ядраад нам унтжээ. Өглөө сэрж үзвэл орных нь хажууд Гэрэл сөхрөн суугаад массаж хийж байлаа. Эрдэнэ шууд ухасхийн боссонгүй. Нүднийхээ булангаар сэм харвал, сүүлийн үед "сувдан сондор" хэмээн их л дөвийлгөн, үнэ цэнийг нь хэдэн зуу дахин өсгөж сонин хэвлэлд бичдэг болсон 0,595 милмикрон диаметртай яльгүй давстай ердийн усан нулимс Гэрлийн нүднээс унаж байв. 1995 оны намар Хөвсгөлд онгоц сүйрсэн мэдээг сонссон ерөнхий сайд Жасрай ийм үнэт нулимсаа огтхонч гамналгүйгээр литр хагасыг гоожуулсныг өөрийнх нь "Засгийн газрын мэдээ" сонинд сурвалжлан бичиж байсан нь Эрдэнийн санаанд оров.

Эрдэнийг алгуур нүдээ нээхэд, Гэрэл хармайнаас нь гараа суга татан авч гэмгүй царайллаа.

-Та ч ёстой нам авлаа шүү.

-Тиймээ, миний кадр тасарчээ

Гэрэл Эрдэнийг гэртээ байлгах гэж дахин дахин гуйсан тул татгалзсангүй.

-Танайд хоёр гурав хоноё доо гэлээ.

Нэг удаа унтаж байхад нь Гэрэл шовхийтэл үнсэв. Эрдэнэ цочин өндийвэл Гэрэл уучлал гуйсан нүдээр ширтэн зогсож байв.

-Яаж байна аа! Би чинь нуудгайтай хүн шүү дээ гэж Эрдэнэ зэмлэн хэлэхэд Гэрэл:

-Тиймээ, Та нуудгайтай, би нөхөртэй. Арван зургаатай намайг тавин зургаатай Довчин албан тушаалаар далайлган давуу эрхээр өмч хувьчилж байгаа юм шиг хувьчилж авсан юм. Яг л улсын үйддвэрийн газар шиг! Гэвч би Хивсний үйлдвэр биш хүн болохоор өөрийнхээ хувьчлалын талаар тодорхой санал бодолтой байж болохгүй гэж үү? хэмээн эхэр татав. Үүнийг сонсоод төрөлхийн ардчилсан үзэлтэй Эрдэнийн сэтгэл уярав.

-Албан ёсны эзэнтэй хүүхэн ингэж болохгүй шүү дээ.

-Албаны ёсны эзэн,...хн! Яг нарийндаа тэр миний биеийн хувьцааны ихэнхийг эзэмшиж "контрольный пакетийг" атгадаг ч гэсэн өөрийн мэдэлд байгаа цөөн хэдэн акцаа танд эзэмшүүлмээр байна гээд тэрээр шүрхэртэл уйлав. Брокерийн пүүсүүдээр танил тал муутайдаа Эрдэнэ гутарч "Би хүний эхнэрийн акцийг авах нь бүү хэл Долгорынхоо "контрольный пакетийг" Итгэлтэд алдчихаад явж байна шүү дээ" гэж хэллээ. Гэрэлийг улам их уйлахад Эрдэнэ аргадаж:

-Дүү минь хайран сайхан оригиналь нулимс! Одоо чинь зах зээлд орсон, юм бүхэн үнэд орсон цаг. Битгий уйл! Бөгсөн дээрээ тэнгэрийн хөх тамгатай монгол хүний оригинал нулимсыг патентыг нь аваад экспортолбол эдийн засгийн хямралаас дорхноо гарна гэж мэргэжлийн эх орончдын хэлдэг ортой шүү. Ийм үнэт түүхий эд болох нулимсаа гамна! Тайвшир. "Амьд явсан хүн Америкт дүрвэх виз авна" гэж хуучны үгтэй юм гэж хэлсэн боловч энэ үгэндээ өөрөө ч итгэхгүй байлаа.

-Хэрэв би тан шиг нөхөртэй бол ганц тор бариад дэлхийг тойрох аялал хийсэн ч бэлэн гэж Гэрэл хэлэв.

-Хүн эхлээд тэгдэг л юм. Яг хэрэг дээрээ "ядарлаа, унаанд сууя" гэдэг гэж Эрдэнэ хариулжээ. Гэтэл нэг орой Довчин гэртээ ирээд:

-Цаад Эрдэнэ чинь өнөө Итгэлтийгээ хуниад эрүү үүсгэгдээд зугтаасан юм байна. Өглөө Пүрэв генерал тэгж хэллээ. Би УИХ-ын гишүүн хүн. Ийм оргодлыг гэртээ нууж байгааг сөрөг хүчнийхэн мэдчихвэл тун тусгүй юм болно ГЭЖ ноцтой өнгөөр хэллээ.

-Та нар хахууль авч коррупци хийчихээд гэмгүй өнгөрч чаддагийг би мэднэ. Цаад Эрдэнээгийнхээ паспортыг сольж өгөөд хөдөө байдаг салбар пүүсэн дээрээ гарга! Харин баригдах юм бол би есөн давхраас шууд... гэлээ. Эхнэрийнхээ тоглоом хийгээгүйг мэдэх Довчин арга сүвэгчилж эхэллээ.

Нэг шатахад долоо шатна гэдгийн үлгэрээр Эрдэнэ мотоциклээс унаж ясныхаа зөөлөн эдийг гэмтээжээ. Үүнийг сонссон Гэрэл унадаг дугуйгаар давхиж хүрэв.

-Намайг дагуулаад хаашаа ч хамаагүй цагаачлаач гэж Гэрэл дандаа гуйдаг байлаа.

-Одоо чинь манайх ардчилсан улс болсон учраас биднийг эдийн засгийн цагаач гэж үзээд оруулах газар олдохгүй л дээ гэж Эрдэнэ гунигтай хариулна.

-Аяганы хариу өдөртөө, ...ны хариу шөнөдөө гэдэг. Та хүнийг ашиглаж ашиглачихаад гол гаргаж байна. Би чамаас хоногт хорин доллар нэхсэн биш гэж нэг удаа Гэрэл гомдолтой хэллээ.

-Архи ууж байхад хүн жаргаж байгаа юм шиг л санагддаг. Маргааш нь эрүүлжүүлэхэд шартчихсан сэрэхэд харамсмаар байдаг. Анх унтаж байхад хорвоогийн жаргалыг амсаж байх шиг бодовч Абоорт хийлгээд хэвтэж байхад дэмий тэгж дээ гэж бодогддог гэдэг. Нэг гондоомыг угааж цэвэрлээд хэд хэд хэрэглээд ирэхийн цагт "энэ муу гуйлгачинг юунд дагалаа" гэж намайг жигших болно гэж хэлэхэд:

-Би ерөндөгтэй хэмээн хариулсан Гэрэлд Эрдэнэ дахиад юу ч хэлсэнгүй. Эрдэнэ удсан ч үгүй Ново ороод ирнэ хэмээн явлаа.

Эрдэнэ оргоод сар болоогүй байтал Дулмаа нэг дискон дээрээс оргоод алга болжээ. Хэдэн өдөр шуугиан болж цагдаагийн газар бүртгүүлж сонин хэвлэлээр зарлуулаад тэгсхийгээд таг мартав. Харин Галсан эхнэрээ алга болсноос хойш нэг хэсэг хоосон үнсний саван дотор олон хоног хэвтсэн акуурк шиг болж заримдаа уйлж байлаа.

-Түүхий ноолуураа гааль дээр шатаачихсан аятай уруу царайлад юу болчихов? хэмээн Итгэлт нэг удаа зэмлэв.

-Ах минь? Дулмаа маань төв нервийн системд үе үе бодогдолт өгөөд хэмээн хушуугаа мурилзуулав.

-За эр хүн дахиад л нэгийг олоод авчихгүй юу. Долгорыг эргүүлээч ...гэснээ -чи ч чадахгүй дээ, чадахгүй! гэж нэмлээ.

Эрдэнийнхээ сэтгэлийг орчин цагийн жорлонгийн ханан дээрхи сүг зурагт байдаг хутга шаалгасан зүрх шиг болгоод явуулсан Долгор сэтгэлийн шаналалд орж хонь хариулж хүртэл үзэн, хээр цаасан дээр шилбүүрээрээ "To be, or not to be." хэмээн бичин бодлогоширдог байлаа.

Итгэлт нэг удаа Долгорт

-Долгор минь! Чи аль бүр өрх толгойлсон эмэгтэй явах вэ? Ганц жожгоолок гал болдоггүй, ганц хүүхэн хөнжил дүүрдэггүй гэдэг. Галсан та хоёр нийлбэл хэн хэнийгээ цангаахгүй. Миний хувьд бол чамайг орхихгүй гэлээ

-Чамаас болж би эр нөхрөөсөө салсан. Одоо намайг дахиад нэг хүнд хаягдахыг харах гээгүй л юм бол ийм юм бүү ярь гэж Долгор эсэргүүцэв.

-Эм хүн оруулахгүй гэсэн хүнээ гурав оруулдаг юм даа гэж Итгэлт англи маягаар хүйтэн инээв.

Энэ газар хөөрхий Долгорын зовлонг хуваалцдаг хүмүүс гэвэл Ням, Хишигт хоёр л байлаа. Тээр жил үзмэрч Дашцэрэн алмаз Төмөрийг мэргэлж байгаад мартаад явчихсан архивыг дахин дахин уншиж Эрдэнийн хувь заяаг нааштайгаар хэлж өгөхийг бодно. Заримдаа Ням гуай хөзрөөр мэргэлж "Эрдэнээгийн бажийнк нь нааш эргэх төлөвтэй. Ялимгүй барьер байна. Удахгүй факс ирэх байх" гэхэд Долгор хязгааргүй баярлана.

-Наадахын чинь прогноз заримдаа сүрхий магадлалтай байдаг юм гэж Хишигт Долгорын сэтгэлийг засна.

Ингээд нэг өдөр Улаанбаатар орж хүүгээ эргэхээр гарлаа. Яван явсаар багшийн коллежийн байр орж Хонгор, Бат хоёрын суудаг өрөөнийн хаалгыг татвал, Хонгор хоёр ширхэг варены шилэнд хийсэн зараа мэт өргөслөг ургамлыг их л додомдон усалж байснаа Долгорыг гэнэт харлаа. Долгорын сэтгэлд гэнэтхэн муу совин татав.

-Бат хаачаа вэ ? гэж Долгор саарал хоолойгоор асуув.

-Байхгүй

-Хаачаа вэ?

-Аавтайгаа уулзаж ирнэ гээд Ново явсаан. Долгор эгч та битгий санаа зов! Бид хоёр салахдаа цонхон дээрээ нэг нэг кактус тарьж "хэн азтай яваагийн кактуст олон өргөс ургаж байг" гэсэн юм. Батаа маань сайн яваа байхаа. Түүний кактусын өргөс хоёр мянга хол давлаа.

Долгор түүний хариултыг бүрэн сонссонгүй. Гарлаа. Одоо түүнийг хүү нь бас хаяад явжээ. Тэр Туул голыг чиглэн алхлаа. Орой нь харшийнхаа ойролцоо салхинд гарч явсан ерөнхийлөгч Очирбат Их тэнгэрийн амны гүүрний ойролцоох цооногийн дэргэдээс эмэгтэй хүний шинэхэн сээгий малгай олов.

Зах зээл, чи хүний зовлонд цадах болоогүй юу!?

Сүрэн Хонгорт гараа өгсөн тухай мэдээ "Халуун хөнжилд" нийтлэгдэж Архангай аймгийн Эрдэнэбулган сумын бүтээлч хөдөлмөрчид "Ням өвгөн ч азтай хүн юм аа", "тэгж яваад азаартах биз дээ", "Итгэлт зуун саяын зээлтэй хүн, ганц хүүгээ долоо шатсан ганзагачинд өгөхгүй", "хүний зээл хүнд наалдахгүй" хэмээн ярилцах боллоо. Должин ганц хүүгээ ядуу гуйлгачны охинд сайн болсонд дотроо бухимдавч Итгэлтээс айж, түүний дургүйг хүргэвэл Галсанг ноолууранд хөөж явуулчихаад Дулмаатай бааранд суучихдагийг нь м.эдэх тул дэмий л амыг нь харна. Нэг удаа:

-Буруу замаар гахай зөөвөл буцахдаа "шаталт" зөөнө гэж үгтэй юм даа. Ганц хүү чинь Сүрэнгийн гарыг гуйсан байна. Эртхэн шиг "гүүд сприйтэй" юмтай нийлүүлэхийг бодсон дээр байх аа гэтэл загасан консээрв идэж байсан Итгэлг эхнэрээ "подтексттэй" нүдээр харж байснаа:

-Сүрэнг муу ёрын сүнстэй амьтан гэж чамд ямар сатаана нь шивэгнэж орхив гэлээ.

Сүрэнгийн аав нь ганзганд явахаараа дандаа л шатаж байх юм байна шүү дээ.

-Ит из нөү проблем гээд Итгэлт штопорынхоо тосыг арчин босчээ.

Итгэлтийн хүүгэй охиноо суулгаад, түүний зээлнээс хувь таслан "дочерь" компани байгуулах бодолтой өөр нэг хүн байсан нь Бадарч юм. Үүнийгээ биелүүлэх гэж тэр сүүлийн хоёр жил Хонгорын сууж байгаа баар луу охиноо мини юбка өмсүүлэн гүйлгэж "хүүхдийг нь олчихвол л учиртай шүү" гэж захьсан боловч цаадах нь "ДОХ-оос сэргийлэх" нэрийн дор байнга бэлгэвч хэрэглээд болдоггүй, дэмий л хүүхнээ ашиглуулсан хэрэг болоод дуусчээ.

Итгэлтийнх ноолуурын баяраа хийх үеэр Бадарчийн эхнэр охиноо бараг нүцгэлж, усны хувцас өмсгөөд Хонгорын сэрлийг хөдөлгөхөөр явуулаад нөхрөө уйлж унжин баймаажин Итгэлтийн рүү хөөжээ. Бадарчийн ирсэнд баярласан Должин "Рояль" спирт дөрөв таслан чанга найрууллаа. Бадарч Итгэлг хоёр эхлээд алт дилер, Аибекс, Моламын талаар жаал ярилцав. Тэгснээ Бадарч:

-Итгэлт минь чи бид хоёр олон жил "хэрэглэгчдийн найдвартай түнш" явлаа. Би чамайг анх найруулсан спирт зарж байхад чинь барьсан удаагүй, бас чамайг эрүүлжүүлэхэд хонуулж үзсэнгүй. Энэ жил миний охины биений юм үзэгдэж, чиний хүү цэргийн зарлан авлаа. Энэ хоёрыг суулгавал болохгүй гэх газаргүй мэт. Миний тавьсан зээл чинийхийн хажууд өчүүхэн ч гэсэн "өртэй хүн баяжиж, өвчтэй хүн эдгэрдэг" болохоор би ганц охиноо хэнээс ч дутахгүй инжтэй буулгана гэж боддог. Бас цагдаагийн ахлагчийн хувьд амьтан ах дүү нараас хураасан, торгосон юм бишгүй л байна гэхэд Итгэлт дүлий годил оргин вирүстэй файл шиг үл ойлгогдох найдваргүй байдал гаргана. Должин:

-Өвгөөн, хам чинь чамд сайхан үг хэлж байна гэлээ.

-Миний охиныг секс, мисс хоёр нь хосолсон буян заяатай хүн болноо гэж Гүрдаваа Рэнбүүчи мэргэлсэн юм даа гэж Бадарчийн хэлэхэд Должин угтан авч:

-Танай охины тааз ч олон хүнд заяахгүй эд шүү. Би ч зүгээр байгаагүй, Алтанцэцэг

бариацаас энэ хоёрын талыг асуухад хэдэн жийп золиод аргалуулж орхивол "Рокфеллер шиг баян болно" гэсэн гэлээ.

Итгэлт мөн л "подтексттэй инээгээд

-Чи нөгөө кредит картыг гаргаад ирээч гэлээ

-Ямар кредит карт

-Яагаав нөгөө бурхан багшийн чандраас аравнайлуулсан "Американ экспресс" банкны алтан карт!

Баяр хөөр нь багтаж ядсан Должин:

-Ёс төрөө бодоод дансанд нь хийлгүй бэлэн мөнгөөр сүй бэлгээ баривал яасан юм бэ? хэмээн шивэгнэж амжлаа.

Бадарч малгайгаа засаад баяр, хөөр итгэл найдвар дүүрэн царайлаад, цүнхээ онгойлгон нэхэмжлэхийн баланк гаргаад:

-Таньдаг улс ёс төр энээ тэрээ гээд яах вэ? Амраар дансанд л хийж орхи! Аль компаний чинь нэрэн дээр нэхэмжлэх бичих вэ, хөгшөөн? гэлээ.

Итгэлт энэ бүгдийг сонсоогүй дүр үзүүлэн, товойлгон хэвлэсэн алтан шаргал үсэгтэй кредит картаа хармайлан гарахад арга барагдан гонсойсон Бадарч, Должин хоёр бие биенээ л ширтлээ.

Итгэлт явсаар банкин очиж ямар нэгэн гүйлгээ хийгээд дараа нь ноолуурын үйлдвэр дээрээ очоод:

-Тэтгэврийн хөгшдийг диспетчерийн өрөөнд урья! гэлээ. Итгэлт Чингисийн зурагтай хөх цэнхэр мянгатын дэвсгэрт дээр сарнай цэцгийн бүтэн баглаа барьсаар Ням өвгөний өмнө очиж:

-Зээ! Танайд 586-гийн сорьцтой, 20 унцын алт байгаа юм бизээ. Манайд 9 каратын засаагүй бриллант байна. Энэ бүгдийг нийлүүлж кольцо хийлгэвэл лус савдаг баярлаж, төвийн нутгуудаар хур тунадас элбэгшин, салхи зүүн хойноосоо 5м/сек-ээс хэтрэхгүй болоод, олон жилийн дунджаас дулаахан болохын учир тэнгэрийн өнгөт төгрөг барьж танай эрдэнийг үнэ тохиролцон аваад, төлбөрийг ямарч хэлбэрээр хийхэд бэлэн байгаагаа илэрхийлэхэд таатай байна гэснээ эв хавгүйхэн инээмсэглээд: -Би олон дахин гэрлэж яваагүй, дээр нь уран цэцэн үггүй болохоор, хүүхний эцгийг олигтой панаалдаж чадахгүй юм гэв. Ням өвгөн: -

-Дилерээс үлдсэн алтыг минь хайрлаж яваарай! Дүрлэгэр нүднийхээ оптикийн шиллэг эд мэт гамнаж яваарай! гээд цэцгийг авлаа. Ганц охиных нь буян заяа дэлгэрсэнд баярласан Хишигт авгай палаткны манжетканд нүүрээ наагаад уйлна. Итгэлт:

-За ах дүүс минь ноос ноолуурын ажлаа эртхэн дуусгаад, өнөө орой сүй тавьсны баярт зориулан тавин хүний босоо хүлээн авалт хийж, Дулмаагаар стриптиз үзүүлье гэв.

Энэ бүхнийг харсан Бадарчийн царай хүрэн хар болсноо шазуураа зууж "муу дуракийг...! муу пиздаг...! тагнуулын төв газарт юм уу, Пүрэв генералд нэргүй мэдээлэл бичээд... гэхчлэн хоорондоо утга авцалдаа багатай юмс бахардан үглэж явлаа.

Улс төрийн элдэв жагсаал цуглаанаас дайжсан Өлзий өвгөнийх Шарга морьтийн зусланд өвөлжиж байлаа. Нэг өдөр тэднийд хоёр янзын гийчин ирж өвлийн галлагаатай сууцных нь нам гүмийг эвдлээ. Дааман хаалгыг өшигчин зогсоо хүнд хаалга нээж өгсөн Хуяг:

-Чи чинь газрын хаанаас гараад ирэв! хэмээн дуу алдлаа. Цаана нь сүүлийн үеийн жагсаал цуглаан болгон дээр үг хэлсээр байгаад "Улаан ардчилагч Дорж" гэж алдаршсан найз нь зогсож байжээ. Дорж Сүхбаатарын талбай дээр ардчилсан холбооныхон өлсгөлөн зарласан, түүнчлэн Румынд цуст мөргөлдөөн болж Чаушеску буудуулсан, хятадууд Тэнгэрийн амгалант талбай гэдэг дээрээ оюутнуудаа цус урсган дарсан зэргийг яриад "нэг бол МАХН-ын төв хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ы тэргүүлэгчдийн дарга нөхөр Ж.Батмөнхийг барьж авч буудах, эсвэл өорснөө Сүхбаатарын талбай дээр танканд дайруулах хоёрын аль нэгийг сонгох цаг болоод байна" гээд "ардчилсан хүчний олон сайхан залуучууд амь насаа алдахыг хүсэхгүй байгаа болохоор Батмөнх даргыг барьж цаазлахаас өөр замгүй болсныг ярив.

-Ээ дээ мэдэхгүй, нөгөө ардын дайсан, сэхээтний төөрөгдөл энээ тэрээ шиг л юмнууд болох вий гэж Хуягийг болгоомжлон асуухад:

- Зүгээр зүгээр. Чи өнөө Элбэгдоржийг таних билүү гээд нүдээ цавчлан ширтэв.

-Танилгүйдээ. Бид чинь нэг онд шинэ цэрэг болоод карантин дээр цуг дэглүүлж байгаагүй юу

Дорж пүүшиг асааж, өмнөө байсан архианаас нэг том балгаснаа:

-Элбэгдорж бид нар ардчилсан холбоо байгуулаад бас дээр нь Америк, Англи, Герман туслана гэсэн...

Энэ бүгдийг сонсож суусан Өлзий өвгөн: -Ардчилсан холбоо гэнэ ээ?

-Тиймээ МоАХ гэж Дорж давтан хэлэв

-Та нар чинь Америкийн империалистуудтай сүлбээтэй амьтад уу?

-Тийм

-За тэгвэл хүү минь явж үз. Манайхан энэ Хуягийг оролцуулбал гурван үеэрээ намын гишүүн болж байгаа улс. Өвгөн ах нь нэгдэл байгуулалцаж явсан хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хотын намын бага хурлын төлөөлөгч хүн. Ардчилсан холбоо Америкийн империалистуудтай нийлж, жанжин шугамаасаа гуйвахгүй гэж Өлзий ууртай бөгөөд шийдмэг хэлэв. Хуяг: -Ааваа та чинь юу болж байна аа? Энэ чинь миний онжав шүү дээ.

-Юу ч гэсэн тэр. Хүү минь зүгээр л явж үз. Эс тэгвэл ах чинь чамайг өндөр настны намын үүрт очиж хэлнэ шүү. Бид та нартай адилхан марксизм- ленинизмаасаа урваж чадахгүй гэлээ.

Дорж цааш нь ардчилсан холбооны мөрийн хөтөлбөрийн тухай ярих гэсэн боловч Өлзий

хэдэн өдрийн өмнө район дээрээ очиж үзэл суртлын хэлтсийн эрхлэгчээсээ МоАХ-ны тухай сонссон болохоор тэднийг үзэн ядах, зах хязгаар нутагт малчнаар хөөж явуулж хүмүүжүүлэхээс өөр юм бодогдохгүй, "Чи яв, түргэн зайл" гэдэг хариу л өгч байлаа. Хуяг бол МоАХ-ын талаар ац бодолтой байлаа. Муусайн хүнд сурталтай дарга нарыг авч хаяад ард олонд жинхэнэ эрхийг нь эдлүүлнэ гэдэг нь зөв мэт боловч империалист хүчинтэй холбоо сүлбээтэй гэдэг нь эргэлзээ төрүүлэх ажээ. Дорж тэднийхээс явахдаа:

-Ардчиллын төлөө тэмцэл хэзээд ялдаг. Бид ялна. Өвгөн та тэр цагт муусайн тоталитаристуудтайгаа ганц худагт суугаад толгойгоо шаах болно доо гээд явжээ.

Орой, нар сервантнаас өнгөрч байхад хавгас сугавчилсан хоёр хүн ирж, Хуягийг ахмад коммунистын хүү учраас МАХН-д орлогчийн шатыг алгасуулан эчнээ элсүүлсэн тул ОСГ-ны хорооны намын үүрийн товчоон дээр яаралтай ирж батлахаа аваад Эрх чөлөөний талбай дээр болж байгаа сөрөг өлсгөлөнд оролцохыг даалгасан илгээлт гардуулав. "МАХН-ын Төв хорооны дэргэдэх, засгийн газрыг гэмт халдлагаас хамгаалах нийгэмлэгээс" эрхлэн эл сөрөг өлсгөлөн гэдгийг зохион байгуулжээ. Хуяг:

-За мэдлээ. МПБ, МУЗН, МЗНН, МБОХН, МҮЭ, МХЗЭ, УБХТН...-ийн гишүүн гээд л ямар юманд элсэж сураагүй юм биш, явья гэв. Өлзий:

-Хүү минь саяхан цэргээс халагдсан юмсан. Дахиад л салах нь. Намын даалгавар ч хүнд байдаг юмш дээ гээд хоолой нь зангирснаа: -миний хүүг гал улаан батлах нь өршөөг гээд баруун гарыг нь чанга атган товаришлаад: -ирэхэд чинь зүүн гарыг чинь тавааршлана аагэв.

Хуяг гил хар өнгөтэй "Украйна" дугуйгаа унасаар гарахдаа эхнэртээ хандаж:

-Би муусайн тоталитаристуудтай нийлэхгүй. Сүхбаатарын талбай орж ардчилсан холбооныхонтой нийллээ. Аавд маргааш хэлээрэй! гээд явжээ.

Ардчилсан холбооны өлсгөлөн гэнэтхэн ялалтад хүрч улс төрийн товчоо бүрэн бүрэлдүүнээрээ огцорлоо.

Намын төв хорооны удирдлага хонтоороо орхин зугтаав. Улаан ардчилагч Дорж МоАХ-ний тавин гишүүний хамт Хотын намын хорооны агуулахад оров. Тэнд одонгийн лент зүүсэн манаач өвгөнөөс өөр хүнгүй. Намын хорооны товчооны гишүүд аппаратын ажилтнуудын гэртээ аваачиж амжаагүй орхисон юмс ундуй сундуй хөглөрнө.

-Ард түмний хөрөнгө хаана байна гаргаад ир! гэж улаан ардчилагч Дорж том цэнхэр тугаа далайн зандраад агуулах савыг нээлгэв. Дорж:

-Чадах чинээгээрээ авцгаа? Ялсан ардчилагчдийн сүр хүч. Үнэндээ бол ард түмэн бидний юм гэлээ.

Хүмүүс сандал ширээнээс авахуулаад хогын сав... ер нь дааж чадах бүхнээ л ийш тийш нь чирлээ.

Эрдэнийн сэтгэлд Долгор бодогдов. "Намайг дагаж их зовлон үзсэн хүн дээ. Үсээ ч олигтой буржийлгаж явсангүй" гэж ганцаараа ярьж явтал бөөн пигүүж харагдав. Тэгээд нэгдүгээр даргын нарийн бичгийн даргын өрөөний "Алтанбулаг" хивсийг дөрвөлжлөн баглаж байсан улаан ардчилагч Доржоос:

-Нэг толгойг буржийлгэхэд хэдэн пигүүж ордог юм бэ? гэж асуувал цаадах нь:

-Ялсан ардчилагчдын толгойд бол хоёр авдар ордог. Энгийн хүнд бол хорь орчим ширхэг нь болно гээд ха ха гэж инээв. Эрдэнэ хорин ширхэг пигүүж тоолж аваад "Үнэн" сонинд нямбайлан боож өвөртлөөд эргэтэл Дорж:

-Ийм их юманд орчихоод наадахаараа яах нь ю? Ядахдаа тэр "Решение ЦК МНРП в жизнь" гэсэн туурган хивсийг хуулаад аваач! гэв

-Зүгээр надад энэ л болно оо гээд Эрдэнэ явжээ. Маргааш нь улаан ардчилагч Дорж зохицуулагчтай МоАХ-ны гишүүдийг Элбэгдорж дарга дуудав. Тэрбээр хүний унадаг дугуйны араар сундлан их л ууртай давхиж ирснээ:

-Та нар ардчилагчид болохоос биш ямар феодалын хөрөнгө хураах комисс юм уу? Өчигдөр орой хотын намын хорооноос авсан юм аа энд авчирч тавь! гэлээ Гишүүд удтал дуугүй байснаа:

-Та чинь ардчилсан хувьсгалын маргааш өмч хувьчлал явуулна гээгүй билүү?

-Өмчийг ингэж хувьчлахгүй. Ягаан, цэнхэр хоёр сугалаа гаргаж сугалуулаад юу хожсоныг нь өгнө. Тэхэн дээрээ тулбал улаан ардчилагч Доржийг МоАХ-ны районы зохицуулагчийн тушаалаас хөөлөө. Та нарын дотор цэрэгт байсан хүн байвал наадахаа дахиад ингэхгүй болтол нь "дэглэ" гэв.

-Элбэгээ даргаа "дэглэнэ" гэдэг чинь коммунист дэглэмийн ёс биш үү?

-Дээрэм бол коммунист дэглэмийн ёс болохоор шийтгэл нь ч мөн л коммунист байх ёстой гэж дарга хүйтнээр хариуллаа.

Гишүүдийн дунд шивгэнэлдэн ярилцах битүү чимээ гарснаа, авсан юмаа авчран овоолж гарлаа. Эрдэнэ бүгдийн сүүлд алхаж очоод "Үнэн" сонинд нандигнан боосон пигүүжнүүдээ тавив.

-Наадах чинь юу юм бэ?

-Пигүүж

-Задлаач гэж Элбэгдорж ойрд аялгуугаар боловч халх хүнд ойлгогдохуйц тодхон хэлэв. Эрдэнийн хийсэн дээрэм бусдыгаа бодвол хөнгөтгөн үздэг зүйл ангиудад холбогдмоор санагджээ. Эрдэнэ пигүүжнүүдээ унтаж байгаа манцуйтай хүүхдээ задлаж байгаа эхийн гараар задлаад дарга өөдөө гэмшилтэй бөгөөд гомдолтой нүдээр харлаа.

-Хэнд өгөх гэсэн юм бэ? гэж Элбэгээ дарга хардангуй асуугаад ардчилсан холбооны хүүхнүүдийн хэн нэгний нэрийг хэлэхийг шазуур зуун хүлээлээ.

-Долгорт!

-Ёх хэмээн сэтгэл нь амсхийсэн Элбэгдорж нэг хүнийг дуудаж: -Лантуу дарга хэлэлцээр хийсний дараа манай эхнэрт бэлэглэсэн цахилгаан хайчийг Эрдэнэд өг! гэлээ.

Дорж нэг орой Хуягийн д халамцуухан орж ирлээ.

-Улаан Ардчилагч Дорж гэдэг чинь би дээ! гэж тэнд байсан улстай танилцаад өврөөсөө хоёр шил "Талын хар" гаргах зуураа: -Муусайн зусарч золигнууд, орох дээр л хөл алдаад архи өгөх юм гэлээ. Хуяг:

-Чи чинь хэзээ ингээд олон зусарчуудыг таньдаг болсон билээ? гэжасуув.

-Таних танихгүй нь ямар хамаа байна! Ороод л хойморт нь цэнхэр тугаа зоочихоод, хоёрын зэрэг лоозон дэлгээд л суухаар өөрийн эргүй гар нь авдар руугаа явдаг юм даа гээд хоёр далаа займчин ханхалзав. Дорж сая л гэхэд өөрийн хорооныхоо МАХН-ын үүрийн дарга хөгшнийг айлгаж байгаад улаан таван хошуутай тамга, намын татвар "хураав" тэмдгийг нь шатаалгасан төдийгүй, хоёр шил архийг нь гаргуулан уужээ. Доржийн энэ явдлыг мэдсэн Хуяг:

-Энгийн номхон коммунистуудыг сүрдүүлэх нь манай ардчиллын зарчимд харш гэж зэмлэсэн боловч:

-Тэр дэмий. Би ардчилсан ёсыг гадарлаж байна. Коммунистууд бол коммунистууд шүү дээ. Бодоо Данзанг хэн цааш харууллаа? 700 гаруй хүрээ хийдийг хэн шатааж, зуун мянган хуврагийг минь хэн яалаа? Коммунистууд биш гэж үү? Манай ардчилал дэндүү зөөлөн юм. Уг нь цөмийг нь... Нарийндаа бол румынчууд Чаушескуг бууддаг зөв юм болсондоо... гээд нэг шил архиа задлан цүл палхийлгэн залгилснаа: -Ху намын хулгай нарыг цөмийг нь Лениний хөшөөний сунгасан гарнаас дүүжлээд... гэснээ нам унан эзгийг буцалгаж гарав.

Улаанбаатарын хойноос орж ирээд санхүүгийн болон худалдааны коллежийн хоорондуур урсдаг Сэлбэ гол байгаагүй бол дуу шүлэг зохиогч нар хэрхэн "Сэлбийг өгсвөл сэрүүхэн" ч гэх юм уу "хатаж байгаа Сэлбэ" гэхчлэн бичих байсан юм, бүү мэд! Үдшийн бүрэнхий болсон хойно энэхүү ач буянт Сэлбэ голын арслантай гүүрний доогуур хятад жийнс турк цамцтай хорчгор залуу "парокс" маягийн чамин цүнх сугавчилсаар орж явчихав. Тэр орсон дариудаа нэг нохойн дээр гишгэж бөөн шуугиан боллоо. Гүүрийн доор харанхуй бөгөөд өвгөнтийн гашилмал үнэр ханхийнэ. Гүүрийн нөгөө булангаас:

-Бат уу? гэх дуу гарлаа. Дууны эзэн бол багшийн коллежийн оюутан Жаргал байлаа. Бат Жаргал хоёр коллежийнхаа дотуур байрны өрөөг шөнийн цагаар янхан хүүхнүүдэд хөлслүүлээд өөрснөө энэ гүүрэн дор хоноглож сургуулийн төлбөртөө өгөх хэд гурван доллар олж байгаа билээ.

-Тийм ээ би байна гэж Бат эрүүгээ хавчигнуулан хэлээд уутан хөнжлөө татан гаргав.

-Байранд чинь өнөө нэг хар бульдог хэвтээд байсан.

-Тийм байна, гэхдээ бульдог биш сенбернар, сеттер хоёрын эрлийз байсныг нь би гишгэж орхилоо.

-Аа тиймүү гэснээ Жаргал: -Чи олз омогтой юу? гэж асуув.

-Хоёр германд хүүхэн олж өгөөд хорин марк! Нэг хужаа харин сүүлдээ луу унжиж хулхидлаа... Тэгэхдээ би хариуг нь сайн барьсан. Эртүүдийн цоолсон бэлгэвнээс зарах мөртлөө өнөө тэмбүүтэй хүүхнийг өвөрлүүлчихсэн. Харин нэг америк нүнжигтэй загнасан. Шууд л тавин ногоон гаргаад өгч байна лээ. Жаргал минь ингэхэд чиний хэлдгээр япон хэл үзэхгүй бол үйлчүүлэгчдийнхээ ихэнхийг алдах нь байна шүү.

- "Кон ничива Бат сан"! Би чамд англи герман хоёртой хол явахгүй гэж олон хэлсэн дээ.

-Талийгаач Ринчен Бямбаев багш маань байнга л өмнө маань булан нь салбайсан толь бичгүүд тавиад "За шавь минь бор тархиа божийтол хэл үзнээ хө" гэдэгсэн.

-Чи дандаа л багшийгаа ярьж байх юм. Танай багшийг чинь Бал дарга хүнд албан даалгавар өгч гүжрээр гүтгүүлээд үхүүлчихсэн гэдэг үнэн үү?

-Би ч үнэн л гэж боддог. Багш маань дандаа "Бал даргын гар ч урт даа" гэдэгсэн.

Тэр хоёр тэгсгээд унтав.

Өглөө тэднийг чанга яригчийн учиргүй тод паржигнах, элдэв уухай лоозон хашгирах дуу сэрээлээ. Үл мэдэгдэх дуу гарч байгаа зүг рүү машинтай, дугуйтай, явган олон хүн цувж байна. Тэд мөн сонирхон явсаар

Сүхбаатарын талбай дээр ирвэл Ардчилсан хүчнийхэн жагсаал цуглаан гэдгээ хийж байгаа ажээ. Тэд шуудай гурил худалдаж авч элбэг хүрэлцэм бөс давуун дээр "ард түмэн өлсөж цангаж байгаа тухай" уншсан хүн шууд л өлсөөд унамаар угга төгөлдөр лоозонг хибрай,

сэрби, тамил хэл дээр бичиж хаджээ. Бат, Жаргал хоёр утгыг нь ойлгож байсан ч яагаад монгол хэл дээр бичээгүйн учрыг олсонгүй. Уул нь олж ядаад ч байх юмгүй, Зориг, Элбэгдорж хоёр гадаад явахдаа тусламжаар бэлэн лоозон олж ирсэн юм байжээ.

Элбэгдорж дарга цуглаанчдад хандаж:

-Өнөөдөр аугаа их зөнч мэргэн Мохамедийн үхсэн өдрөө. Хүний эрхийн салбарт оруулсан түүний хувь нэмрийг өндрөөр үнэлэн хүндэтгэе гээд малгайгаа авахад бүгд малгайгаа авч пинтүүтэй, халзан, хожгор үй олон толгой наран дор гарч ирлээ. Гэтэл нэг хүн араас нь юм шивэгнэхэд дарга толгой дохисноо "аа тийм бий" гээд дахин микрофоныг авч:

-Эрхэм элэг нэгтэй монгол жагсаалчид, цуглаанчдаа! Энд нэг жаахан алдаа гарсан байна, уучлаарай. Өнөөдөр лалын фундаменталист Мохамет гэгчийн нас барсан өдөр бус, Тель Авивт харамсалтайгаар цаазлагдсан Е.Э. Ийсус Христийн төрсөн өдөр юм байна. Бүгд малгайгаа өмсцгөө гэхэд хурсан олон нэгэн зэрэг ярсхийтэл малгайгаа өмслөө.

-Улс орон ардчилна гэдэг ч мөн сайхан юм аа. Ингээд л хэн санаанд орсноо, тэр байтугаа сайн санахгүй байгаа юм аа ч ярьж болдог цаг ирэх гэж хэмээн нэг эмгэн хэлтэл хажуугаас гүн ухааны доктор Нямаа оролцож:

-Цэдэнбал даргын минь л ач!

-Та юу гэчихвээ?

-Тийм ээ, Цэдэнбал дарга маань л ард олныхоо тусын тулд тархи толгой нь муудаад явахдаа өөрийнхээ оронд ардчилсан хүчнийхнийг зэвсэглэн дарахгүй буулт хийх хүн гэж мэдээд энэ Батмөнхийг тавьсан байна шүү дээ. Улс төрийн холын хараа гэж... хэмээн бахархангуй хэллээ.

Хүмүүс хоёр камаз нийлүүлэн зассан тавцан дээр зогсоо Монголын гол ардчилагчдын дундаас өөр өөрийн таньдаг хүнийг олоод харчих санаатай өндөлзөнө.

-Энэ өвгөнтөрхүү хэвлүүн полдгор хүү чинь хэн бэ?

-Цөг гэм. Тэр чинь Элбэгдорж гуай. Монголын ардчиллын заяа буянаар төрсөн хүн,

Тэггэл ямар ч л байсан үс нь маш урт, өөр бусад юм нь ямар хэмжээтэйг бүү мэд товариш, дөрвөн мөчиндөө ороосон эрхинуудээ эргэлдүүлэнгээ маань маягтай юм бөвтгөх завсраа:

-Үхсэн хойноо, муу бага дарга! ум мааний... еэ хар п..! хэмээн хорсолтой хэллээ. Энэ бол хэдэн жилийн өмнө комсомолын дээд төгссөн боловч сүүлийн үед сүсэгтэн болж яваа Цамба ажгуу.

-Үгүй ээ ингэхэд Элбэгээ дарга чинь яахлаараа сүүний оочерт зогсож байгаа юм шиг арвын бидон барьчихсан явдаг билээ?

-Хаана бидон байна?.

-Харахгүй байна уу? Тэр баруун гарт нь!

-Юуны чинь арвын бидон! Тэр чинь Баабар!

-Еэ базардархи минь! Өнөө цочоол-дамкраатууд нь сонсчихоогүй байгаа!

Энэ зуур Элбэгдорж дарга:

-Манай өнөөдрын ардчилсан холбооны цуглаанд социал демократ нам субъектив дэмжлэг үзүүлж байгаа! гэж тайлбарлаад тэр намын дэд дарга Бямбажаргал үг хэлэх гэж байгааг зарлав. Тэгтэл урт гонжгор пийлнэгтэй, бүр Баабараасаа өндөр, монхор залуу гарч ирээд, микрофон авангуутаа үг сүтгүй енгэнэтэл уйлж гарав. Түүний нулимсыг цуглаан зохион байгуулагчид гялгар уутанд тосон авч байлаа. Хожим сонсоход түүний эсэргүүцлийн нулимсыг уг цуглаанаас төр засагтаа хандаж гаргасан өргөх бичигт хавсарган явуулсан гэнэлээ.

Иймэрхүү яриа хөөрөө явж байтал гэнэт олны дунд:

-Зөвлөлтийн мэргэжилтэн гэсэн дургүйцсэн дуу гарлаа.

Үнэхээр тавцан дээр харааны шил зүүсэн хонгордуу үстэй хиймэл үүдэн шүдтэй, нүдэнд дулаахан орос хүү зогсож байлаа.

-Усны аж ахуйн яамны Жанжаадорж сайдын зөвлөх Водкин байна гэж нэг нь мэдэмхийрэхэд нөгөөх нь:

-Энд шургаад авсныг бодоход НАХЯ-ны зөвлөх Радченко байх гэж дүгнэлээ.Тэр ч байтугай нэг хүн:

-Гандан хийдийн зөвлөх мөн байна. Би өөд болоочийн хойтохыг асуух гэж ороход ийм мэргэжилтэн байсан гэж мэтгэсэн боловч үнэмших хүн гарсангүй. Гэтэл ханцуйдаа хөх даавуу уясан сонин харцтай намхан туранхай залуу

-Юуны чинь зөвлөлтийн мэргэжилтэн! Ху намынхан сөрөг ухуулга хийдгээ болиорой! Манай Зориг юу гэж хэлүүлсэн ч зориг нь мохох хүн биш

-Пөө өнөө Зориг чинь энэ үү?

-Тийм

-Энэ эхлээд Зорге юм уу, Зорький нэртэй байсан байх хэмээн эхний хүн өөрийгээ хамгаалахыг оролдов. Гэтэл сонин харцат тиймч амар бууж өгөх эр биш байжээ. Зоригийг анх эхээс төрөхөд нь л Зориг гэж нэр өгснийг гэрчилсэн гэрчилгээний нотариус баталсан хуулбарыг үзүүллээ.

-Ер нь Зориг нэртэй хүмүүс иймэрхүү байдаг юм. Цэдэнбалын Зориг ч гэсэн хаанаас нь харсанч орос шүү дээ.

-Тэгж ярихдаа тулбал уулын спортын мастер Зориг гуай бол тас хар... гэж ирээд л маргаан ширүүслээ. Энэ бүхнийг харж зогссон хөдөөний өвгөн:

-Хөөрхөн л шар толгойтой баньди байна. Нүднийх нь цэлхийг харахад баахан давсаг султай даг уу. Уул нь ч мөндөлийн арьсаар хоёр гурван орой бүлээн жин тавиад л... юухан байхав дээ хэмээн ганцаараа ярьж байлаа.

Зориг нөхөд хамтран зүтгэгчдэдээ "Морь харлаа" гэж хэлээд засгийн газрын ордон руу оржээ. Мөн түүнтэй нэг мөчид СнЗ-ийн дарга байсан Содном гуай жолоочоо дуудан

-Чи давхиад ордны баруун талд зогс. Зориг 19 цаг 18 минут 45 секундэд урдаасаа тавдахь цонхоор 58 градусын өнцөг үүсгэн морь харна. Түүнийг харчихаад энэ захидлыг "Ардын эрх" сонины газарт аваачиж өг! Наана чинь Зоригийн цонхоор морь харж байгаа зураг, мэдээлэл сэлт байгаа. Хариуцлагатай явна шүү гэлээ. Ингээд даргын жолооч чухал материал өвөртлөн аймаар том сенсацийн гэрч болохоор гараад өгвөө.

90-ээд оны сүүлч. Ардчилсан хүчнийхэн сонгуульд ялалт байгуулж, аймгийн засаг даргаар тэдний хүн ирэх юм дуулдав. Итгэлт тэрхүү ардчилсан хүчний ерөнхий сайдаас тохоон томилсон шинэ засаг дарга өчигдөрийн онгоцоор ирснийг дуулаад 2000 ам долларын бэлэн дэвсгэрт өвөртлөөд засаг даргын тамгын газрыг зорилоо. Эд засгийн эрхэнд гарснаар хэмжээ хязгаараа алдсан мафи, коррупцийг хазаарлан зогсоож чадна, тэгвэл хээл хахуульд өгдөг олон сая төгрөг нь эргээд өөрт нь эргэлдэх болно гэхээс баяр хүрнэ. Дээр нь тэд засгийн эрхэнд гармагцаа албан татварын багц хуулийг эргэж хэлэлцэнэ гэж амласан нь ч баяр хөөр төрүүлнэ. Итгэлтийн гаргаж байгаа ноолууранд бараг тэг хувийн ашиггүй болтол татвар тавиад, хоёр төр дамжин дарга явагч пост коммунистуудынх болохлоор ногоон гэрлээр жирэлзүүлэн оддог хөг өнгөрөх нь гэж бодохоор баяр хөөр төрнө. Итгэлт анх ардчилсан холбоонд хандив өргөж байснаасаа болоод байнга хавчигдан зүдэрч гагцхүү өөрийн ов мэх, авхаалж самбааны хүчинд хэдэн төгрөг эргүүлсээр өнөөг хүрчээ. Одоо ч уяа нь алдуурсан нохой шиг хажуугаар чинь жирэлзүүлээд өнгөрнө дөө. Миллиард доллартай болох ч юухан байх вэ дээ гэж бодогдов.

Ху намын нөмөр нөөлгийн баячууд муусайн, экскоммунистууд Итгэлтийг царайчлан "Чи засаг дарга дээр ороод өгөөч?", "Татварын албаны шинэ даргатай танилцуулаад өгөөч" гэлцэн гүйгээд ирж байгаа нь нүдэнд үзэгдэх шиг, "өвгөнд нь тэр цагт хэлэх үг бий" гэж бодохоос Ху намын хорооны дарга хэдэн үрчийсэн доллар барьчихсан гэрт нь орж ирээд "Зээлийн баталгаа гаргаад өгөөч" гэж царайчлан гуйж байгаа нь нүдэнд харагдах шиг ч болж алхаа нь хөнгөрнө. Гэтэл "Должингийн аав нь гэж нутаг хошуундаа алдартай хуучныг баримтлагч байдаг нь гай болох юм биш байгаа даа гэж бодогдоно. Гээд хүний эцэг эхийн явдал үр хүүхдэд ямар л нялзав гэж дээ хэмээн тайтгарлаа. Итгэлт эрх баригч намын дотны хүн болж ерөнхий сайд гадаад дотоодод айлчлахад нь үйлдвэр худалдааны бүлгийн төлөөлөгчдийн нэгэнд ордог болно гэдэгтээ эргэлзэхгүй байлаа.

Тэгтэл өмнөөс нь шалдаа бууж, гэр орныхныгоо газар хөдлөлтөд нэрвэгдүүлчихсан аятай царайлсан Бадарч ирж явлаа. Мөрдэсээ аваад хармайлчихсан харагдав. Итгэлт түүнийг хараад "Ху намын коррупцийн муу уяаны нохой! Ядмаг дорой амьтдын юмыг луйвардаж ханаа байлгүй. Шалдаа буугаад хий нь гарчихсан дотуур хаймар шиг болоо шив дээ" гэж бодсон боловч түүнээ ил гаргасангүй.

-Яагаав? Бадарч ахлагч шартаж орхио юу? Зуу татахуу? гэлээ.

-Итгэлт минь өнгөрөөд байна. Ардчилсан холбооны хүн ирээд аймгийн засаг даргын тамгыг авсан. Мөрдөнд байсан мянгаад хүнийг хууль зүйн үндэслэлгүй хорьсон байна гээд суллагчихсан. Цагдаагийн даргаар Завханы нэг муу цагаач томилогдсон гэнэ. Намайг ажлаас халсан төдийгүй иргэдийн гомдлыг үндэслэн шалгаж эрүү үүсгэж ч магадгүй юм хэллээ. Сайн цаг, сайхан нам хоёр ч өнгөрлөө бололтой. Ингээд арын сайхан хангай засаг захиргаагүй, дүрэм журам сахиулах хүнгүй болвоо гэж Бадарч ярилаа.

Итгэлт "Чам шиг мудар, мудар засагт л хэрэгтэй болохоос биш, Ардчилсан хүчнийхэнд бол хивс нэхэх газар муужгай хэрэггүй гэдгийн үлгэр биз дээ" гэж дотроо бодсон боловч:

-Ийм явдал болсон нь харамсалтай. Тайван амгалан байж учрыг магадлахыг зөвлөө гэж хөндийдүүхэн хэллээ.

-Иш, Итгэлт минь тэр шинэ засаг дарга нь хэн гэж бодно оо. Бодохоос л "каалтаад" байх юм. Өнөө танайд брокер байсан Эрдэнэ.

-???

-Тиймээ,Эрдэнэ.

Энэ нэрийг дуулмагц Итгэлтийн цусны даралт шууд л 150-180 болж бушуухан нэг нитроглицерин залгив. "Эрдэнэ надтай тооцоо бодож. намайг шатаана. Тэгхээр яа вэ?!" гэдэг бодол тулгарлаа. Гэвч тэрээр дорхноо биеэ барилаа.

-Эрдэнэ чи бид хоёрын дэргэд эрдэм номтой, англи, оростой хүн байхгүй юу!

-Үхсэн хойноо, тэр муу ганзагачны эрдэм ном ч дээ! хэмээн хэллээ.

Итгэлт бодов. Эрдэнээс зугадаад хаачих вэ? Хөрөнгө хогшлоо хаяад өөр аймаг шилжилтэй биш. Хэрэв данс бодоход хүрвэл эр хүнд "шарталт ч бий, шар тайлалт ч бий" гэдгийг санах. "Зарим юм түргэн дээрээ, загасны мах шарсан дээрээ" гэж үгтэй юм. Юу ч гэсэн одоохон очиж уулзья гэж бодлоо.

-Уул үзээгүй моостондоо хийж, ус үзээгүй купальник өмсөж болохгүй ээ хө. Эрдэнэ шургахдаа сайн. Дээр нь боловсролтой хүн. Учир нь олдох л байх гэлээ.

-Энэ улсыг ч ардчилсан хүчний хэдэн баньди нар баллаж дуусгах бололтой. Хуучин засаг дарга даралт нь ихдээд гэртээ байгаа. Хоюулаа ганц юм аваад очих уу? гэхэд нь:

-Би складаа үзэлгүй болохгүйнээ гээд салж явлаа.

Засаг даргаар томилогдож ирсэн Эрдэнэ Ардчилсан хүчний засгийн газрын бодлогыг тайлбарлаж, Айбекс, Моламын хэргийг бид л нэг талд нь багтаана. Улс орныг хэрсэн мафи, коррупцийн сүлжээг таслахын тулд бараг бүх удирдах албан тушаалтныг өөрчлөхөөс өөр аргагүй болсныг дурьдахад хурган дарга нар тунч дурамчхан хүлээж авчээ. Харин нутгийхнаас Долгорын талаар л асуух гээд зүрх хүрсэнгүй

Эрдэнэ өглөө ажилдаа ирээд байтал удалгүй нар дээш хөөрч, хуучин даргын цуглуулсан Лениний бүрэн ботийд дээр "цаанаа нэг юм хэлэх мэт" тусах үед гаднаас Итгэлт орж ирээд шууд л хэдэн боодол ногоон барьж:

-За би угаасаа дарга даамал язгуургүй. Посткоммунистуудыг үзэн яддаг, ардчилсан холбооны анхны цуглаан дээр аймгийнхаа анхны хандивыг одоогийн ерөнхий сайд Элбэгдорж гуайд өргөснөөсөө болоод нутаг орондоо байх суух газаргүй болж Польш хүртэл явж наймаа хийж байсныг минь чи мэднэ газар. Ингээд манайхан ялалт байгуулан засгийн эрхэнд гарсан баярт өдрийг мялааж ардчилсан хүчнийхэндээ 2000 ногоон барьж байна гэв.

Мөнгө бариад зогсож байгаа Итгэлтийг "хэнхдэгийн хүрдийг цочоох" гэдэг кунфүгийн мэх хийж нам шааж унагамаар санагдсан боловч Элбэгдорж дарга нь аль болох сайхан ааштай байж, олон түмнийг намдаа татах даалгавар өгсөн нь бодогдон биеэ барилаа.

Итгэлт дараа нь:

-Муугийн ёс биш монголын ёс! хоюулаа тавааршлая гэснээ: -Өвгөн чинь аймгийнхаа ардчилсан хүчнийхний байр, утас халаалтынх нь зардлыг таван жилээр дааж байгаа гэлээ. Энэ бүхэндээ зоригжсон Итгэлт улам газар авч: -Чи бидний хооронд проблем бий. Тэр миний гэнэн цагаан дурлал маань дэндүү поовэртэй зэргээс болжээ. Мужууд конфликттэй нэг өдөр байхад, хэлэлцээрийн ширээний ард суух өөр өдөртэй байлгүй яах вэ? Долгорын өмнө бид их буруутай...

"Долгор" гэдэг нэр Эрдэнийн занал хорслыг дахин бадруулж ширээн доогуураа гараа оруулан нууцгай тавьсан мончоогоо шүүрлээ. Итгэлт ажиггүй доошоо Эрдэнийн "салмаандар" бажийнхийг ширтэн:

-Чамайг явснаас хойш Долгор алга болсон. Харин тэгэхнээ Эрдэнэтэд амьд байна.

-Юу?

-Би вагзаал дээр уулзсан. Долгорыг усанд унаж үхсэн тухай Ням өвгөний "Нүгэл буян" сонин дээр бичсэн "Зах зээл чи хүний зовлонд цадах болоогүй юу?" гэсэн гарчигтай мэдээ худлаа байна билээ гэв.

Долгор амьд гэдэг үг Эрдэнийн сэтгэлийг бүрмөсөн өөрчилж, Итгэлтийг хэрхэн дампууруулан шатаах төлөвлөгөөг нь замхруулав. Долгор амьд гэдэг үгний төлөө тэр хэнийг ч уучлахад бэлэн байлаа. Итгэлт Долгортой хэрхэн уулзснаа яриад:

Намайг ч шууд л амбаардан хөөсөн... аргагүй юм даа гээд хэсэг дуугүй сууснаа: -Би сүүлд

нь гэмтэлд хэвтэж байж полиэтиленээр ахар сүүл хийлгэсэн... чамайг үнэмшихгүй байх гэж бодоод хуучныг нь аваад ирлээ гээд, тос даасан боодолгой юм задалж эхлэхэд нь Эрдэнийн нүд халтирч болиуллаа...

...Харин тэр шөнө Бадарч хэдэн жил тарваганы эргүүлээр явахдаа хурааж аваад завшсан хориод халиавраа зуныхаа сууцны дээвэрт сэм зөөж "гайгүй дээ удахгүй хэрэг болно" гэж шивэгнэн хэлээд манжеткаараа хөлсөө арчив.

Эрдэнэ Архангай аймгийн МАХН-ын гишүүдийн дотор МоАХ-ны салбар байгуулах гэж олон хоног ажиллав. Үүний хажуугаар "Ардчилсан хүчнийхэн гэдэг чинь империалист харгис хүчинтэй эвсэлдсэн, ленин багшаа хараасан улс, аав ээж ах дүүс бүхий л ахмадуудаа алаад дан ганц МоАХ-ны гишүүдийн улс байгуулна гэж негр хүүхний агтавчнаас адис аван тангараг гавьдаг улс гэнэ" гэсэн цуурхал тарж хөгшин хөвөө улсууд дайжин зугтаж байлаа.

Эрдэнэ нам бусчуудын МоАХ-г амархан байгуулж удирдлагынх нь цалин пүнлүүг орон нутгийн онцлог, голлон авдаг хандив зэргийг тооцоолон тогтоож, салбар зөвлөлийн зохицуулагч сард гурван тарваганы арьс, хоёр литр нэрмэл, дэд зохицуулагч хоёр тарваганы арьс нэг литр нэрмэл, нарийн бичгийн дарга хоёр мөндлийн арьс гурван тагш нэрмэлийг авч байхаар тус тус тогтоож өгөв. Мөн хотоос хүн ирэх үед гишүүдээс нэрмэл татварлахыг чандлан хоригложээ.

Гэтэл МАХН-ын дотор байгуулах МоАХ бол өөр байдалтай байлаа. Цагийн аяст зохицуулан тавьсан залуухан даргыг зад панаалдаж болох байсан ч түүний орлогч, зөвлөгч егзөрүүд амаргүй байлаа. Ардчилсан хүчнийг гүггэсэн элдэв ярианы эх бол мань хашрууд яг мөн гэж итгэсэн Эрдэнэ шууд нүүр тулж уулзахаар шийдлээ. Гэтэл намын хорооны даргын дэргэдээс нууц явуулга, худал суртал нэвтрүүлэгт гаршсан өвгөн орлогч нь холдсонгүй.

-МоАХ бол ард олны тусын тулд улс орноо ардчилсан замаар хуяьсган өөрчлөх байгууллага юм. Ийм болохоор Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн та бүгд элсэн орох биз ээ гэж найдна хэмээн Эрдэнэ эцэст нь тулгав. Ардчилсан хүчний төлөөлөгчийн далд бодлыг гааж мэдсэн көгшин коммунист "Уухай! чи биднийг элсүүлээд өвлийн хүйтэн, гангийн халуунд гадуур явуулж ухуулах хуудас наалгах гээ юү? Тэгж байгаа бол би дотор чинь ороод фракц байгуулан баллаж хаяа даа!" гэхээс хөх инээд нь хүрч байлаа. Тэгээд:

-Орон бүхний пролетари нарын төлөө бие сэтгэлээ харамлахгүй хэмээн коммунист болсон бид МоАХ-ны эгнээнд орж дэлхийн үгээгүйчүүдийн төлөө тэмцэхэд бэлэн байна гэлээ. Эрдэнэ "Уухай чи тэгж байна уу? Хэн нь хэнийхээ хөлд суухыг үзнэ гайгүй!" гэж бодогдон "Cogito, ergo sum" хэмээн латинаар шивэгнээд:

-Та бүхний хүслийг би дуртайяа хүлээн авлаа. Гэвч бидэнд баталсан нарийн дүрэм горим бий. Би та бүхний "Боданчар мунхагаас хойшхи" бүх үеийн намтарыг Бат- Үүл даргад хянуулж шийднэ гэлээ.

"МАХН-ын дарга нар МоАХ -д элсэх гэнэ" гэсэн яриа олны дунд тарж "МоАХ-ын зорилго зөв учраас орж байна", "Цаадуулд нь дарга хийчих хүн олдохгүй мань дурсгасан "Курильские Острова-Неотемлемый часть Советского Союза" гэсэн бичигтэй Карл Марксын зурагтай цамц, нэлээн сүүлд аймгийн засаг дарга Японы Хоккойда аралд зочлоход тэндхийн япончууд бэлэглэсэн "Give me my occupied icelands!" гэсэн бичигтэй шоорт хоёр байдаггүй. Энэ яриа тэнгэрт тулж зурагт, радиогоор. ярьж, сонин хэвлэлд хүртэл бичигдсэн боловч яагаад ч юм бэ, Хонгорт хүрсэнгүй. Халзан хүн сам олоод хэрэглэх аргаа олохгүй болов гэдгийн үлгэр шиг Хонгор музейгээс хулгайлсан юм аа траншейний нүхэнд нуугаад шөнө болгон очиж үздэг байв. "Траншейны нүх ч найдваргүй эд гэх чинь билээ. Чадраа доктор ураанаа мөн л траншейний нүхэнд хийж байгаад алдсан юм гэх чинь билээ" гэж бодогдовч өөр хийчих газар олдсонгүй. Наадмын урьд өдөр мань хүн нуусан юман дээрээ ирвэл хэвээрээ л байлаа. Гэтэл

хэний ч нүдэнд унамаар хурц өнгөөр хийсэн өнөөх цамц анхаарлыг нь гойд татлаа. Тэгтэл цаанаас бас нэг шоорт гараад ирлээ. Тэр хоёрын бичигнүүд өөр боловч газрын зураг нь ив ижил болохыг Хонгор анзаарав. Тийм болохоор тун дажгүй хослол болж байлаа. Тэр хоёрыг өмсөөд наадамд очтол яг тохирмоор санагдлаа. Наадамд ирсэн хүн болгон Хонгорыг гайхан харна.

"Миний дэгжнийг гайхаж байна" гэж бодсон Хонгор "Музейгээс алдсан цамц, шоорт хоёрыг Хонгор өмсчихсөн явна" гэсэн яриа тарж байгааг анзаарсангүй. Гэнэт хоёр цагдаа ирээд Хонгорыг үг сүггүй баривчлан аваад явлаа. Маргааш нь түүнийг байцаав. Түүнийг байцаасан хошууч музей талсан хэргээс гадна өөрөө шалгах үүрэг аваад илрүүлж чадаагүй байсан хэд хэдэн хэргийг Хонгорт тулгав. Мөн музейн тайлбарлагчийн гэртээ аваачаад "мартчихсан" Луу гүний мөнгөн хэт хутга, соёо, цохилуур, хаш хөөрөг гэхчлэнгийн Хонгорын зүүдэнд ч ороогүй юмс бас нэхэгдлээ. Сүүлдээ "Итгэлт гуайн том хүүг зодсон" хэргийг тулгахад нь:

-Итгэлтийн ганц хүү нь би юм шүү дээ. Би өөрөө өөрийгээ зодсон байж арай таарамгүй юм гэхэд нь мань байцаагч "сум булцуунаасаа хэтэрснийг" мэдээд санаа нь зовсон ч юм уу, ганцхан музей талснаа л хүлээчих гэж тулгалаа. Анхны хулгай илэрснийг мэдсэн Хонгор бантахдаа "Говь-Алтайн алмаз Төмөр өгсөн" гэж өчив. Ингээд дөрвөн цагдаа, музейн тайлбарлагчийн хамт Хонгорыг Төмөртэй нүүрэлдүүлэхээр гарлаа. Хонгор гэрт оруутаа Төмөр лүү гүйн очиж гар бариад, мөн бугуйг нь барьж:

-Төмөр ах аа намайг бодоорой хэмээн шивэгнэж амжив. Музейн тайлбарлагч цүнхнээсээ өнөөх цамц шоорт хоёрыг гарган:

-Та үүнийг таних уу? гэж Төмөрөөс асуув. Гэрийн дотор чив чимээгүй. Хонгорын цусны даралт 80-120 байснаа 120-180 болов.

-Танина, тэгээд юу гэж?

-Эдгээрийг Хонгор өмсөж яваад аймгийн прокурорын гарын үсэгтэй ордороор баригдсан. Уул нь аймгийн музейн хөрөнгө. Гэтэл Хонгор тан дээр буулгаж байна гэж байцаагч нэмж хэллээ.

-Тиймээ! Би энэ цамцыг Хонгорт өгсөн юм. Би нэг шөнө гараашаа ухуулаад, зургаан шинэ "бенц" алдсан юм. Танай цагдаагийн газар ч бүртгүүлчихсэн байгаа. Олоод өгчихнө гэж горьдсон ч юм биш, зүгээр иймэрхүү юман дээр л гэрчтэй байх гэж тэмдэглүүлсэн ухаантай. Тэгээд өөрөө машиныхаа мөрийг нь хөөж яваад энэ хоёрыг олсон юм. Нэгийг нь таван жаран есөөс өгөхгүй сайхан лимүзэнгүүдээ алдаад оронд нь энэ цамц, шоортыг олж авсан хүн дээ. Аргаа барахдаа Хонгорт түүнийгээ өгч "Миний дүү, хүн олонтой газар өмсөж яваад "өөрийнхээ юмыг үзсэн байртай харсан хүнийг" ахтайгаа авчирч уулзуулж байгаарай! гэж захисан юм. Гэтэл энэ юмнууд та нарынх байдаг. Ингэхээр миний машинуудын орсон гараашийг та нар л зааж өгөх болж дээ гэж Төмөр туйлын ноцтой хэллээ.

Монголын бүхий л мөрдөн байцаагч, шүүгч нар уран цэцэн мэдүүлгээс нь залхаж гүйцээд гол төлөв "хэргийн бүрдэл болоогүй", "гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй" гэж үзээд салахын

түүс болдог алмаз Төмөртэй заргалдах нь "Ерөнхий сайдыг коррупцитай холбоотой болохыг нотлохоос ч" хэцүү гэдгийг мэдэх цагдаагийнхны ясны хөлс чийхрав. Гэтэл нэг нь:

-Ерөөсөө Төмөр гуайн машааныг авсан хулгайч нар буцахдаа манай музейг ухсан байна

-Яг тэгэж, бид эрлээ нэгтгэх нь зөв.

-За даа мэдэхгүйдээ. Эд мөрийн баримтны үзүүрээс нэг атгасан хүн ч тавихгүйг л хичээдэг юм даа гэж Төмөр хэллээ.

Ирэгсэд цөм өөр өөрсдийн буруугүйг батална.

-Энэ цамц, шоорт мүзейн юм болохоос миний юм бишээ. Тэгээд ч би ном журамтай ахмад коммунист хүн.

-Коммунист гуай нарыг ч би мэднэ ээ гэж Төмөр ёжгой хэлээд цамцыг Хонгорт өгч: -За миний дүү олонтой газар өмсөж яваад сэжигтэй харсан хүнийг ахтайгаа уулзуулдаг юм шүү гэв.

Цагдаа нар буцах болж Хонгор тэндээ үлдэв. Төмөр тунгалаг Тамирын голоос тул барьж түүнийг дайллаа.

-Дүү минь, ийм ажил хийсний хэрэггүй. Зүгээр л сайн бизнесмэн бол!

-Анх таныг харсан цагаас л ийм ажил хиймээр болоод байх юм. Та яаж сайн эр, загалмайлсан эцэг болсон бэ?

-Ах нь "Алтан гурвалжинд" тангараг тавьсан юм.

-Хаана байдаг юм бэ?

-Тайланд-Бирмийн хил дээр байдаг нэвтрэх аргагүй ширэнгэ. Тэнд дэлхийн мафийн төв байдаг юм. Нэвтэрч ороход тун хэцүү. Тэнд очоод Алтан толгой гэдэг дээр гараад Ал Капони, Холендра Шульцаас авахуулаад л нэрд гарсан загалмайлсан эцгүүдийн нэрийг дуудан тангараг тавьдаг юм. Алтан толгой дээрээс үдшийн бүрэнхийг харсан хүн алдартай мафийн толгойлогч боддог юм гэнэ лээ. Миний дүү ахынхаа үгэнд орж ийм ажил битгий хий!

-Төмөр ах аа ! Дээхнэ манай ерөнхийлөгч Очирбат гуай Тайландын вант улсад айлчиллаа гэсэн. Лав тэр толгой дээр гараа даа?

-Яалаа гэж дээ. Төрийн тэргүүн хүн тийм ажил хийж болохгүй. Тэгээд ч Алтан гурвалжинд очих замд цэрэгжүүлсэн эргүүл маш олон. Тэд үг дуугүй буудах эрхтэй байдаг юм.

-Би л ерөнхийлөгч байсан бол яаж ийгээд очих байсан гэснээ "Манай ерөнхийлөгч жаалхан маанагдуу хүн" гэж ирээд л өндөр настны намын үүрийн дарга Пийдр гуайн ярьдаг ч ортой дог шүү хэмээн Хонгор бодолхийллээ. Төмөрийн ярьсан бүгдээс гагцхүү "Алтан

гурвалжин" гэдэг нэр л үлдэж бусад нь цөм Хонгорын нэг чихээр ороод нөгөө чихээр гарлаа.
Хонгор маргааш нь хот орж Улаанбаатар-Бээжингийн онгоцны билет авлаа.

Тамирын голын хөндий. Урьд нь намын хорооны нэгдүгээр даргынх зусланд гардаг байсан хивс шиг ногоон зүлгэн дээр хэдэн гарааш барьжээ. Алмааз Төмөр Тамирын хөндийгээр хэдэн "жийп", "Уаз"-аа үсэргэн "авторалли"-д бэлдэж байлаа. Хэдхэн хоногийн дараа шадар сайд Пүрэвдоржийн сумын ойн томоохон наадам болох юм. "Финиш" гэсэн бичигтэй улаан даавууны дэргэд Төмөр, Өлзий, гуравдахь нь машин мотоцикль уралдуулж байгаа айлын гадуур өнгөрдөггүй, дэлхийн алдарт хурдан жийпнүүдийн талаар яльгүй жаахан панаалтай юм ярилгүй өнгөрвөл азанд муу гэж үздэг насаараа жолоо мушгисан Өлзийн үе насны өвгөн байлаа.

-Тэр хөх алаг "тоёота" чинь Шварцнеггэрийн хурдан цэнхэр шиг өнгөтэй байна хэмээн өнөөх машины хорхойтой өвгөн их л мэдэмхий хэлэв.

-Шварцнеггэрийн хурдан цэнхэр гэж ямар машин байсан юм бэ? гэж Өлзий асуув.

-Парис-Дакарын уралдаанд долоо түрүүлсэн сайхан жийп байсан юм.

-Та үзсэн үү?

-Олон хүнээс сонссон. Уралдаан эхлэх өглөө астаачир нь өөрөө ажиллаад мотороо асаачихдаг байсан юм гэнэ лээ. Чиний энэ хөх алаг ч энэ жил инфляцийг ч урьдаа гаргахгүй давхих байх аа.

-Машин таньдаг хүний тэрэг л түрүүлдэг юм бол миний хүүгийн хөх алаг түрүүлэх байх гэж Өлзий хэлэв.

-Би таньж юу базаах вэ?

-"Монгол машаан" нийгэмлэгийн дарга, Их хурлын Гомбожав гуай ноднингийн автораллигийн "мааслын тавд" ирэх машиныг, уралдааны комиссынхонд өгсөн хахуулынх нь хэмжээтэй яг хэлж байсан юм гэдэг шүү.

Тэр гурав босож Төмөрийн гэрийн зүг явахдаа сайн тэрэг, сайн жолооч нарын тухай ярьсаар явлаа. Гэрт ороход Төмөрийн хүү Битлз зүүн диван дээр нойрсож байгааг эцэг нь харж магнай дээр нь үнсснээ "мужик" гэж хэлээд нүүрэндээ баясал тодруулав. Тэр гурвын өмнө модон боошигтэй шуугисан пиво тавилаа. Зүүн хойд талын шүүгээн дээр эхнэр хүний парик харагдана. Цаад жил Дулмаа Галсанг "сулралтай болсон" хэмээн шүүх эмнэлгээр заалдаж явж гэрлэлтээ цуцлуулаад Төмөртэй хуримлахдаа Өлзий өвгөнийг ивээл жилтэй хэмээн гэрчээ болгосон ба түүнээс хойш мань өвгөнийг "Крестный" хэмээн авгайлдаг болжээ.

-Одоо цагт ийм аймаар буржийсан хиймэл үс эвгүй бишүү гэж анх Дулмааг парик зүүж эхлэхэд мань Төмөр хэлсэн боловч:

-Тамирын голд Майкль Жексонтой адилхан эхнэр нэгээр нэмэгдэг гэж Дулмаа хариулжээ. Төмөр эхнэрийнхээ хүсэлд саад хийсэнгүй бөгөөд Дулмаад хиймэл үс зохисон нь хэлэхийн аргагүй. Тэдний найрнаас буцаж явсан нэг хүн:

-Дэлхийн миссийг ямар үзсэн бишдээ. Төмөрийн эхнэр ч эхнэр юмаа. Сайхан эхнэрийг хараад эр хүний "чалх" сайжирдаг гэдэг юм. Манай голын сулралтай эрчүүдэд аштай юу гэж ярьжээ.

Тэр орой Төмөрийн хот наадамд явах найр хийлээ. Төмөр нэлээд халж "аавын минь зулай..." гэдэг дууг гитардан дууллаа. Бэлдсэн архи пиво дуусахын хэрд ихэд согтсон Өлзий өвгөн "иссэн болгоныг уугаад соггож болдог" гэж зүтгэсээр байгаад Дулмаагийн талх барихаар исгэсэн хөрөнгийг хүртэл уучихаж билээ.

Наадам эхлэх болов. Наадамчин олны дунд ахлагч Бадарч машины ноймор ачиж ирсэн гэдэг үг нэгээс нөгөөд дамжин тарж шадар сайдын сумынхны хорыг буцалгана. Үнэхээр ч бардам зантай Бадарч У-шугийн тэмцээнд түрүүлсэн тамирчны байнд өгөх суудлын тэргийг авахдаа зүүх ноймор өвөртөлж ирсэн билээ. Уул нь эдний сумынхан сайн зодоочтой айл. Гэвч "Интернациональ" тэмцээний хүрэл медальтай самбочин Бадарчид наадмаа алдах вий гэдэг бодол нутгийн хүн болгоныг зовооно. Бүхэл бүтэн сумыг доромжлон шинэ ноймор ачиж ирсэн Бадарчийн бардам зан "хэдэн банди нарыг нь нам цохиж орхиод өгсөн машинд нь ноймроо хадаад буцдаг хэргээ" гэж хэлсэн үг нутгийнхны хорыг маажжээ. Бадарчийн энэ яриа Төмөрийн чихэнд хүрчээ. Ачааны машины уралдаанаар наадмын эхний өдөр шувтарлаа. Төмөр Зил-130 унаж уралдах жолоочдоо "гараанаас гаруутаа нэг хэсэг тоормозоо гишгэсхийж яваарай" гэж захиад төв асрын зүүн буланд очиж у-шу цохих улсын тоонд нэрээ бичүүллээ. Гэтэл Төмөрт өмсгөл байсангүй. Бадарч самбогийн цагаан өмд цамцаа тайлж:

-Миний хэрэглэлийг өмс. Цагаан жийнсээр хийлгэсэн юм.

-Сум нь том, тамирчид нь олон юм хойно болох байлгүй дээ. Чиний наадах дээр аягүй бол хоригдлуудын цус үсэрсэн эд байлгүй гээд Төмөр хувцсыг авсангүй. Азийн аваргийн тэмцээний хүрэл медаль хүртэж байсан, одоо нас дал гарсан өвгөн нинжа, хэд хэдэн газарт сэлэмний ирэнд өртөн зүсэгдсэн боловч дажгүй сайн өмсгөлөө Төмөрт өгсөн нь яг таарав.

Төмөрийн "Зил-130" арван нэгдүгээр байранд орж, харин жийп нь түрүүлжээ. Төмөр:

-Намайг Бадарч ахлагчтай зодолдуулж өгөөрэй гэж зодооны бичээчид хэллээ.

-Пихлуу чинь самбогийн цолтой болохоороо амарчилж аваад нам цохичихоод болохгүй байна. Та чинь ямар цолтой билээ? гэж тэр хүн тосон балныхаа ишийг амандаа хэмлэнгээ асуув.

-Есдүгээр ангид байхдаа Алтай хотын өсвөр үеийн аварга болж байсан гэв. Төмөр багаасаа сайн зодолддог хүүхэд байжээ. Харин сүүлийн жилүүдэд бие хамгаалагчтай болсноос хойш зодолдох хэрэгцээ гарахаа болиод бие нь баахан нялхрах тийшээ ханджээ. Гэхдээ л алмааз Төмөр бол алмааз Төмөр л шүү дээ. Явсаар байгаад сүүлийн тойрогт Бадарч мань Төмөртэй яах аргагүй туналаа. Бадарч Төмөрт:

-Өвгөн чинь ам гарсан хүн. Чамайг л өнгөрвөл бусдыг нь ганц ганц шаагаад л нам болгоно. Чи надад бууж аль, хоёр цоо шинэ мотоцикль өгье.

-Дэмийр! Чадлаа мэдэхгүй байж яах гэж бүхэл бүтэн суманд ам гарсан юм бэ?

-Чамд ам гараагүй. Чи бид адилхан эр улс шүү дээ

-Тэр тусмаа үзнэ дээ гээд Төмөр цагаан алтан бүрээстэй бриллиантан шүдээ яралзуулан инээв. Бадарчийн цусны даралт таван атмосферээр нэмэгдэж эргэн явлаа. Бадарч тэндээсээ гараад гүрэмч, хараалч, сексч хэмээн юм юмаараа нэрд гарсан урт гэээгтэй хууз сахалтай ламынд очиж гурван ээлжийн хөнжлийн даавуу хоёр блок гондоомтой барьж Төмөрт хараал хийж өөрийг нь түрүүлүүлж өгөхийг гуйгаад "тэр нохойг газардуулж өгвөл унаж яваа жаран есөө орхиод явна" гэлээ. Өөрт байнга хэрэг болдог юмсыг нь бариад зогсож байгаа Бадарчийг мөнөөх лам учиртай харснаа:

-Би чинь энэ сумын харьяат шүү дээ

-Хорийн канистр бензин нэмлээ.

-Нутгийн ах дүүс мэдвэл юун бензинтэй эсэн юм болно.

-200 литр бензиний толоон нэмэе.

-Чи өөрөө амаа сайн хумхиж яваарай.

-Тэрнийгээ би мэднээ гээд Бадарч явжээ.

Барилдаан эхэллээ.

-Мастер нь заагаад өгнө. Битгий яар гэж шадар сайдын хөх ирвэс хэмээн У-шучдын дунд нэрд гарсан дасгалжуулагч нь Төмөрт хэлж байлаа. Бадарч өөрийн хийж гаршсан "Байдсан гүү гишгэх" гэдэг айхавтар түрэмгий мэхээ хийж Төмөрийн дээрээс дарах гэтэл цаадах нь "Азарган үрээ агтлах" хэмээх баргийн хүн хийж чаддагүй мэхээр хариу бариад хөөрхий Бадарчийг золтой л голоор нь цуулаад хаячисангүй. Бадарч цавь руугаа гараа хийж үзээд нойтон юм тааралдсангүйд жаахан санаа амран зогсож байтал гол асрын өмнөөс жижигхэн хуй босож эргэлдсээр ойртохыг харж ламын хараалын тэмдэг гэж үзээд ойртож ирэнгүүт шороо атган авч Төмөр лүү гурав цацаж зургаа нулимаад эх бурхан, эцэг бурхан, хүү бурхан гэж гурав загалмайлаад Төмрийн толгой руу өшиглөхөөр хөлөө явуултал цаадах бултаж, Бадарч хүчиндээ шурган унахдаа баруун гараараа газар тулж авлаа.

-Бөлдөгдөөд, бөгс рүү нь амбаард! гэж өвгөн дасгалжуулагч байдаг хүчээрээ хашгирахад Төмөр бүгдийг ёсчлон хийвэл Бадарчийн урт бие газар тэврэн унав. Шүүгч ес хүртэл тоолоход тэр өндийсөнгүй. Наадамчин олон баярлан уухайлж "Төмөр Вива. Бийс,Браво..." гэлцэн шүгэлдэж байлаа...

Эрдэнэ засгийн газрын хуралдаанд аймгийнхаа төсвийн төлөвлөгөөг танилцуулахаар хотод иртэл Данзан дарга түүнийг дуудуулжээ. Данзан түүнийг магтах гэж дуудуулаагүй нь лавтай гэдгийг Эрдэнэ мэдэж байлаа. Данзан өөртэй нь зөрөлдсөн хэдэн хүнийг эрх мэдлээ ашиглан байж улсын сангийн алтыг гулууз гулуузаар нь идсэн хэмээн хэрэгт оруулж дөнгөсөн тухай Эрдэнэ сонссон билээ...

Эрдэнийг хармагц Данзан их л дотночлон инээмсэглэж, угтан ирээд гарыг нь хэзээнээс нааш ганц нэг юм хувааж сурсан танил хүн мэт барьж зэрэгцэн суулгаад:

-Аймаг чинь төсвийнхээ орлогын наян хувийг мөн л архинаас олсон хэвээрээ юу, замдаа Хар хориноор дайрч ирэв үү? Тэнд чинь спиртийн үйлдвэртэй билүү? гэх зэргээр асууж хариултыг тэмдэглэн авсан ба ханын шүүгээнээсээ спирт гаргаад чанга найруулан дайллаа.

Данзан цааш нь: -Улс орны байдал улам хүнд болж байна. Зуун хорин жил идэж хүрнэ хэмээн Чингисийн үеэс хадгалсан наян хасаг тэрэг алтыг хэдэн болчимгүй залуус "диллэр" тоглоод мөрийндээ аваад идчихсэнээс болж ард түмэн "амаараа шороо үмхсэн" тухай туйлийн гашуудалтай яриад, ширээнээсээ боодолтой нунтаг гарган халбагдаж эхэлсэн нь "өөрийнх нь үмхэж байгаа шороо" ажээ. Манай орны эдийн засгийн байдал хүнд, спиртийн үйлдвэрүүд даанч цөөхөн байгааг тэрбээр дурьдаад, Хятад улсын хувьд ухаантай бодлого явуулах чухал гэж ярилаа. Манай ард түмэн хятадын бараа ялангуяа архинд сүүлийн хэдэн жил тун их даслаа. Нэг л өдөр өвгөнт архиа оруулахаа болилоо л гэхэд энэ өвгөнтийн хөндийн ард иргэд харангадаж үхээд сонгогч олны санаа сэтгэл алдагдах болно. Ингэвэл яах вэ? гээд Эрдэнийг цоо ширтэв.

-Тэгвэл хандивлагчид туслана. Япон туслана гэж Эрдэнэ хэлэв

-Хандивлагчид! Япон! Өөрснөө арал нь дэлбэрчих гээд ядарч байна шүү дээ гээд Данзан хүйтнээр инээмсэглэв.

Данзан сонгуульд онц идэвхтэй оролцож төрийн өндөр албан тушаалыг эзэгнэх болжээ. Гэвч сүүлийн үед баяжихын тулд банк нэртэй болгонтой сүлбэлдэн тэдэнд л ашигтай бол ямарч хамаагүй заалтуудыг хуулинд оруулахаар хөөцөлдөх болжээ. Энэ ажилд нь ардчилсан хүчнийхэн хань болохгүйг мэдсэн Данзан тэднийг улайран эсэргүүцэгч болжээ. Гэтэл энэ үед Олон улсын валютын сангаас зөвлөх Наарыг ирүүлэн, Рейган багшийн заасан коммунист бус хөгжлийн замыг монголчуудад сонгуулжээ.

"Энүүнд архинаасаа дахиад өгөх хэрэг байна уу?" гэж Данзан бодох зуураа, эхнээс нь хэрэггүй л задаллаа хэмээн өөрийгээ зүхлээ.

-Тун удахгүй их хурлын чуулган эхэлж манай орны цаашдын хувь заяатай холбоотой асуудал хэлэлцэнэ. Та энэ талаар ямар бодолтой байна вэ? гэж асуув. Эрдэнэ энэ асуултад сэтгэл хөөрөн:

-Би ерээд оны эхээр нэг америктай танилцсан юм. Хожим нь манайд АНУ-ын бүгд найрамдахчуудын институтын шугамаар семинар хийхээр ирж байсан. Та таних ч байхдаа, Арьнольд Шварцнеггер гэж. Тэр дандаа хэлдэг байсан юм. "Танай орон хүний эрхийг

дээдэлсэн ардчилсан улс болох ёстой, Алтаа дандаа гадаадын найдвартай банкинд хадгалуулан, цэвэршүүлж бай!" гэдэгсэн. Тэр бас банкирчдыг төр засгийн толгойд гаргах тун осолтой, лобби хийж мөнгө цохиод болдоггүй юм гэж дандаа захидагсан... гэж хариуллаа. Данзан энэ бүхнийг арай ядан тэсвэрлэж сонсоод хармайнаасаа лонх хэлбэртэй усан цаг гаргаж ирээд:

-За би таны дотрыг сайхан заслаа. Би өөр хүнтэй уулзах учраас удаан ярьж чадахгүй байна гээд бослоо.

Данзан Эрдэнийг явсны дараа компьютерээ асаан "маш нууц" гэсэн файл гаргаж "Архангай. Цогтын Эрдэнэ" гэж бичлээ. Энэ бол засгийн эрхийг Данзан авмагцаа "Улсын сангийн алтыг гулууз гулуузаар нь идсэн, идэхэд тусалсан, идсэн явдлыг буруушаахгүй байсан" хэмээн цаазлах улсын нэрийн жагсаалт ажээ.

Итгэлтийн чиргүүлтэй "камаз" хотод ирээд бүтэн хоёр хоносон боловч ерөнхийлөгчтэй уулзах чин хүсэлтэй түүнд дайгдаж ирсэн Ням өвгөн Улаанбаатарыг үзэж чадсангүй. Толгойтын тэнд нэг айлын хашаанд ачаатай машинаа мануулахаар түүнийг орхисон байна.

-Зэврүүн байна, ходоодоо дулаацуул гэж түүнд Нэг шил найруулсан спирт өгсөн нь ерөнхийлөгчтэй уулзах хүслийг нь мартуулснаар барахгүй "Энэ машинуудыг надаас өөр хэнээрч мануулах юм билээ" гэж хэлүүлжээ. Очсон орой нь том дүгэрэг мөнгөн сар гийгүүлэн гарахад хамт машинаа харж үлдсэн нэг нь түүнийг харж байсна:

-Пээ яасан сайхан сар вэ? Манай Тамирт гарч байгаа болов уу? гэж асуухад Ням өвгөн их л мэдэмхийрэн:

-Хаанаас гарах вэ? Энэ чинь улсын нийслэлийн сар. 500 000 хүнтэй том хотын сар болохоороо ийм том байгаа юм. Манай сумын сар бол хамаагүй жижигхэн байдаг юм шүү дээ"гэж хэлжээ.

Хоёр дахь өдрийнхээ өглөө босоод хоосон лонхоо шиншилж гомдолтой хараад "Итгэлт муу гайхал намайг энэ хэлхээтэй төмөртэй хотын захад үүрд аргамжъя "гэж бодоогүй бололтой хэмээн үглэж байтал Итгэлтийн явуулсан хүмүүс ирж халааг нь авлаа. Нямыг очиход үлэмж ашигтай наймаа хийсэндээ сэтгэл ханасан Итгэлт халамцуу байсан ба Ням өвгөнийг Улаанбаатарт оруулан хуйцаагаар дайлж, шотланд виски уулгажээ.

-Ням гуай минь одоо цаад ерөнхийлөгчтэйгээ уулзаж ноднингийн сонгуулиар өөр хүний төлөө саналаа өгсөн нүглээ наманчилж үз! гээд хөх цэнхэр мянгат гурвыг өгчээ. Ням өвгөнийд өнгөрсөн жил болсан ерөнхийлөгчийн сонгуулийн өдөр хэн нь юм бэ, нэг дарга давхиж ирээд тампуу ном харуулж:

-Энэ бол Түдэвийн зохиосон тууж роман гэснээ сонин сэтгүүлийн хэдхэн хайчилбар үзүүлж: -Харин энэ бол Очирбатын бүх бичсэн юм. За одоо хэний нь төлөө санал өгөх гэж байна? хэмээн тулгахад нь "Олон хуудас юм бичсэн нь л илүү байдаг юм байгаа биз" гэж бодоод л Түдэвийн төлөө саналаа өгч орхижээ. Орой нь энийгээ их сонин болгон Итгэлгэд ярьтал цаадах нь тунч ёозгүй царайлан:

-Илтгэх хуудас, тайлан, өргөдөл, нэртэй нэргүй матаас мэдээллээс нь авахуулаад л манай хадам хөгшний цоохорлосон цаасыг цуглуулах юм бол ч газар тулдаа л даах..." гэснээ гараад явчихжээ.

-Нүглээ наманчлаад ч юу шалих билээ. Ядаж нэг хамт зургаа татуулчих юмсан хэмээн Ням өвгөн улаа бугарч суулаа.

-Та чинь Улаанбаатарыг их л хол байдаг юм яриад байсан бил үү?

-Яриад яах вэ! Улаанбаатар хол, ухны сахал богино гэж үгтэй юм даа хэмээн хөгжилдөв

-Ням гуай ч газар үзэж нүд тайлж явах шив дээ?

-Хэлээд яах вэ? Тамирын голоос өнгөрвөл "О" өргөрөг байдаг, танидаг хүүхний тоо Хишигтээр дуусдаг гэж бодож явсан би их юм үзлээ гэв.

Ням өглөө эртлэн босож төрийн ордныг заалган явлаа. Гэтэл төрийн ордны баруун өмнө талын олон давхар байшингийн үүдэн дээр том цүнх үүрсэн бүдүүн хар авгай дээр баахан хүн овооролдон байхыг үзвэй. Нэг улаан хамартай нөхөр лонхтой юмнаас амсаж үзснээ:

-Найруулчихсан юм байна шүү дээ гэхэд нөгөө авгай:

-Юу ярьж байгаа юм бэ! Наадах чинь дэлгүүрээс авсан АПУ-гийн архи гэлцэн маргалдана. Тэр бол шагийн архи хэмээн эсэн бусын юм холин худалддаг авгай байжээ. Танил дотно үнэр Ням өвгөний хамарыг цохиж барьц алдууллаа. Ням өвгөн чигээрээ алхах гэснээ тэссэнгүй

-Наймаа юу байна ? гэж суулаа

-Үйлдвэрийн архиа аваарай

-Хэд гэж байгаа юм бэ ?

-Мянга хоёр зуу.

-Больж үз алив амсая? Нэг л гаж амттай

-Дургүй байвал болихгүй юу?

-За за авья гээд өврөөсөө нэг аяга гарган ууснаа дараа нь өнөөх шагчин авгайд өөрт нь хийж өгөн дайллаа. Тэрээр ийш тийшээ хяламхийн харж байснаа татаж орхив. Тэгээд тэр хавьд тэнэж явсан гудамжны нэг архичныг дуудан хувааж ууснаа мөнөөх шагчин авгайг дахин дуудлаа. Хоёр шил найруулсан спирт авч уусны дараа Иггэлтийн өгсөн мөнгө ч дуусаж, Ням өвгөн ч согтож төрийн ордноос өөр зүгийг зорилоо.

-Даабл хангайс лээнд...(Хоёр хангайн нутаг) хэмээн англиар дуулах аядаж явтал гэнэт хоёр цагдаа бариад авах нь тэр. Цагдаа нар Ням өвгөнийг нэг буланд аваачин нэгжиж үзээд сэтэрхий тэвнэ ч олоогүй тул "дэгээнд нь том юм таарахаар нь баярлан таттал ханзархай гутал гарсан загасчин ” адил нэг хэсэг санаа алдан зогсов.

-Эрүүлжүүлэхэд хүргэх үү?

-Яршиг яршиг яарч байна.

-Наадахад чинь тэгээд юу ч алга уу

-Ёстой хувхай хоосон юм аа

-Яаж хэдэн цаас олдог билээ.Ходөөний иймэрхүү өвгөчүүл овоо нүнжигтэй байдагсан. Энгийг чинь ингээд олны нүдэн дээр орхиж болохгүй байна. Эрүүлжүүлэхийн тэрэг

ингэсгээд ирэх биз?

-Ингэхэд чи "Нүгэл буян" сониноос шагналаа авсан уу?

-Аль хэзээний аваад идчихсэн. Дахиад юм бичих гэхлээр сонин мэдээ олдохгүй юм.

-Наад өвгөнөөсөө асуу!

-Хөөе өвгөөн! Танай тэнд хүн амийн хэрэг гарсан уу?

-Аан? гэж нүүр лүү нь хэсэг гөлөрснөө: -Хүн амын тооллого болсоон, болсон гэж Ням өвгөн хэллээ?

-Үгүй ээ. Хүн алсан үхсэн явдал гарсан уу ?

-Аа... гарсаан гарсан ???

-Өнгөрсөн хавар Долгор гэдэг нөхөртөө хаягдсан хүүхэн Туул голд унаад... Зах зээлээ гэж олон хүний толгой залгиж байна даа... гэснээ нэгийх нь гарыг дэрлэн хүнгэнэтэл хурхирлаа. Долгорыг үхсэн тухай цуу анх ингэж гарчээ.

Маргааш өглөө нь Итгэлт эрүүлжүүлэх байранд ирж Ням өвгөнийг авлаа.

-Та чинь яаж яваад энд орчихдог билээ хэмээн Итгэлт егөөтэй асуув. Ням хэсэг хулмалзснаа:

-Төрийн ордноос гарч яваад ... хэмээн зориг муутайхан хэллээ. Эрүүлжүүлэхийн жижүүрээс бүх учрыг мэдсэн Итгэлт цаашлуулж:

-За тэгээд Очирбат ерөнхийлөгчтэй уулзаж чадав уу?

-Уулзсан уулзсан гэж Ням хэлээд цааш харав.

-Тэгээд ерөнхийлөгч ямаршуухан суух юм бэ дээ

-Төрийн ёслолийн өргөө гэдгийнхээ хойморт, Азийн нэгэн барын арьсан дээр суугаад л, төрийн хан хуурандаа "жонон хонгорыг" оруулсан шигээ, экспортонд гаргадаг захиалгын цагаан архи зооглож байх юм.

-Ерөнхийлөгч хүн болохоороо таныг таньж байгаа биз дээ?

-Хэлээд яах вэ? Та чинь Архангайн Ням гуай шив дээ гэсэн.

-Та ч тийм л гэсэн биздээ... За тэгээд хоол сархад гээд сүйд болж байна уу?

-Тэгэлгүй яах вэ! Тэргүүн хатагтай Цэвэлмаагаа дуудаад Ням гуайд хуурай спирт уулга, хонь гаргаж өг! гээд сүйд. Тэгтэл Хүнс хөдөө аж ахуйн сайд Өөлд гуай нэг хонь хөтлөөд

ороод ирлээ. Ерөнхийлөгч чинь зэвсэгт хүчний ерөнхий командлагч юм болохоороо Жадамбаа гэгч генералыг дуудаж ирээд хонио гаргууллаа. Удсан ч үгүй Эрчим хүчний сайд Жигжид гуай дөрөвдүгээр цахилгаан станцынхаа тогоон дотор өнөө хонины махыг чинь ялз хорхоглоод аваад ирлээ. Тэндээс гарч яваад ингэж балрахгүй юу гэж Ням өвгөнийг ярихад Итгэлт элгээ хөштөл инээлээ.

Сонгуулийн сар гэгдэх болсон зургадугаар сарын урт өдрүүд дуусаж, ялсан намын найр, ялагдсан намын "дотроо онгойлголт" давхцсан намрын "найртай" өдрүүд эхэллээ. Гил хар өнгийн суман жийп унасан Эрдэнэ гүн сэтгэлгээнд дарагдан явах бөгөөд аймгийн зам ангийнхны гаргасан суваг шуудан дээгүүр гарахдаа хаазаа сурмагаар тохируулна. Эрдэнэ засаг дарга болсноосоо хойш нэг ч шөнө эр хүний хийдгийг хийх зав гарсангүй. Төр засгийн ажил нь тогтоол шийдвэр лиценз зөвшөөрлөөр яваад л байвч амин хувийн амьдрал нь нэг л явж өгөхгүй байлаа. Долгорыг амьд мэнд гэдгийг дуулуутаа л давхиж хүрсэн боловч цаадахь нь хүний урманд аяга байхуу уулгасангүй гаргажээ. Тэгэхлээр нь хүүгээрээ зад панаалдуулж уяруулахаар шийдэн Батынхаа өвөрт хоёр шил хатуу вино хийгээд явуулсан нь ч талаар болжээ. Нэг өдөр нарийн бичгийн дарга нь:

-Тантай уулзана гэж нэг шал миа авгай ирээд... дарга хүн хүлээж авахгүй гээд байхад "намайг заавал хүлээж авах учиртай" гээд маанагтаад байхаар нь би харуулын цагдааг дуудаад бариулчихсан. Та ямар хачин эмэгтэйтэй танил юм бэ! хэмээн урт сормуусаа дэрвэлзүүлэн хардангуй хэллээ.

-Ямархуу хүүхэн байна?

-Хүүхэн биш ээ авгай

Долгор байх гэдэг бодол Эрдэнийн дотор орж ирсэн боловч засаг даргатай алба амины ажлаар уулзах гэж аль авгай ирэхийг тэр гэх билээ.

-Яалаа гэж хамаагүй тэгж болох ю! суллаад оруулаад ир! гэж Эрдэнэ хэллээ. Тэгээд кофе уужээ суутал Долгор орж ирлээ. Хүний алим илүү харагддаг онол ёсоор Долгор урьдаасаа илүү хөөрхөн болсон харагдав. Эрдэнэ түүнийг хэрдээ л хөл алдан угтаж нарийн бичгийн дарга хүүхнээ уурлуудан байж "диско" бэчээн, бразил кофегоор дайлсан боловч цаадахь ер уярсангүй. Хүүгэйгээ уулзснаа товч мэдээлээд "би чамтай уулзах гэж цаг авсны учир бол... би өөр хүнтэй суух гэж байгаагаа чамд албан ёсоор мэдээлэх ...гэж" хэмээн Долгор шийдэмгий хэлэхэд Эрдэнэ:

-Би чамд "саанкц" өгөхгүй хэмээн хашгирлаа.

-Чи чадахгүй Эрдэнэ минь! Тэр жил Итгэлт бид хоёрыг зодоод зугтаж алга болсны чинь хойно чамайг сураггүй алга болсон хүмүүсийн жагсаалтад бүртгүүлэн гэрлэлтээ цуцлуулсан.

Эрдэнэ удтал бодол болон дуугүй сууснаа:

-Би чамайг хоёр ч дахиад жирэмслүүлж чадсан шүү дээ гэж дорой дуугаар хэллээ.

-Хн! Итгэлтийн дэргэд ичмээр хэвгэж!. Хоёр гэнэ шүү. Нэгийг нь ч хаашдаа аборт хийлгэчихсэн... Хүү маань том болж, саяхан нэг жаахан охинд ерөндог тавиулаад л явж байх чинь билээ гэж нухацтай хэлсэн түүний үгэнд "одоо чи бид хоёрыг холбоод байх юм байхгүй болсон" гэх өнгө илэрхий. Долгорын нүд "Намайг хэмх элэгдээд зугтааж одоход чинь энэнээс жаалхан хүүхэд, саяны хэлдгээс чинь олон жирэмслүүлэх бололцоо байхад олж харалгүй л явсан шүү дээ" гэж хэлээд байлаа. Эрдэнэ:

-Би тэгэхэд дэндүү "хаард" загнасан байна билээ.

-Чи одоо хуучин Эрдэнэ минь биш болжээ. Би ч нью Долгор болсон.

-Бүхнийг мартаад шинээр эхэлж болох шүү дээ.

-Болохгүй байна, Эрдэнэ минь! Би чиний хиртсэн дотоожийг бишгүйдээ л нэг угааж явлаа. Харин хиртсэн сэтгэлийг ОМО нунтгаар угааж болдоггүй юм байна.

-Би чинь Эрдэнэ чинь мөн шүү дээ. Чи миний паспортыг хар л даа.

-Миний сэтгэлд хуучин Эрдэнэ минь биш болсон.

-Чи тэгээд хэнтэй суух гэж байгаа юм бэ?

-Содном даргатай!

-Юу? Чи тэр настай хүнд сэтгэлтэй болж орхио юу? Эсвэл цаадахь чинь тийм их мөнгөтэй хэрэг үү?

-Хуучин Эрдэнээгээ бол сайд нарын зовлөлийн зуун даргаар ч солихгүй байсан. Одоо бол ганцаар л тулж орхино. Тэр бид хоёр зовлонгийн дунд ижилдсэн юм. Би чамд хаягдаад хэзээ ч эргэж ирэхгүй нохрөө хайгаад явж байхад, Содном гуай мөн хэзээ ч олж чадахгүй газрын тосоо эрж яваад тааралдаж зовлон жаргалаа нэгтгэсэн юм.

-Чи тэгээд үнэхээр Содномтой (түүнийг энэ удаа гуайлсангүй) суух гээд байна уу?

-Суухаар барахгүй, хэвтэнэ дээ. Би шийдсэн гээд Эрдэнэ рүү "Нүд-Нүд" ангиллын ширтэлт хийв. Эрдэнэ "Чи минь намайг битгий хаяач! " гэж уйлан гуймаар санагдавч, эмэгтэй хүн гуйх тутам цаашилдагийг мэдэхийн дээр, бүхэл бүтэн аймгийн засаг дарга хүн байж нэг муу тэтгэврийн сайдтай хөгшин хүүхэн булаалдаад ч яах юм билээ гэсэн бардам сэтгэл төрж биеэ барилаа.

-Эрдэнэ минь эмэгтэй хүн "Эго" давхаргаа цоортол эр нөхөртөө үнэнч байж байгаад түүнээс хойш өөр хүнд үнэнч болдог гэж Зигмунд Фройд багш сургасан юм шүү дээ! Ингэдэг номтойгоос хойш намайгаа уучлаарай! гээд Долгор явсан ба хэдэнхоногийн дараа мөнөөх Содномтойгоо хөнжил нэгтгэжээ.

Содном бол хойт зүгт их шүтлэгтэй хүн ба нүүх суухаасаа эхлээд хамаг юмаа хойноос асууж сурсан нэгэн ажээ. Ямар сайндаа газрын тос хайж байхдаа мэргэжилтнүүдийнхээ олсон газрыг өрөмдөхийн оронд:

-Хойноос асуусан чинь энд өрөмдвөл өлзийтэй гэсэн хө! гэж ирээд цохионы орой руу өрөмдөж байх вэ! Тэрээр нэг өдрийг октябрийн хувьсгал мандсан өдөр хэмээн их л хүндэтгэн идээ будаа өрж хурим найр үүсгэх ба өөр нэг өдрийг хувьсгалт засаг унасан өдөр хэмээн их л цээрлэн зул хүж өргөж маань уншин мацаг барьдаг байжээ. Долгорын суусан Содном бол иймэрхүү, ер нь л бүх юмаа хойд талаар мэдүүлсэн нэгэн байжээ.

Өнөөгийн Долгор тэр жил дискон дээр танилцаад ганц үнсүүлэн сэтгэлээ нээж Эрдэнийн эхнэр болсон Хүнхэр зуслангийн бор хүүхэн биш "долоон удаа анхны шөнийг үзүүлж, долоо дахиад битүүрч онгорсон" их гарын мисс болжээ. Амьдрал фройдизмоор явдаг гэж итгэдэг болсон энэ хүүхэн Эрдэнийг сайжруулж сольё гэж бодоогүй ч гэсэн Зигмунд Фройдынхоор бол ингэх ёстой хэмээн өөр хүнтэй суулаа.

Эрдэнэ Долгорыг дөнгөж явуулаад сууж байтал хотоос Данзан даргаас нэгэн албан бичиг ирүүлснийг бичээч нь авчирж өглөө. Уг бичигт манай улс хичнээн олон банктай байна төдийчинээн их хөгжих тухай өгүүлээд дүрмийн сангаа бүрдүүлж чадалгүй дампуурч байгаа нэгэн банкиг Монгол улсынхаа тусын тулд хөл дээр нь босгохын үүднээс аймгийн төсвөөс зуун сая төгрөгийг уг банкинд хандивлах, үүнээс үүдсэн төсвийн цоорхойг нөхөхийн тулд төрөл бүрийн албан татварыг нэмэхийг шаардсан байв. Төсвийн мөнгөнөөс элдэв хандив зээл өгөхийг хориглосон байдгийг Эрдэнэ бодож гайхлаа. Дээр нь ийм хэмжээний мөнгийг тэр банкинд үнэхээр хандивлаж өгөх болвол аймаг нь энэ өвөл гэрэл цахилгаангүй ус уургүй өвөлжихөөс гадна өөрөөсөө өөр нэг ч хүнд цалин өгөлгүй бүгэн жил зүтгүүлэх хэрэгтэй байв.

Эрдэнэ хариуд нь "Дүрмийн сангаа бүрдүүлж чадахгүй байгаа банкинд тусламж үзүүлж байгаа юм бол газрын ойр, мөн аймгийн дэвсгэр нутагт байрладаг зэргийг харгалзан "Алмаз Төмөр ба түүний хүүхэн" хувийн банкинд 200 сая төгрөг хандивлах саналтай" байгаагаа Данзанд фааксдсан боловч хариу авсангүй.

Намрын нэгэн зэврүүн өдөр билээ. Салхи өглөөнөөс эхлэн зүүн хойт зүгээс 6-10 метр/сек хурдгай салхилан нэг л ёозгүй байлаа. Урин цаг бол ч удахгүй дулаарна биз дээ гэсэн бодол төрөөд өнгөрнө гэж бодохсонж. Одоо бол харьж яваа цаг болохоор хоёрын хоёр дублёноктой хүнд ч гэсэн "зуу татахгүй бол даарах нь байна шүү" гэсэн бодол төрүүлнэ. Эрдэнэбулган сумын зочид буудлын үүдэн дээр нэлээд халамцуу залуухан лам, англи цэмбэн шинель өмсөж хоёр ч бороохойгоор гангалсан армийн офицер хоёр пан гөрж зогсоно. Лам нь Цамба, офицер нь Жамбал.

Жамбал Ховдод томилогдон хэдэн цэргийн хамт яваа бөгөөд унаж яваа хуучин Т-34 танкандаа засвар хийлгэх нэрийн дор хуучин "эвлэлийн анд" Цамбатайгаа уулзан бааранд сууж бардаак хийсээр хэд хоножээ. Жамбал зэвсэг техникийн үнэ хадсан өнөө үед армийн хэрэгцээний машин, танк зэргийг афганы душмануудын цэргийн олзноос хямдхан худалдаж аваад Баян Өлгийгээр дайруулан хөлөөр нь оруулж ирнэ хэмээн Батлан хамгаалахын сайд Жадамбаагаас чамгүй доллар авсан ба түүнийхээ ихэнхийг эндхийн хүүхнүүдэд тараагаад дууссан нь эрүүл үед толгойд нь орж ирэн зовоох тул эрүүл цаг гаргалгүй савахыг эрхэм болгон яваа нь энэ. Гэтэл өнөөдөр Жамбалыг энэ хэргээс амархан мултлах аргыг Цамба олжээ. "Догьчуулын гар нийлбэл, долоогоор тамгыг дарна" гэдгийн үлгэр болж Бадарчтай тааралдан найздаа тохиолдсон гай зовлонг яривал "Би тавин жийп арав арван мянган доллараар олж өгье" гэж хэлжээ. Жамбал нэг жийпэнд 35-40 мянган ам. доллараар бодож мөнгө авсан тул уусан мөнгөө нөхөх төдийгүй дахиад хэдэн шөнө хүүхэн авах мөнгө цаана нь унаж байлаа.

-Чи хаанаас ийм хямдхан жийп олох юм бэ? гэж Бадарчаас асуувал:

-Энэ чамд хамаагүй. Харин та хоёр хүн амьтанд битгий хэлээрэй

-За

-Тэгвэл бид жийпнүүдээ Солонготын даваа давуулж өгнө. Жийп өгсөн цагт дойлуур миний өвөрт орно. Ингэж тохирно гэвэл өнөө орой Да чавганцынд очоорой! Тэнд та хоёрыг нэг хүнтэй танилцуулж өгнө гэж хэлээд Бадарч явлаа.

Бадарч ийм хямдхан жийп хаанаас олох юм бэ? Тавин сайн жийп олно гэдэг тавин хуучин Б-69 олохтой адилгүй. Гэвч Бадарч өчигдөр орой энд наймааны ажлаар ирсэн хулхи Жагайтай уулзаж тохирсон нэг зүйл бий. Тэр бол өнгөрсөн намар Шадар сайдын сумын ойгоор наадмын түрүүг авах санаатай ноймор ганзагалж очоод У-шугийн тэмцээнд Төмөрт хэмх бөлдөгдүүлж бай шагналаа алдсан төдийгүй хэдэн сар хүүхнүүдэд "сулралтай" хэмээн шоолуулж явсны хариуг авах тухай яриа юм. Тэрбээр хулхи Жагайтай архидаж суугаад:

-Төмөрийн согоо шиг хэдэн жийпийг хулгайлаад хил дээр аваачин шууд бартер хийж өгөөч ! гэж гуйжээ.

-Төмөрийн машинуудыг гэнэ ээ? Тэгж үхсэнээс СПИД тусаж үхсэн минь дээр!

Алмаз Төмөр Архангайд манаргаж яваа тухай мэдээ уншаад хулхи Жагай нэг хэсэг нойр нь хүрдэггүй седуксин ууж үзжээ. Эрээний ойролцоо, Борхойн талд гааздуулан үхсэн гэж

итгэж явсан Алмаз Төмөр амьд байгаа ажээ. Түүнтэй манай гариг дээр дахин учирвал шууд л нөгөө ертөнц руу зугтаахаас өөр замгүй болно. Гэтэл Бадарч ахлагч "гараашийг нь ух!" гэж байдаг. Машиных нь тоогоор гулууз алт өгье гэж амласан ч хийх ажил биш.

-Гараашийг эвдээд зөөчихгүй юу? Цагдаагийн хэсгээс гарах эрэн сурвалжлах группд хаашдаа би орно шүү дээ. Хөгшин чинь мөрийг нь төөрүүлж орхиле!

- Тэр чинь Алмаз Төмөр шүү дээ! Өөрөө мөрдөж ирээд л барьж аваад модноос дүүжлэн паяалагнагдаж орхино шүү дээ.

Бадарч хэсэг зуур пауз авснаа:

-Би эзгүй газар амдан хүлээж байгаад учрыг олчихье. Надад гуран дарвийнк, хоёр халиавар, нэг карбин бас гранат хүртэл бий.

Хулхи нүдээ алгуур эргүүлж Бадарчийг шалган харлаа. Үнэхээр тэгж чаддаг бол ч... гэхдээ тэр чинь хоёр баллон газ уушгийг нь тэлтэл шахаад элсэн говьд уух пепсигүй хаяхад үхээгүй алмаз Төмөр шүү дээ.

-Ээ дээ больё өвгөн минь

Бадарч элдэв янзаар гуйж эцэст нь таван зуун кило ноолуур өгөхөөр болж байж сая яриа тохирлоо.

-Чи миний мөр дээр Төмөрийг хүлээх хэрэг үү?

-Тэгнэ. Хөгшин эхлээд дарвийнкаараа буудаж шархадуулаад, дараа нь карбинаараа хулхиар нь хийгээд үхмэгц нь энэ гранатыг ануусаар нь хийж дэлбэлээд үзэх мөргүй болгоно.

-Алдаж балрав даа. Цаадах чинь Засгийн газар, сөрөг хүчин хоюуланд нь нүүртэй их гарын загалмайлсан эцэг шүү дээ.

-За тэгж дандаа "азаартаж" байх юм гэж хаа байдаг юм бэ? Машиныуд Бадарчийн гарт ороход ноолуур чиний машинд ачигдана.

Энэ хоёр ийнхүү ярьж тохирчээ. Гэтэл өнөөдөр тэрхүү машинуудыг Жамбалд дамжуулан далд оруулах аятайхан нүх олжээ. Цамба, Жамбал хоюул сэтгэл уужран алхаж яваад нэгэн орон сууцны байшингийн өмнө ирэв.

Жамбал нэгэн хашаа руу зааж:

-Эд нар байгаа л биз дээ хэмээн асуугаад нүдэнд нь тачаалын гал бадрав.

-Чимиг хүүхэн Ардчилсан холбооны гишүүн болоод хот руу улс төрийн боловсролын Академид суралцахаар явсан. Харин Цэцэг өмч хувьчлалаар хөгшин эхийнхээ цэнхэр тасалбарт хэдэн мал олж аваад энэ Цагаан давааны ард гуанз нээсэн. Эртүүд би хорин доллар өгөөд бараагүй шүү

-Үнийг нь ханатал өгье гэж хэлэхгүй дээ хэмээгээд Жамбал тас няс инээв.

Тэд явсаар Да чавганцын хашаанд болзсон уулзалтдаа очлоо. Бадарч, Цамба, Жамбал гурав "рояль" спирт гурав найруулан уулаа. Дараа нь тэд даалуу тоглов.

-Танай аймгийн засаг дарга хэн бэ?

-Нөгөө Эрдэнэ... Ромбо хээтэй чанс, Ролик хээтэй зургаа хэмээн чанс чулуудав.

-Ямар Эрдэнэ?

-Яагаав дээ нөгөө Итгэлтийнд брокер байсан Эрдэнэ. Тэр чинь засаг дарга болоод мандаж яваа.

-Аль тийм "п...нууд" мандаж явахыг тэр гэх ю? гэж Бадарч хорсолтой хэлэв.

-Юу гэнэ ээ? Чи бараггай холиогооч! гэж Жамбал хэлээд муухай харлаа. Нэгдүгээрт засгийн албанд зарагдаж яваа хүний дэргэд засаг даргыг хараасан хоёрдугаарт дороо байсан нэг бажгарыг нүд хариулан сольж орхисондоо бантсан Бадарч:

-Гэхдээ тэр чинь перфект англиштэй сүрхий пихлуу гэхчинэ билээ хэмээн займчууллаа. Гэрийн дотор нэг хэсэг нам гүм болж зууханд шатаж байгаа мод хааяа хааяа тас тас дуугарах нь дөрөвдүгээр цахилгаан станцын тогоонууд дэлбэ дэлбэ үсэрч байгаа аятай сүртэй чангаар дуулдана.

Төмөр хоёр гарааш жийптэй боловч харуул манаа гаргадаггүй байлаа.

-Олон хавар нэгэндээ гэж үгтэй юмдаа манаач аваач гэж Өлзий гуйсан боловч:

-Дөрвөн хөлт нь бол төмөр идэх арай болоогүй. Харин хоёр хөлт нь бол Алмаз Төмөрийн машин гэж мэдэх юм бол тороос, борхоов хоёртоо гар хүрэхгүй гээд пар пар инээжээ. Өлзий орой бүхэн гарзны ам хааж байгаа нь энэ хэмээн бахины ам скоочдох ба өглөө бүр машин бүрэн байхыг үзээд үүнийхээ ач гэж тайлбарлана. Намрын нэгэн шөнө хулхи Жагай, Бадарч хоёр Төмрийн гараашид орж тавин сайхан жийпийг холбож чирээд гарч

одлоо. Тэд эхлээд Тамир голын эх их уулсын зүг рүү мөрийг нь төөрүүлж жаал яваад хойш эргэлээ. Тэгээд хүрээд ирэхийг нь хүлээн Жамбалын унаж явсан танкнаас мулталж авсан их бууг их идэшээр цэнэглээд жаал хүлээлээ.

Төмөр өглөө айжуухан босоод гараашдаа иртэл хоосон болжээ. Тэрбээр "Мөнгө нь ихдээд ирэхлээр татварын байцаагчаар оролдож байна уу? Миний гараас гараарай!" хэмээн хэлээд англи маягаар хүйтэн инээлээ. Тэгээд машиныхаа мөрийг хөөж Их Тамирыг өгсөв. Байн байн гүн бодолд орно.

-Тавин жийп чирсэн хүн энэ их хөвч өөд яагаад цоройлдог билээ? Аа! Муу ахыгаа хасах тавын харааны шилийг нь нуучихсан аятай төөрүүлэх нь үү! Троллейбус үзэх нүдгүй, тоорт даах шүдгүй болдог юм гэсэн ч ах нь ийм юманд хууртахгүй гээд жолоогоо эргүүлэн нэгэн хулгай замаар амдан одлоо.

Хулхи Жагай, Бадарч хоёр Төмөрийг бүгэн өдөр хүлээгээд ирсэнгүй ингээд Хулхи Жагай цааш явж Жамбалтай болзсон газраа очих, Бадарч эндээ үлдэж маргаашийн үд хүртэл Төмөрийг хүлээгээд ирэхгүй бол араас нь гүйцэж очихоор тохирлоо. Бадарч өдөржин хүлээгээд Төмөр ирсэнгүй. "Ер нь Төмөрийг цагдаа нараас илүү мөр хөөдөг гэж хэн хэлсэн юм бэ? Аягүй бол төөрүүлсэн мөрийг хөөж яваад их хөвчид онхолдож үхээ ч билүү?" гэж бодсоор нэг мэдэхэд нам унтжээ... Өглөө сэрээд харвал унаж явсан жаран ес нь алга. Ойр хавийг нэгжин хайвал машиныг нь нэлээд хол чирээд авааччихсан хоёр залуу тонож харагдав. Бадарч дарвийнхээ сэмхэн аваад дунд нь барин буудаж орхивол алдчихлаа. Буун дуунаас чимээ авсан хоёр залуу задалж байсан мотороо тэр чигээр нь дамжлан гүйсээр жалганд нуусан машин дээрээ очиж гялс асаан давхисаар хошуу тойрлоо. Бадарч:

-Муу хар зэв! Хулгайн анчдын муу хар царил хэмээн буугаа чулуудахад түүний дууг хадны цуурай элэглэн давтана. Бадарч машиныхаа сэгэн дээр ирвэл сарайж сэрийсэн төмөр араам нь "чамаас болж би ийм боллоо доо гэх" адил хэрзийнэ. Нөхөөстэй дотуур хаймрыг нь ажилгүй сэвчээнхтэй нь хаяад явсныг бодоход хулгайч нар бүх эд ангийг нь задлан их л тухтай үзсэн нь илэрхий

Бадарчийг ингэж мунгинаж байхад нөгөөх нь Архангай, Завханы нутгийн зааг дээр Жамбалтай болзсон газар луугаа яарч явлаа. Солонготын даваа дөнгөж өнгийтэл цаанаас нь хачин сүүпэр жийп тосч ирэхэд цонхоор нь нэг хүн заналтай мэндлэхийг харвал Төмөр дүрээрээ! Тэр:

-Муу хулхи! Загалмайлсан эцгийнхээ гарт ороо биз! хэмээн зуунги хэллээ.

-Еэ түрийвчээ гээмэр ... гэж Хулхи Жагай хараагаад тороосоо мулт татан шидээд эргэн давхилаа.

Төмөр машинуудыг нь Хулхи Жагай чирчихсэн явж байгааг хараад жигтэйхэн уур нь хүрч дайрчихаад явчихад манай замын цагдаагийнхан юу л олов гэж хэмээн заналаа. Төмөрийн 16 цилиндртэй жийп түүнийг хааш нь ч гаргасангүй. Яндангаар нь онгоцны бензиний цайвар утаа хаялсан жийп зүүн талаар нь түрүүлээд ороод ирэхийн алдад Жагай машиныхаа явуут дунд үсэрлээ. Энэ агшинд Төмөрын жийпний араас кашмир торгон шүхэр задарч огцом зогслоо. Төмөр мончоогоо барьсаар бууж ирэв.

-Төмөр ах минь өршөө! Би найман эхнэртэй далаад нялх хүүхэдтэй хүн. Тэднийг бодож амьд үлдээгээч гэж тэр гуйлаа

-Яасан их чалхтай эр вэ! Тэр жил чи намайг алчихлаа гэж бодсон биз? Мафийн хүзүү урт, машины кардаан богино гэж дуулсан уу, дүү хүү! гээд хэд цохилоо. Түүнийг хэд гүвшээд автал хачин дуугаран амаар нь цагаан хөөс сахрав. Тэр муужирчээ. Төмөр үүнд урам хугаран "салат идэж, соок ууж явсан солиг уу даа" гээд орхилоо. Бүх юм нам гүм. Тэнгэрт дунд мандлын долоон баллын үүл хөврөнө.

МАХН-ын төв байр. МАХН-ын удирдах зөвлөл хуралдаж байна. Тэнд мөн Бадарч ахлагч, Цамба лам, хулхи Жагай нар байна.

-Цонхоо битүүлсэн үү?

-Тэр шугамын араажавыг салга! Түүгээр дамжуулаад сонсож болдогийг мэдэхийн цаагуур мэддэг байж...

-Түрүүн доор хушууч Доодамба явж харагдсан. Өлгүүрт савхин цамцаа орхиогүй биз? гэсэн яриа хөөрөө болж байна.

Даш-Ёндон дарга:

-Энхмандах аа! энд юун үл таних хоёр гурван хүн байна гэж Бадарч, Цамба нар руу зааж хэллээ.

-Эд ардчилалд нүүргүй болж, түүнийг үзэн ядахаас өөр юмгүй болсон улс. Бадарчийг та санаж байгаа болов уу? Өнөө Намын хянан шалгах хороог мэдээллээр дардаг байсан нөхөр. Энэ Цамбыг би комсомолийн сургуульд явуулж байсан. Эвлэлийн тэргүүний ажилтан байсан хүн. Нэг хэсэг лам болж байгаад хамбынхаа эхнэртэй орооцолдоод тэндээсээ гарсан. Дээр нь бас бурхны соёл дэлгэрүүлэх төвд баар нээж тайчих урлаг суртчилж байгаад Далай ламд баригдаад бүр баларсан юм. Ер нь бол буцах замгүй болсон хүн! Пүрэв генералын хуурай хүү Жагайг ч та юу эс андах билээ. Хулхидсан, зээлсэн юмнаасаа манай намд өч төчнөөнийг л хандивласан шүү дээ гэж Энхмандах тэднийг танилцууллаа.

-Цаг ардчилсан болоод хүнийг итгэхэд хэцүү болж дээ гэж нэг нь хэлэв. Даш-Ёндон дарга тавин дөрвөн тоот эрхээ бугуйнаасаа зүүгээд бослоо. Уул нь ламын ёсны эрхи нь 108 тоотой байдаг боловч төв ёсны үзлийн дагуу эрхийг төв дундуур нь хувааж 54 болгосон юмсанжээ.

-Өнөөгийн байдлыг авч үзвэл ардчилал тахал мэт дэлгэрэх бололтой. Дарга нарын хүүхдийг дарга болгохгүй, шалгаруулалтад хэн түрүүлснийг нь авна гэх болж. ЗХУКН хөрөнгөө хураалгалаа. Бид ХКН-д их найдвар тавьж байгаа боловч тэд коммунизмаас урвасан нь өдөр ирэх тутам тодорхой болж байна. Ю.Цэдэнбалын хойд дүрийг тодруулахгүй гэдэг нь илэрхий болов. Бид хэдийгээр маршал цолыг нь сэргээсэн боловч шарилыг нь ухаад босгоод ирэхгүйгээс хойш хэрэг алга. Иймээс бид намрын ялаа шиг бээрсээр үхэх үү? Эсвэл дэлхийн хөдөлмөрчин ардуудын эрх ашиг, төв ёсны интернационализмын шар тугийн дор, даян дэлхийн шударга түмэнтэй эв санаагаа нэгтгэн энхрий хайрт Бурханов, Нагаржанаев, Зонков нарынхаа заасан замаар тэмцэж "Пролетарийн бослого" гарган "Төв хороо, төмөр утсан хашаа" хоёрын нэгийг сонгох уу? гэдэг дээрээ туллаа. Үүнийг догм сэтгэлгээтэй олонд сайтар танилцуулах хэрэгтэй гэж ирээд удаан ярилаа. Олон хүн бодол болон сууж байтал:

-Би таван халиавар, зургаан шувууны буу энэ их хэрэгт хандивлая. Дээр нь Элбэгдорж, Баабар, манай засаг дарга Эрдэнэ гурвыг эндээс гараад алъя! гэж Бадарч сэтгэл хөдлөн хэлэв.

Даш-Ёндон хүйтэн инээснээ:

-Хэрвээ тэр гурвыг ардчилал гэж нэрлэдэг байсан бол ч бид чамаас өмнө... гэснээ "Чи ч ийм юм олж ирнэ л дээ" гэсэн байртай Энхмандах руугаа хялалзав.

-Ардчилалтай тэмцэхдээ түүний уг үндсийг таслахын тулд учир мэдэхгүй мэргэн ардууд дээр тулгуурлан сурталчилгаа явуул. Ардчилснаас болж хоёр онгоц уналаа. Шуурга салхи ч хэрээс хэтэрлээ гэдгийг тэдэнд хэлж өг? Ганц хоёр шувууны буугаар их хэргийг бүтээхгүй. Бидэнд Кубын коммунистууд туслана гэсэн. Сая манай нэг хүн явж Фидель Кастротой уулзаад иржээ. Цаадах чинь бослого гаргаад түшиц газартай болоод ав, тэгмэгц бид Че Гавери гэдэг мэргэжлийн бослогочин явуулна гэж хэлүүлсэн байна. Бидэнд өөр их зэвсэг хэрэгтэй гэж дарга цааш нь хэллээ. Тэгтэл Энхмандах дарга босч:

-Алив Цамба чи өнөө Жамбалтай тохирсноо яриач!

-Жамбал гэж миний найз Ховдод цэргийн том дарга болсон юм. Тэр Афганаас хямдхан танк худалдаж аваад Баян-Өлгийгээр дайруулан хөлөөр нь оруулж ирнэ гэж ихээхэн доллар авсан хүн юм. Гэтэл над дээр Архангайд ирээд бид хоёр бааранд суусаар байгаад нөгөө мөнгийг нь барчихсан. Одоо тэгээд тэр өөрөөс нь авлагатай ардчилсан засгийг унагааж өгсөн хүнд нүдээ ухаад өгсөн ч буцахгүй болсон хүн. Сая надтай нийлж баахан АК зарсан.

Дараа нь хүмүүс ардчиллыг хэрхэн унагаах талаар баахан ярилцав.

Дарга тэдэнд:

-Саяхан манай энэ Энхмандах Англи орж Өндөр хаалгын хүн тавьдаг газарт байгаа Маркс багшийн шарилд мөргөөд иржээ. Буцах замдаа дэлхийн төв үзэлтнүүдийн их шүтээн Ленин багшийн шарилд мөргөх гэсэн боловч түүнийг ломбодоод хаясан байжээ. Гэвч төв үзлийн ёсоор юмыг төсөөлөн бодоод л орхивол гүйцэтгэсэнтэй адил болдог тул түүнийг Ленин багшид мөргөснөөр тооцох нь зүй юм. Бид ч засгийн эрх барьж байхдаа төв үзлийн ёсоор ард түмнийхээ амьдралыг сайжруулж байгаа мэтээр төсөөлж ирснийг та нар мэднэ. Манай удирдах зөвлөл ч энд зүгээр байсангүй, төв үзэлтнүүдийнхээ хийморь лундааг сэргээхээр "Төв ёсны үзэл ба пролетарийн бослого" гэдэг номыг намынхаа нас тоолон 70 гаруй удаа хурлаа. Одоо хамгийн гол нь эхлээд тэднийг дотроос нь хагалмаар байна. Энхмандах чи намаасаа гарч Ардчилсан холбоонд ороод тэдний дотор дарь булах цаг болсон. Маргааш өглөө Цагаан ордныхоо өмнө намын батлахаа сүр бараатай шатаа! Тэгээд Элбэгдорж дээр очиж дээгүүр албанд ор! Яаж дээгүүр албанд орохыг би ямар чамд заалтай нь биш! Тэгээд нам засгаа болон биднийг учир зүггүй хараан зүхэж олны зэвүүцлийг төрүүл! Дараа нь намайг алах ажиллагааг илээр зохиож намайг бууд!

-Чи буудахдаа муу шүү, гэнэ алдаж даргыг алчихав гэж нэг нь хэлэв.

-Тэгээд террор хийх гэлээ хэмээн цаадуулыг чинь чамтай цуг барьж хорьчихоод их үйл хэргийг эхэлмээр байна.

-Даргаа, хэрвээ бид ялахгүй бол би гэдэг амьтан шоронгийн хадаас болох нь байна шүү дээ. Би уул нь овоо зээл авчихсан юмсан.

-Хувьсгал ялсны маргааш есөн сайхан шарыг чинь тоо ёсоор нь өгөмц гэлээ.

Дараа нь тэд өөрсдийнхээ шавдан бататгахыг ерөөн мэгзэм уншив. Даш-Ёндон дарга мөнөөх төв дундуур нь тасалсан тал эрхиэ эргүүлэн "Централисты всех стран..." хэмээн теонор хоолойгоор хүнгэнүүлэв. Энхмандах англи явсан хүн гэсэндээ цаадуулынхаа мэдэхгүй хэлээр "сэнтраалисте ов оол кантрийз юнаит" хэмээн бувгнав. Дөрвөн мөчиндөө нэг нэг эрх ороосноос гадна хүзүүнээсээ арваад эрх хэлхсэн Цамба чавганцынх шиг урт эрүүгээ улам урагш шаамийлган байж, сайхан цангинасан хоолойгоор "Ум ма ни..." хэмээн эхэлсэн боловч хэдийнэ? Дулмаа хүүхнийг бараагүй нь бодогдон уур нь гэнэт хүрч "муу пи..-г ална даа... мааний бадма хум... п..!" хэмээн цааш уншив.